БАЛЧИР ХҮҮХДИЙН АНГИЙН ГАРЫН АВЛАГА

Бяцхан үрсээ болгоогтун



Бяцхан үрсээ болгоогтун

БАЛЧИР ХҮҮХДИЙН АНГИЙН ГАРЫН АВЛАГА

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.
Юта муж, Солт Лейк хот

Бид та бүхнээс энэхүү гарын авлагын талаарх санал хүсэлтийг хүлээн авахдаа баяртай байх болно. Curriculum Development, 50 East North Temple Street, Room 2404, Salt Lake City, UT 84150-3200 USA хаягаар санал хүсэлтээ илгээнэ үү.
cur-development@ldschurch.org

Нэр, хаяг, цахим шуудангийн хаяг, тойрог, гадасны нэрээ бичнэ үү. Мөн гарын авлагын нэрийг бичихээ бүү мартаарай. Энэхүү гарын авлагын сайн тал болон сайжруулах шаардлагатай зүйлүүдийн талаарх санал сэтгэгдлээ илгээнэ үү.

© 2008 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи хэл дээрх зөвшөөрөл: 8/04

Орчуулгын эрх: 4/11
Nursery Manual: Behold Your Little Ones -ын орчуулга
Mongolian
37108 363

ГАРЧИГ

Оршил 1

Эцэг эхчүүдэд хандсан захиа 7

Хичээлүүд

1. Би Бурханы хүүхэд 8
2. Тэнгэрлэг Эцэгт надад зориулсан төлөвлөгөө байдаг 12
3. Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна 16
4. Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ надад хайртай 20
5. Есүс Христ бусдыг хэрхэн хайрлахыг бидэнд харуулсан 24
6. Ариун Сүнс надад тусалдаг 28
7. Есүс Христ миний төлөө дэлхийг бүтээсэн 32
8. Ням гараг бол Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг дурсан санах өдөр билээ 36
9. Би Тэнгэрлэг Эцэгийнхтэй адил бие махбодтой 40
10. Би өөрийн биеийг арчлах болно 44
11. Би гэр бүлдээ хайртай 48
12. Би гэр бүлтэйгээ хамт залбирч чадна 52
13. Миний гэр бүл үүрд хамтдаа байж чадна 56
14. Би дуулгавартай дагана 60
15. Би таархалтай байх болно 64
16. Би “Намайг уучлаарай” гэж хэлэх болно 68
17. Би хуваалцах болно 72
18. Би бусдыг хайрлах болно 76
19. Би баяр хөөртэй байж чадна 80
20. Би хүндэтгэл бишрэлтэй байх болно 84
21. Иосеф Смит, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан 88
22. Мормоны ном надад Есүс Христийн тухай заадаг 92
23. Би судруудад хайртай 96
24. Би бошиглогчийг дагах болно 100
25. Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг 104
26. Би баптисм хүртэж мөн гишүүнээр батлагдах болно 108
27. Ариун ёслол нь Есүс Христийн талаар бодоход надад тусалдаг 112
28. Тэнгэрлэг Эцэг санваараар дамжуулан намайг адисалдаг 116

Тусгай хичээлүүд

29. Есүс Христ амилсан (Христийн Амилалтын баяр) 120
30. Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү (Христийн мэндэлсний баяр) 124

Богино хичээл: Балчир хүүхдийн ангид тавтай морилно уу 128

Богино хичээл: Төрсөн өдрийн мэнд 129

Үйл ажиллагааны индекс 130

Үзүүлэнгийн индекс 131

ОРШИЛ

БАЛЧИР ХҮҮХДИЙН АНГИ

Зорилго Балчир хүүхдийн ангийн зорилго бол хүүхдүүдийг Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнээс суралцаж мөн түүний дагуу амьдрахад нь туслах явдал юм. Балчир хүүхдийн анги нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн талаарх ойлголтоо хөгжүүлэн, Тэднийг илүү ихээр хайрлаж, Сүмийн нөхцөл байдалд эерэг сэтгэгдэлтэй байх мөн өөрсдийн үнэ цэнийг мэддэг болоход нь балчир насны хүүхдүүдэд туслах ёстой.

Эцэг эхчүүдэд хандсан захиа Хүүхдийг балчир хүүхдийн ангид орохоос хэдэн долоо хоногийн өмнө Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн тухайн хүүхдийн эцэг эхэд 7-р хуудсанд байгаа эцэг эхчүүдэд хандсан захианы хуулбарыг өгөх ёстой.

Балчир хүүхдийн ангийн удирдагчид Балчир хүүхдийн анги бүрт доод тал нь хоёр хүн (балчир хүүхдийн ангийн удирдагч мөн удирдагчийн туслах) дуудагдах ёстой. Балчир хүүхдийн ангийн удирдагчид нь эхнэр нөхөр эсвэл дан эмэгтэй/эрэгтэй хүмүүс байх хэрэгтэй. Балчир хүүхдийн ангийн удирдагчид нь хүүхдүүдийн аюулгүй байдал болон сайн сайхныг хангахын тулд тэдэнтэй энэхүү ангид байх хугацаанд хамтран ажиллах ёстой.

Ахуй орчин Балчир хүүхдийн ангид хүүхдүүдэд аюулгүй, зохион байгуулалттай, хайраар дүүрэн орчныг бүрдүүлэх ёстой. Өрөө нь цэвэрхэн, өөдрөг бөгөөд халуун дулаан уур амьсгал төрүүлэм мөн боломжийн хэрээр ариун цэврийн өрөөтэй ойр байх хэрэгтэй. Ангид тоглуулах тоглоомууд нь цэвэрхэн, аюулгүй, эвдэрч хэмхрээгүй байна. Авирах тоглоомууд хэрэглэхгүй.

Цагийн хуваарь Балчир хүүхдийн анги нь ерөнхийдөө Хүүхдийн хэсгийн хуваарьт цагийн туршид үргэлжилдэг. Энэхүү цаг нь хичээл, зууш, дууны болон тоглох цаг гэх мэт хэд хэдэн хэсэгт хуваагдана.

Эдгээр хэсгүүдийн дараалал, үргэлжлэх хугацааг шийдэхдээ хүүхдүүдийнхээ хэрэгцээг анхаарна. Хүүхдүүд тогтмол хийдэг зүйлийг сайн сурдаг тул долоо хоног бүр адил дараалаар хийгээрэй.

- *Хичээл:* Хичээлийн цагийг залбирлаар эхэлж, дуусгаж байх ба ерөнхийдөө хүүхдүүдийн нэг нь (шаардлагатай бол балчир хүүхдийн ангийн удирдагчдын нэгний тусламжтайгаар) залбирах хэрэгтэй. Хичээлийн цагийн туршид энэхүү гарын авлагад багтсан хичээлүүдийн аль нэг үйл ажиллагааг эсвэл бүх үйл ажиллагааг сонго. Балчир хүүхдийн ангид эдгээр үйл ажиллагаануудыг давтан хийж болно. *Хүүхдийн дуу,* болон Сүмийн сэтгүүлүүд гэх мэт Сүмээс хэвлэн гаргасан материалуудыг ашиглана.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Балчир насны хүүхдүүдийн зан чанарын талаарх мэдээллийг, *Teaching, No Greater Call: A Resource for Gospel Teaching* (1999), 110–111 номоос үзнэ үү.

Хуваарь: Балчир хүүхдийн ангийн хуваарийг төлөвлөхдөө хүүхдүүдийнхээ хэрэгцээ, онцлогийг анхаарч үз. Хэр удаан суусны дараа тэд босож хөдлөх хэрэгтэй вэ? Тэд хэзээ өлсөж, хөнгөн зууш идэх хэрэгтэй вэ? Чимээгүй үйл ажиллагаа нь тэднийг хичээлд бэлтгэхэд туслах уу? Бага насны хүүхдүүдийн олонх нь анхаарлаа богино хугацаанд төвлөрүүлэх чадвартай байдгийг сана. Хүүхдүүд хийж буй зүйлээсээ үйдсан, тогтворгүй байх мөн өөр бусад зан авир гаргаж буй эсэхийг ажиглаж байгаарай.

- *Тоглох:* Хүүхдүүдэд ном, тоглоом болон эвлүүлдэг тоглоомоор чөлөөтэй тоглох боломж олго. Хүүхдүүд тоглоомоор дамжуулан суралцдаг. Тоглоомын цаг дуусах үед тоглоомуудаа байранд нь буцааж тавихад нь хүүхдүүдэд тусал.
- *Зууш:* Хүүхдэд өгөхөд хялбар мөн эрүүл мэндэд нь тустай хөнгөн зууш өгөх хэрэгтэй. Хүүхдэдээ идүүлмээргүй хүнсний зүйл байгаа эсэхийг эцэг эхээс нь асуу. Зууш идэхийн өмнө хүүхдүүдэд гараа угаахад нь туслан хоолоо адислуулахаар залбирахыг хүс. Зуушны мөнгийг Хүүхдийн хэсгийн төсвөөс гаргах ёстой.
- *Дуу хөгжим:* Дуу дуулж, хөгжмийн энгийн зэмсэг тоглож эсвэл дууны аялгуунд хөдөлж алх ("Балчир хүүхдийн анги дахь дуу хөгжим"-ийг үзнэ үү, х. 4). Балчир хүүхдийн ангийн энэ хэсэг нь хичээлийн цагийн нэг хэсэг эсвэл дуу хөгжимд зориулсан тусгай хэсэг байж болно.

Багш нар балчир хүүхдийн ангийн хичээл дуусахад хүүхдүүдийг зөвхөн эцэг эх эсвэл ах эгч нь ирж, авч байхад анхаарах хэрэгтэй. Эцэг эхийнх нь зөвшөөрөлгүйгээр хүүхдүүдийг өөр хэн нэгэнд өгч явуулж болохгүй.

Шилжилт Хүүхдүүдийг хичээлийн нэг хэсгээс нөгөөд шилжихэд туслах хэвшлийг тогтмол бий болго. Жишээлбэл: та нар "Хөгжилтэй" (Хүүхдийн дууны ном) гэх мэт дууг дуулж "Тоглоомоо авах нь хөгжилтэй" эсвэл "Гараа угаах нь хөгжилтэй" гэх мэт үгсийг оруулан дуулж болно.

ЭНЭХҮҮ ГАРЫН АВЛАГЫН ХИЧЭЭЛҮҮДИЙН ТАЛААР

Энэхүү гарын авлагын хичээлүүдийн зорилго нь балчир насны хүүхдүүдийг Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний үндсэн сургаалуудыг сурахад нь туслах явдал юм. Эдгээр хичээлүүдийг заахаар бэлтгэх явцдаа Сүнсний нөлөөллийг эрэлхийлэн удирдамжийн төлөө залбир. (*Teaching, No Greater Call,* 97–99 үзнэ үү). Та нар эдгээр хичээлийг ямар ч дараалаар зааж болох ба нэг хичээлийг долоо хоног дараалан зааж болно. Балчир хүүхдийн ангийн хичээлийн явцад та нар хүүхдүүдийн сонирхол болон хэрэгцээн дээр үндэслэн нэг хичээлийг хоёр удаа зааж болно.

Балчир хүүхдийн ангид зөвхөн Сүмээс хэвлэн гаргасан сургалтын материалуудыг ашигла. Энэхүү гарын авлагад санал болгосон үйл ажиллагаануудаас гадна та нар Сүмийн сэтгүүлүүдээс тоглоом, зураг, дуу, түүхүүдийг ашиглаж болно.

Та нар хүүхдүүдэд заахдаа судраа ашигла. Судраас түүх ярьж өгөхдөө хичээл дээр судраа нээн түүх өгүүлж буй хуудсыг заа. Энэ нь та нарын зааж байгаа зүйл судраас ирж байгаа юм байна гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах болно. Тэдэнд судруудад талархаж мөн хүндэтгэлтэй хандаж байхыг заа. Та нар өөрийн гэсэн сударгүй бол бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө нэг хувийг хэрхэн авч болох талаар асуу.

Эдгээр хичээлүүдийг заах явцдаа хүүхдүүдийн гэр орон болон гэр бүлийн нөхцөл байдалд болгоомжтой ханд. Хичээл дээр хүүхдүүдийн эцэг эх болон гэр бүлийнх нь талаар ярилцах тохиолдолд өрх толгойлсон эцэг эсвэл эх, өвөө эмээ эсвэл гэр бүлийн өөр гишүүд нь өсгөж буй хүүхдүүдийн сэтгэл санааг ойлгож хандаарай.

Түүнчлэн балчир хүүхдийн ангид байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааг ойлгон мэдрэмжтэй ханд. Хүүхдүүдийн хийж чадахгүй зүйл дээр нь биш харин тэдний *хийж чадах* зүйл дээр анхаарлаа төвлөрүүл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэрхэн заах талаар нэмэлт мэдээллийг *Teaching, No Greater Call* 38–39 номоос үзнэ үү.

Хичээлийн гол хэсгүүдийг дор тайлбарлан үзүүлсэн:

Багшид зориулсан танилцуулга Хичээл бүрийн эхэнд заах гэж байгаа сургаалын талаарх товч танилцуулга, судрын эшлэлүүдийг оруулсан. Энэхүү танилцуулга болон бусад холбогдох судруудыг уншин мөн тунгаан бодох нь хүүхдүүдэд уг сургаалыг Сүнсээр заахад өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Тоглох: Балчир насны олон хүүхэд тоглоом, бусад зүйлсээ хуваалцаж тоглохдоо сэтгэл санааны болон харьцааны хувьд бэлэн биш байдаг. Хэрвээ тэд хуваалцахыг хүсэхгүй байвал бүү албад.

Үйл ажиллагаа: Үйл ажиллагааны үеэр хүүхдүүд хэрхэн оролцож байгааг анхаар. Та нар балчир хүүхдийн ангийнхаа хүүхдүүдийн чадвар болон хэрэгцээг мэднэ. Үйл ажиллагаануудыг шаардлагатай үед өөрчилж болно. (*Teaching, No Greater Call,* 33–34-ийг үзнэ үү.).

Үйл ажиллагааны хайрцаг: Та нар балчир хүүхдийн ангидаа үйл ажиллагааны хайрцаг байлгаж болно. Энэ хайрцгандаа үйл ажиллагаануудад зориулан хийсэн эвлүүлдэг тоглоом, зураг, хүүхэлдэй, будах хуудасны хуулбар гэх мэт зүйлүүдийг хадгалж болно. Та нар эдгээр зүйлсийг балчир хүүхдийн ангийн хичээлийн туршид аль ч үед хэрэглэх боломжтой.

бэлтгэхэд тань туслах болно. Энэхүү танилцуулгыг балчир хүүхдийн ангийн хүүхдүүдэд уншиж өгөхөд зориулаагүй юм.

Сурах үйл ажиллагаа

Сурах үйл ажиллагааны гол зорилго нь хүүхдүүдэд дараах боломжуудыг олгосноор сайн мэдээг заах явдал юм. Үүнд:

- Сургаалын талаар сонсох.
- Сургаалтай холбоотой зураг үзэх.
- Сургаалын талаар дуу дуулах (эсвэл дуу сонсох).
- Сургаалтай холбоотой үйл хөдлөл хийх.
- Сургаалын талаар үг хэллэг хэрэглэх.

Балчир хүүхдийн ангид хүүхдүүдийг өөртэйгөө ойрхон суулгаад сурах үйл ажиллагаанд оролцуулах нэг газрыг тусгайлан бэлд. Энэ нь шалан дээр тавьсан хөнжил буюу дэвсгэр эсвэл тойрог болгон зассан сандлууд байж болно. Хүүхдүүдийн нүдний харалдаа, ойрхон байхын тулд суу эсвэл өвдөглөж суугаарай. (Тайлбар: Өвдөглөх, шалан дээр суух мөн тонгойход тохиромжтой байдлаар хувцасла.)

Цугларах үйл ажиллагаа: Хичээл бүрийг хүүхдүүдийг ангидаа цуглуулан Сүмээс зөвшөөрөгдсөн дуу эсвэл бусад үйл ажиллагаагаар эхэл. Долоо хоног бүр цугларахдаа нэг ижил үйл ажиллагааг явуулж байвал хүүхдүүд уг үйл ажиллагааг хичээлийн цаг эхэлж байгаагийн дохио болгон ойлгодог болох ба энэ нь хичээлдээ бэлэн болоход тэдэнд туслах болно. Цугларах үйл ажиллагаа нь алгаа хэмнэлтэйгээр таших, хүүхдүүдийг өөртэйгөө хамт алгаа ташихыг уриалах гэх мэт энгийн үйлдлүүд байж болно. Энгийн мөн долоо хоног бүр байнга давтан ашиглаж байвал Сүмээс зөвшөөрсөн аль ч дуу эсвэл үйл ажиллагааг сонгож болно.

Цугларах үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаануудыг жишээ болгон харууллаа:

- Хүүхдүүдийн дуртай "Би Бурханы хүүхэд" (*Хүүхдийн дууны ном*) эсвэл "Бие биеэ хайрла"(Хүүхдийн дууны ном) гэх мэт дуунуудыг дуул.
- "Хэрвээ сайхан амьдарч байвал"(Хүүхдийн дууны ном) дууг дуулахдаа дараах үгсийг орлуул:
  Хэрвээ та нар хичээлд бэлэн бол ирээд суу.
  Хэрвээ та нар хичээлд бэлэн бол ирээд суу.
  Хэрвээ та нар хичээлд бэлэн бол энэ нь адислал болох нь гарцаагүй.
  Хэрвээ та нар хичээлд бэлэн бол ирээд суу.
- Дараах шүлэгт үйл ажиллагааг хийж хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхэд урь:
  Би өнөөдөр сүмдээ ирсэндээ баяртай байна, *(Хуруунуудаараа сүмийн шовх дээврийг дүрслэн харуул)*
  Есүсийн тухай сурахаар, дуулахаар, *(гараараа амаа тойруулан барь)* мөн залбирахаар. *(гараа цээжиндээ тэвэр)*

Нэмэлт үйл ажиллагаануд

Хичээл бүрт хүсвэл нэмэлт болгон ашиглаж болохуйц хоёроос дөрвөн үйл ажиллагааг оруулсан. Эдгээр үйл ажиллагаануудыг балчир хүүхдийн ангийн хичээлийн бусад үеэр бас хэрэглэж болно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Цугларах: Та нартай хамт сууж байгаа хүүхдүүдийг магтаарай. Хүүхдүүдийн зарим нь суухыг хүсэхгүй байвал тэднийг бүү албад, харин тэдэнд өөр үйл ажиллагааг санал болго. Балчир хүүхдийн ангийн нэг багш нь зааж байх үед нөгөө багш нь хүүхдүүдийн анхаарлыг түүн рүү хандуулахад тусалж болно.

Дуунууд: Цугларах үйл ажиллагаанд зориулж дуу дуулж эсвэл үйл ажиллагаа хийвэл хэд хэдэн удаа давтаж, давтан хийх бүртээ илүү намуухнаар хийгээрэй.

Давтаж хийх нь хүүхдүүдэд сурахад тусалдаг. Хүүхдүүд ялангуяа сурах эсвэл нэмэлт үйл ажиллагааг хийх дуртай байвал балчир хүүхдийн хичээлийн бусад цагийн үеэр болон дараагийн долоо хоногуудад давтан хий.

Эдгээрийн ихэнх үйл ажиллагаанд нэмэлт бэлтгэл шаардагддаг. Хэрэв эдгээр үйл ажиллагаануудад шаардлагатай материалууд олдохгүй бол өөр ижил төстэй зүйлсээр орлуулж болно. Эдгээр материалуудыг худалдан авах мөнгийг Хүүхдийн хэсгийн төсвөөс гаргана.

Үзүүлэх материалууд Хичээл бүрт зориулан өнгөт зураг болон зураасан зургийн хоёр хуудас үзүүлэх материалыг багтаасан. Тэдгээр нь хичээл дээр заагдаж байгаа зарчмуудыг харуулж батжуулах зорилготой юм. Үзүүлэх материалуудыг хэрхэн хэрэглэх талаарх саналуудыг хичээлд багтаасан.

Заахад туслах зөвлөмж Хуудас бүрийн баруун талд хичээлээ амжилттай заахад тань туслах санаануудыг бичсэн. Эдгээр саналуудын зарим нь тодорхой үйл ажиллагааны талаар боловч ихэнхдээ бага насны хүүхдүүдэд заах аль ч үед хэрэгжүүлж болох зарчмуудыг багтаасан юм.

БАЛЧИР ХҮҮХДИЙН АНГИ ДАХЬ ДУУ ХӨГЖИМ

Балчир насны хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн талаар сурч авахад бэлэн мөн сурах хүсэлтэй байдаг бөгөөд дуу хөгжим нь тэдэнд сурахад туслах болно. Дуу хөгжим нь Сүнсийг урьдаг ба балчир хүүхдийн ангид байр хөөртэй байх газар улмаар халуун дулаан, хайрын орчинг бий болгодог.

Дуулах авьяасгүй гэж бүү санаа зовоорой. Хүүхдүүд та нарын дуулах чадварыг анхаарахгүй, харин үгсийг тань чагнан, нүүр царайны илэрхийллийг харж мөн дууны аялгууг нь таашаан сонсох болно.

Дуу хөгжим ашиглах аргууд Дуу хөгжим нь балчир хүүхдийн ангид олон зорилгыг гүйцэлдүүлдэг билээ. Та нар үүнийг:

- Хүүхдүүдийг тавтай морилохыг урихад. Жишээлбэл: хүүхдүүд балчир хүүхдийн ангид орж ирэх үед та нар хөгжим намуухнаар дуугаргаж болно.
- Сайн мэдээний зарчмуудыг заахад. Энэхүү гарын авлагын хичээлүүдийн ихэнх нь тухайн сэдэвтэй холбоотой дуунуудыг санал болгодог.
- Хүүхдүүдийг өөр үйл ажиллагааг эхлэхэд бэлтгэхэд нь туслахад жишээлбэл: хичээлийн цагт бэлтгэн хүндэтгэл бишрэлтэй уур амьсгалыг бий болгоход.
- Хүүхдүүдэд хөдөлж мөн өөрсдөд нь таатай байх боломж өгөхөд.
- Хүүхдийн хэсэгт шилжин орсны дараа дуулах дуунуудтай хүүхдүүдийг танил болгоход.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Үзүүлэх материалууд: Хүүхдүүд сурч болохын тулд зураг болон будах зурган дээрээс өөрсдийн зааж байгаа зарчимтай холбоотой зүйлүүдийг зааж өг.

Дуу хөгжим: Балчир хүүхдийн ангийн хөгжмийн хичээлээр та нарт төгөлдөр хуур эсвэл хөгжим тоглуулагч байх шаардлагагүй. Хэрвээ та нар тэднийг ердөө л өөрсдийгөө тойруулан суулгаад дуулж байвал хүүхдүүд их дуртай байх болно. Дууныхаа үгсийг цээжлээд хүүхдүүдээс харцаа салгахгүй дуулаарай.

Дуу хөгжмийн сургалтын материалууд: Балчир хүүхдийн ангид дуу хөгжмийн сургалтын материалуудыг хийх хайрцаг бэлдэхэд анхаар. Үүнд хүүхдүүдийн дуртай дуу болон үйл ажиллагааны жагсаалт, дуулах үедээ хүүхдүүдийн гартаа барьж болох энгийн зураг эсвэл хөгжмийн зэмсгийг хийж болно.

Хүүхдүүдэд хичээлд оролцоход нь туслах

Хүүхдүүдэд дуу заахдаа богино мөрийг цөөн удаа дуулан дараа нь тэдгээрийг өөртэйгөө хамт дуулахыг урь. Хичээл зүтгэлийнх нь төлөө тэднийг магтаарай. Эхний үед тэд дууны ганц хоёр үгийг дуулж, бүр бага хүүхдүүд нь огт дуулахгүй ч байж магадгүй боловч тэд сурч мөн та нарын дуулахыг сонсох дуртай байх болно. Тэд дууны үгсийн дагуу хөл гараа хөдөлгөх үйлдлийг хийхдээ дуртай байх болно. Та нар дууг давтан дуулж байвал аажимдаа тэд дууны үгийг сурч та нартай хамт дуулж эхлэх болно.

Бусад сургалтын материалууд

Энэхүү гарын авлагын хичээлүүдэд зарим дууны үгийг багтаасан. Та нар мөн:

- *Хүүхдийн дууны ном* болон Хүүхдийн хэсгийн дууны бичлэгийг хэрэглэж болно. Энгийн, үг нь давтагдсан дуунууд ялангуяа балчир насны хүүхдүүдэд тохиромжтой байдаг. Та нар дууны үгсийн дагуу энгийн үйл хөдлөл нэмж болно.
- Сүмийн дуу хөгжмийн вебсайт нь www.lds.org/churchmusic юм. Та нар тэндээс *Хүүхдийн дууны ном* болон сүмийн дуулал номын дуунуудын аялгууг сонсож болно.
- Хүүхдийн хэсгийн дууны удирдагчид тусламж

ТУЛГАРЧ БОЛОХ БЭРХШЭЭЛҮҮД БА ШИЙДЭХ АРГА ЗАМУУД

Балчир хүүхдийн ангид түгээмэл тохиолдож болох бэрхшээлүүд болон тэдгээрийг шийдвэрлэж болох санаануудыг дор харууллаа. Бүхий л нөхцөл байдалд, зөв сайхан аашилж байгаа хүүхдийг чин сэтгэлээсээ магтаарай. Хүүхдүүдийг албадан үгэндээ оруулах нь зан ааштай холбоотой асуудлыг шийдэх арга биш юм. Балчир хүүхдийн ангид хүүхэд бүрт халуун дулаан, хайрыг мэдрэх сэтгэгдэл төрөх нь чухал гэдгийг сана.

АСУУДАЛ	ШИЙДВЭРЛЭХ АРГУУД
Эцэг эх нь хүүхдээ балчир хүүхдийн ангид авч ирэн үлдээх үед хүүхэд уйлбал	Хүүхдээ тайвширтал ангид хамт үлдэхийг эцэг эхээс хүс. Балчир хүүхдийн ангид болж байгаа үйл ажиллагааг хүүхдэд сонирхуулж мөн түүнд оролцохыг урь.
Хүүхэд та нараас эсвэл бусад хүүхдүүдээс айсан мэт байх мөн анги дотроо нааш цааш холхих, хэнтэй ч ярихгүй байгаа тохиолдолд	Тэвчээртэй бай; уг хүүхдийг оролц гэж бүү албад. Тэдэнд та нарыг, бусад хүүхдүүдийг мөн орчноо таньж мэдэх хугацаа өг. Уг хүүхдийг үе үе тайвшруулж үйл ажиллагаанд оролцохыг урихаа үргэлжлүүлээрэй. Уг хүүхдэд балчир хүүхдийн анги нь очих дуртай, сайхан сэтгэгдэл төрүүлэм гэдгийг ойлгоход нь тусал.
Хүүхэд өөрөөс тань зууран наалдаад, анхаарлыг тань байнга өөртөө татахыг хүсдэг	Бага хүүхдүүдэд халуун дулаан мэдрэмж мөн анхаарал хэрэгтэй байдаг. Хүүхэдтэй эелдэг зөөлнөөр ярьж харилцах нь тэднийг ихэвчлэн сэтгэл хангалуун байлгадаг. Тэгээд уг хүүхдийг балчир хүүхдийн ангийн үйл ажилллагаанд оролцоход нь дэмжиж урам өгөөрэй.
Хүүхэд хичээлийн үеэр чимээгүй суухгүй, сонсохгүй бол. Тэрхүү хүүхэд бусад хүүхдүүдийг уурлуулан эсвэл анхаарлыг нь сарниулах тохиолдолд	Балчир хүүхдийн ангийн нэг удирдагч нь уг хүүхдийн анхаарлыг үйл ажиллагаанд хандуулж нөгөө удирдагч нь хичээлээ үргэлжлүүлж болно. Хүүхдийн гарт ямар нэг юм бариулах нь тэр хүүхдийг хичээлд идэвхтэй оролцоход нь туслах болно. Аюулгүй, үр дүнтэй хичээлийг бусад хүүхдүүдэд заахын тулд нэг багш нь уг хүүхэдтэй хамт тусдаа суух шаардлагатай болж магадгүй. Хүүхдүүдийг дэмжиж харилцахаа үргэлж сана.

АСУУДАЛ	ШИЙДВЭРЛЭХ АРГУУД
Үйл ажиллагаа дуусахаас өмнө хүүхэд босоод явах тохиолдол байдаг	Хүүхэд бүрийн хэрэгцээ, сонирхол, анхаарал төвлөрүүлэх чадварт анхааралтай мөн мэдрэмжтэй ханд. Тогтворгүйтэх байдал ажиглагдвал хүүхдийн хэрэгцээ, онцлогт тохирох өөр үйл ажиллагаа хий. Нэг багшийг үйл ажиллагаа явуулж байх хооронд нөгөө багш нь сонирхол буурсан хүүхдийг урьж мөн урамшуулж болно. Хүүхдийг аливаа нэг үйл ажиллагаанд оролцуулах гэж албадаж болохгүй.
Хүүхдүүд тоглоомоо булаацалдах тохиолдол гардаг	Бага насны хүүхдүүд хуваалцахыг сайн мэддэггүй. Та нар асуудлыг шийдэх эсвэл тэднийг бие биенээ өвтгөхөөс сэргийлэхийн тулд дундуур нь оролцох шаардлагатай болно. Уг тоглоомоор хамтдаа тоглож болох арга замыг санал болгож эсвэл тэдний анхаарлыг өөр тоглоом, үйл ажиллагаанд хандуул. Хүүхэд бүрт хүрэлцэх хангалттай тоглоомтой байхад анхаар. Хүүхдүүдийг эвтэй найртай тоглож байх үед нь магтаарай.
Хүүхэд тоглоомоо шидэж цохин эсвэл савчих, ширүүн тоглох тохиолдол гардаг	Та нар энэ байдлыг зогсоох хэрэгтэй. Балчир хүүхдийн анги нь хүүхдүүдэд аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх ёстой. Уг хүүхдийг тийм байдалтай тоглож болохгүй гэдгийг зөөлнөөр тайлбарлаж тухайн хүүхдийн анхаарлыг өөр тоглоомонд хандуул. Зөв аашилж байгаа хүүхдийг магт.
Хүүхэд уйлж, уйлагнаж эхэлдэг. Тайвшруулахыг хичээх үед тэр “Би танд дургүй” эсвэл “Та миний ээж биш” гэж хэлэн танаас цааш зүтгэвэл	Хүүхдийн анхаарлыг балчир хүүхдийн ангид байгаа эд зүйлс эсвэл тоглоом, ном руу хандуул. Энэ нь уг хүүхдийг тайвшрахад тусалж магад. Огт тайвшрахгүй байвал уг хүүхдийг аав ээж дээр нь аваачиж өгөөрэй.

ХАЙРТ ЭЦЭГ ЭХЧҮҮД ЭЭ,

Бид таны хүүхдийг балчир хүүхдийн ангид орохыг тэсэн ядан хүлээж байна! Хүүхдэдээ таатай сэтгэгдлийг төрүүлэхийн тулд та нарын хийж болох дараах хэдэн зүйлс байна:

- Хүүхдэдээ балчир хүүхдийн ангид анх орохын өмнөх долоо хоногт энэ ангийн талаарх сайхан зүйлсийг хэлж өгөөрэй.
- Балчир хүүхдийн ангид юу хийдэг талаар хүүхдэдээ ярьж өг. Юу хүсэн хүлээж болохыг мэдэхэд нь тэдэнд тусал.
- Хүүхдээ балчир хүүхдийн ангид аваачиж өгөхийн өмнө шаардлагатай бол бие засуулж, хооллох хэрэгтэй. Живхийг нь солих шаардлагатай хүүхдийг эцэг эхэд нь аваачиж өгнө.
- Хүүхдийнхээ хоолны харшил гэх мэт эрүүл мэндийн талаар анхаарвал зохих зүйлийг балчир хүүхдийн ангийн удирдагчдад мэдэгд.
- Хүүхэд тань айж эмээж байвал хүүхэдтэйгээ хамт балчир хүүхдийн ангид үлдээрэй.
- Балчир хүүхдийн ангийн хичээлийн үеэр хаана байхаа энэ ангийн удирдагчдад мэдэгд.
- Хүүхдэдээ та буцаж ирнэ гэдгээ хэл.
- Балчир хүүхдийн ангийн цаг дуусахад даруйхан ирж хүүхдээ аваарай. Аав ээж, ах эгчээс нь өөр хүн ирж хүүхдийг тань авах тохиолдолд уг хүнд зөвшөөрөл өгсөн гэдгээ балчир хүүхдийн ангийн удирдагчдад мэдэгд.
- Балчир хүүхдийн ангид заагдсан зүйлийг гэртээ бататган хэрэгжүүл.
- Боломжтой бол хүүхдийнхээ мөн гэр бүлийнхээ зургийг өгөөрэй.

Хүүхэд тань өвчтэй буюу дараах шинж тэмдгүүд илэрч байвал балчир хүүхдийн ангид битгий өгөөрэй:

- Халуунтай байвал
- Нус нь гоожиж байвал
- Ханиаж байвал
- Хэвийн бус ааш зан гаргаж байвал
- Бөөлжиж байвал
- Гүйлгэж байвал
- Юм туурсан байвал
- Нүднээс нь нуух гоожиж байвал
- Үс нь бөөстсөн бол
- Сүүлийн 48 цагийн туршид антибиотикоор эмчлүүлсэн өвчин эсвэл үрэвсэлтэй байвал
- Ямар нэгэн өвчин нь халдвартай үедээ байвал:

  Салхин цэцэг (нэг долоо хоног)
  Улаан бурхан (тууралт нь алга болтол)
  Улаан эсэргэнэ (тууралт нь алга болтол)
  Гахайн хавдар (хавдар нь буутал, ихэнхдээ нэг долоо хоног)
  Арьсны бижрүү

Харшлын улмаас таны хүүхдийн нус нь гоожиж, ханиаж эсвэл юм туурсан бол балчир хүүхдийн ангийн удирдагчдад хүүхдийн тань шинж тэмдэг халдвартай биш гэдгийг мэдэгд.

Асуулт эсвэл санал хүсэлт байвал балчир хүүхдийн ангийн удирдагчидтай чөлөөтэй холбоо бариарай:

Балчир хүүхдийн ангийн удирдагч	Утасны дугаар
Балчир хүүхдийн ангийн удирдагч	Утасны дугаар

1 БИ БУРХАНЫ ХҮҮХЭД

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Бид нэг бүрчлэн тэнгэрлэг эцэг эхийн хайртай охид, хөвгүүд юм. Бид төрөхөөсөө өмнө тэдэнтэй хамт амьдарч байсан. Тэнгэрлэг Эцэг маань бидний хүн нэг бүрийг мэддэг мөн бидэнд хайртай. (Дуулал 82:6; Үйлс 17:28–29; Еврей 12:9-ийг үзнэ үү)

БЭЛТГЭЛ

- Судраа авчрах. Дуулал 82:6 болон Мосе 1:4-ийг олоход хялбар болгож тэмдэглэ.
- Энэхүү гарын авлагын 99-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу "Би Бурханы хүүхэд" *(Хүүхдийн дууны ном)* дууны эхний бадгийг дуул эсвэл давтан хэл:

Би Бурханы хүүхэд тул,
Энэ эх дэлхийд намайг.

Хүүхдүүдийг өөрсөдтэйгөө хамт дуулахыг урин 2-3 удаа давт.

Судар Дэлхий дээр тэднийг хайрладаг аав ээж нар байдаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэднийг мэдэж мөн хайрладаг Тэнгэрлэг Эцэг тэдэнд байдаг гэдгийг бас хэлээрэй. Библи судраас Дуулал 82:6 –г нээж мөн "Та нар бүгдээрээ [Бурханы] хүүхдүүд юм" гэж унш.

Судрын түүх 99-р хуудсан дээр байгаа Мосегийн зургийг үзүүл (энэ хуудасны бусад зургуудыг таглах нь хүүхдүүдийг Мосегийн зураг дээр анхаарлаа төвлөрүүлэхэд туслах юм). Мосе олон жилийн өмнө амьдарч байсан агуу бошиглогч байсан гэдгийг тайлбарла. Мосе уул руу залбирахаар гарсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг ууланд авирч байгаа дүр үзүүлэхийг хүсээд тэднийг залбирч байгаа мэт гараа урдаа тэвэр хэмээн хэл. Агуу Их Үнэт Сувд судрын Мосе 1:4-ийг нээж "Бурхан, Мосед, "Болгоогтун, чи миний хүү билээ" хэмээв" гэж унш. Мосе Бурханы хүүхэд болохоо мэдсэн гэдгийг тайлбарла.

Давтан хийх үйл ажиллагаа Нэг хүүхдийг ангийнхаа өмнө, хажуудаа зогсохыг урь.
"Энэ бол [хүүхдийн нэр]" гэж хэл.
Хүүхдүүдээс уг хүүхдийн нэрийг давтан хэлэхийг хүс.
"[Хүүхдийн нэр] бол Бурханы хүүхэд" гэж хэл.
"[Хүүхдийн нэр] бол Бурханы хүүхэд" гэж давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Балчир хүүхдийн ангийн хүүхэд бүр дээр энэхүү үйл ажиллагааг давтан хий. Балчир хүүхдийн анги нь олон хүүхэдтэй бол хүүхдүүдийг хоёр хоёроор нь зогсоож дээрх үйл ажиллагаагаа явуулж зарцуулах цагаа богиносгож болно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуунууд: Сайн мэдээний зарчмуудыг зааж мөн Сүнсийг урихын тулд дуу хөгжим ашигла. Хүүхдүүдийн зарим нь та нартай хамт дуулж, магадгүй олонх нь дуулахыг тань ажиглах байх. Тэд дуу сонсож сурдаг ба өөрсдөө дуулахгүй ч сонсох дуртай байдаг.

Нэрс: Балчир хүүхдийн ангийн хүүхдүүд өөрсдийн нэрийг сонсох мөн хичээлийн нэг хэсэг болж оролцохдоо дуртай байдаг. Хүүхдүүдийнхээ нэрийг мэдэж мөн оролцож байгааг нь магтан тэдэнд хайртайгаа илэрхийлээрэй.

Зураг 10–р хуудсанд байгаа зургийг үзүүлээд зурган дээрх хүүхдийг заан "Энэ хүн Бурханы хүүхэд мөн үү?" гэж асуу. Толгой дохин тийм гэж хариул. Зурган дээр байгаа хүүхэд бүр дээр ийн давтан хий. Тэгээд өөр рүүгээ заан "Би Бурханы хүүхэд мөн үү?" гэж асуу. Толгой дохин тийм гэж хариул. *Хүн бүр* Бурханы хүүхэд гэдгийг мөн Тэр биднийг мэддэг мөн хайрладаг гэдгийг тодотгон хэлээрэй.

Дүгнэлт Бид бүгд Бурханы хүүхдүүд мөн. Тэр биднийг мэддэг мөн хайрладаг талаар гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Цаасан самбар дээрх үйл ажиллагаа:* Хүүхдийнхээ зургийг балчир хүүхдийн ангид авч ирэхийг эцэг эхчүүдээс хүс (хүүхэд нь балчир хүүхдийн ангид анх ороход тэд зураг өгсөн байж болно; 7-р хуудсыг үзнэ үү). Цаасан самбарын дээд талд "Би Бурханы хүүхэд" гэж бич. Хүүхдүүдийн зургийг тавих хангалттай зай үлдээ.

Зурагт үйл ажиллагаанд: Хуудас 11 дэх зургийг хүүхэд бүрт зориулан хувилуул.

Шүлэгт үйл ажиллагаа Хүүхдүүдийг босгож зогсоон өөртэйгөө хамт дараах шүлэгт үйл ажиллагааг хийхийг хүс:

Хэрвээ чи зөндөө, зөндөө өндөр бол, *(гараа дээш өргөн сунга)*
Тэнгэрлэг Эцэг чамайг мэдэж мөн хайрладаг.
Хэрвээ чи жижигхэн, жижигхэн намхан бол, *(бөхийн суу)*
Тэнгэрлэг Эцэг чамайг мэдэж мөн хайрладаг.
Өндөр, *(дээш сунга)*
Намхан, *(бөхийн суу)*
Өндөр, *(дээш сунга)*
Намхан, *(бөхийн суу)*
Тэнгэрлэг Эцэг бид бүгдийг мэдэж мөн хайрладаг.

Цаасан самбар Бэлтгэсэн цаасан самбар дээрээ хүүхдүүдийн зургийг наа. Цаасан самбар дээрх гарчгийг хүүхдүүдэд уншиж өгөөд бид Бурханы хүүхдүүд гэдгийг тэдэнд сануул. Долоо хоног бүр цаасан самбарыг ил тавьж мөн балчир хүүхдийн ангид шинээр хүүхдүүд элсэн орох бүрт энэхүү самбар дээрээ зургийг нь нэмж тогтоо.

Зураг 11-р хуудасны зургийн хуулбарыг хүүхэд бүрт өг. Нүүрний өөр өөр хэсэг (нүд, ам гэх мэт) рүү заахыг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүд хүсэж байвал зургаа будаж болно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Залбирал: Хүүхдэд залбирал хэлэхэд туслах хэрэгтэй бол богино, энгийн үгсийг давтан хэлүүл. Том хүүхдүүд нь өөрсдийн үгээр залбирал хэлж чадаж магадгүй.

Хувилж олшруулах: Хувилагч байхгүй тохиолдолд үзүүлэн дээр цэвэр цаас тавиад хуулбарлаж болно.

Будах: Хүүхэд бүр будах дуртай байдаггүй. Зарим нь хуудсан дээр ганц хоёр зураас ч зурж магадгүй. Хичээлүүдэд зураг ашигладгийн гол зорилго нь хүүхдүүд хичээлийнхээ талаар харах зүйлтэй байж тэднийг гартаа барин мөн гэртээ авч харих явдал юм. Тэд зургийг чадамгай будаж байгаа эсэх нь чухал биш юм.



Би Бурханы хүүхэд



Би Бурханы хүүхэд

2 ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГТ НАДАД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ БАЙДАГ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Бид төрөхөөсөө өмнө сүнсэн байдалдаа Тэнгэрлэг Эцэгтэй амьдарч байсан. Түүнтэй адил болж Түүний дэргэд буцаж очихын тулд Тэнгэрлэг Эцэг бидэнд энэ дэлхий дээр ирж бие махбодыг хүлээн авч болох төлөвлөгөөг бэлдсэн. Энэхүү төлөвлөгөө нь Есүс Христийн Цагаатгал болон бидний дуулгавартай байдлаар дамжуулан гүйцэлдэх боломжтой юм. Есүс Христ бидний Аврагч байхаар сонгогдсон. (Абрахам 3:24–27; Итгэлийн Тунхаг 1:3-ыг үзнэ үү.)

БЭЛТГЭЛ

Энэхүү гарын авлагын 98-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Түүх дуулах “Би Бурханы хүүхэд” *(Хүүхдийн дууны ном)* дууг ашиглан авралын төлөвлөгөөний зарим үндсэн тодорхойлолтыг заа. Дараах тоймыг санал болгож байна:

Бид төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамтдаа амьдарч байсан гэдгийг хүүхдүүдэд хэлж өг.

Дуул эсвэл хэл (өөртэйгөө хамт хийхийг хүүхдүүдээс хүс):

Би Бурханы хүүхэд тул,
Энэ эх дэлхийд намайг

Тэнгэрлэг Эцэгт бидэнд зориулсан төлөвлөгөө байдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Тэр биднийг дэлхий дээр ирж амьдрах болно гэж хэлсэн. Бид маш их баярлан дуу алдацгаасан. “Уухай” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс.

14-р хуудсан дээрх гэр бүлийн зургийг үзүүл. Бид хайртай гэр бүлтэйгээ амьдрахаар дэлхий дээр ирсэн гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. Хүүхдүүдийг гараа зөрүүлэн өөрсдийгөө тэвэр гэж хэл.

Дуул эсвэл хэл:

Их энэрэнгүй эх эцгийг
Дэлхийн хамт заяав Тэр.

Тэнгэрлэг Эцэг биднийг энэ дэлхийд байх үедээ баяр хөөртэй байж мөн Түүний тушаалуудыг дагахыг биднээс хүсдэг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Дуул эсвэл хэл:

Надад замаа олоход туслан,
хөтлөн удирдаач.

98-р хуудсан дээрх Есүс Христийн зургийг үзүүл. Биднийг Өөр дээрээ буцаж ирэхэд туслуулахаар Есүс Христийг Тэнгэрлэг Эцэг сонгосон хэмээн хүүхдүүдэд хэл. Есүсийн тусламжтайгаар хэрвээ бид зарлигуудыг дагавал Тэнгэрлэг Эцэг болон гэр бүлтэйгээ мөнхөд хамтдаа амьдарч чадна хэмээн тайлбарла.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлтгэл: Балчир хүүхдийн ангийн хичээл эхлэхээс өмнө зураг, үзүүлэн мөн хичээлд шаардлагатай өөр бусад материалуудыг бэлд. Энэ нь анхаарлаа хүүхдүүд дээр төвлөрүүлэхэд тань туслах болно.

Сурах үйл ажиллагаа: Хүүхдүүдийг хичээлд оролцуулан анхаарал тавихад нь туслахын тулд тэднийг тойрог болгон суулгаад өөрөө энэхүү тойргийнхоо голд суу. Боломжтой бол тэдний нүд рүү эгцлэн харж болохын тулд өвдөглөж эсвэл доош суу. Зургуудаа тэдэнд ойрхон бариарай.

Дуул эсвэл хэл:

Түүнтэй амьдрахын тул би
Юу хийх ёстойг заагаач.

Дуулах үедээ зургуудыг үзүүлэн дууг бүхэлд нь дуулаарай:

Би Бурханы хүүхэд тул
Энэ эх дэлхийд намайг
Их энэрэнгүй эх эцгийг *(14 –р хуудсан дээрх гэр бүлийн зургийг үзүүл)*
Дэлхийн хамт заяав Тэр.

Надад замаа олоход туслан,
Хөтлөн удирдаач.
Түүнтэй амьдрахын тул би *(98 –р хуудсан дээрх Есүсийн зургийг үзүүл)*
Юу хийх ёстойг заагаач.

Дүгнэлт Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан төлөвлөгөөний талаар гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Ууттай тоглоом тоглоход:* 15-р хуудсан дээр байгаа зургуудыг хувилж мөн хайчил. Зургуудаа дотор нь хийж нуух жижигхэн уут эсвэл даавуу авчир.

Будах үйл ажиллагаанд: 15-р хуудсыг хүүхэд бүрт хувилж өг. Зураг болон үгтэй зурвас цаасыг хайчил. Хүүхдүүдэд өлгөдөг зураг хийж өгөхийн тулд наадаг цаас эсвэл утас авчир.

Ууттай тоглоом Зургуудыг уутанд хий. Хүүхдээр уутнаас нэг зураг сонгуул. Зургийн дор бичсэн зүйлийг унш эсвэл дуулж өг. Хүүхдүүдээс өөртэйгөө хамт дуулахыг эсвэл давтан хэлэхийг хүс. Ээлжлэхийг хүссэн хүүхэд бүрийг хийтэл үйл ажиллагааг үргэлжлүүлэн давтан хий.

Будах 15-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуулж гэр рүү нь өгч явуулбал тэд балчир хүүхдийн ангид сурсан зүйлээ эцэг эхдээ үзүүлэх болно. Хэрвээ цаг хангалттай байвал баруун талд харуулсан хайчилбарын дагуу хүүхдүүдэд зориулан өлгөдөг зураг хийхийн тулд утас, наадаг цаас хэрэглэ.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Сургалтын материалууд: Балчир хүүхдийн ангид зөвхөн Сүмээс хэвлэсэн материалуудыг ашигла (*Teaching, No Greater Call,* 105 -ыг үзнэ үү). Хүүхдүүдээр хийлгэх нэмэлт зүйл хэрэгтэй байвал энэхүү гарын авлагаас эсвэл Сүмийн сэтгүүлүүдээс өөр түүх, тоглоом, хүүхэлдэй эсвэл будах үйл ажиллагааг сонго. Эдгээр үйл ажиллагаануудыг хүссэнээрээ давтан хийж мөн нэг хичээлийг хоёр эсвэл гурван долоо хоног дараалан зааж болно.

Нэмэлт үйл ажиллагаанууд нь та нар хүссэн үедээ хичээлдээ нэмэлт болгон ашиглахаар зориулагдсан билээ. Шаардлагатай материалуудыг олох боломжгүй тохиолдолд ижил төстэй материалаар орлуулж болно.

Будах: Хүүхдүүдийг будаж байх хоорондхичээл дээр заагдсан зарчмуудыг дахин хэл. Зураг дээрх тодорхой зүйлс рүү заан хүүхдүүдэд будаж байгаа зүйлсийг нь тайлбарлаж өг. Зураг дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

Тэнгэрлэг Эцэгт надад зориулсан төлөвлөгөө байдаг.



Би Бурханы хүүхэд тул энэ эх дэлхийд намайг

Их энэрэнгүй эх эцгийг дэлхийн хамт заяав Тэр.



Түүнтэй амьдрахын тул би юу хийх ёстойг заагаач.

3 БИ ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГТЭЭ ХАНДАН ЗАЛБИРЧ ЧАДНА

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Залбирлаар дамжуулан бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярьж чаддаг. Бид Түүнд хайртайгаа хэлж, өгсөн адислалуудынх нь төлөө Түүнд талархаж мөн тусламж хэрэгтэй бусдын болон өөрсдийнхөө төлөө залбирдаг. Бид залбирлаа Есүс Христийн нэрээр төгсгөдөг. Биднийг дэлхий дээр байх хугацаанд өгөгдсөн хамгийн агуу адислалуудын нэг нь залбирал юм. (Матай 6:9–13; Алма 34:18–27; 3 Нифай 18:19–21-ийг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- Бидний талархаж байдаг зүйлсийг төлөөлсөн (хувцас, хоол, судар гэх мэт) цөөн хэдэн жижиг зүйлс эсвэл зургуудыг том уутанд хийж авчир. Уутан дээр “Бид Танд талархаж байна” гэж бичнэ. Өөр нэг уутанд залбиралдаа гуйн хүсэж болох зүйлсийг төлөөлсөн (аз жаргалтай гэр бүл, эрүүл бие, хайр гэх мэт) зүйлс эсвэл зургийг хийж авчир. Уутан дээр “Биднийг адислаач” гэж бичнэ.
- Энэхүү гарын авлагын 106-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зургууд Есүсийн хүүхэд байхдаа залбирч байсан зургийг үзүүл (хуудас 18). Энэ нь Есүсийн хүүхэд байхдаа залбирч байгаа зураг гэдгийг хүүхдүүдэд хэл. Залбирч байгаа хүүхдийн зургийг үзүүл (хуудас 18). Бид залбирахдаа Тэнгэрлэг Эцэгтэй ярьдаг ба залбирлаа “Тэнгэрлэг Эцэг минь” гэж эхэлдэг гэдгийг тайлбарлаж өг. “Тэнгэрлэг Эцэг минь” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Дараа нь бид Түүнд, бидэнд өгсөн адислалуудын төлөө талархдаг хэмээн хүүхдүүдэд хэлж өг. “Бид Танд талархаж байна” бичигтэй уутнаас нэг зүйлийг хүүхдээр сонгуулна. Тэгээд “[хүүхдийн сонгосон зүйлийн нэрийг хэлэн] –ий төлөө бид Танд талархаж байна” гэж хэлээрэй. “Бид Танд талархаж байна” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс. Уутанд байгаа бүх зүйлийг сонгож дуустал энэхүү үйл ажиллагааг давтан хийнэ. Тэгээд дараа нь бид Тэнгэрлэг Эцэгээс адислал гуйдаг гэдгийг хүүхдүүдэд хэлж,“Биднийг адислаач” бичигтэй уутнаас сонгож үйл ажиллагааг давтан хийнэ. “Биднийг адислаач” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс.

106 –р хуудсан дээрх Есүсийн зургийг үзүүл. “Есүс Христийн нэрээр, амен” гэж хэлэн бид залбирлаа дуусгадаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Үүнийг өөртэйгөө хамт хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хүүхдүүдийг өөртэйгөө хамт хэлэхийг хүс:

“Хайрт Тэнгэрлэг Эцэг минь” гэж хэлснээр би эхэлдэг *(нэг хуруугаа өргө— шүлэгт үйл ажиллагааны туршид хуруунуудаа гозойлгосон хэвээр байлгана)*

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Залбирал: Залбирахад бэлтгэн хүндэтгэл бишрэлтэй байхад нь хүүхдүүдэд туслахад та нар их зүйлийг хийж чадна. Жишээлбэл: чимээгүй суун, гараа урдаа зөрүүлэхийг тэдэнд сануул. Мөн түүнчлэн та тэдэнд залбирлын хэлийг заах өгч *Танд, Та, Таны* болон *Таных* гэх мэт үгсийг *чи* болон *чиний гэдэг үгсийн оронд хэрэглэхийг заах өгч болно.* Тэднийг өөрсдийн үгээр залбирч сурах хүртэл залбирах үед нь та нар тэдэнд тусалж болно.

Хариулт хүсэх: Дуу хоолойны өнгө, нүдний харц, ааш аяг нь заах үед их чухал байдаг. Тэднээс хүсэх үедээ хүүхдүүд рүү харан урамшуулж “Та нар “Бид Танд талархдаг” гэж хэлж чадах уу?” гэх мэтээр хэлж болно. Хүүхдүүдийг оролцож байгаагийнх нь төлөө магтаарай.

Түүний илгээдэг адислалуудынх нь төлөө би түүнд талархдаг; *(хоёр дахь хуруугаа өргөнө)*
Тэгээд бид өөрт хэрэгтэй байгаа зүйлийг түүнээс гуйдаг, *(гурав дахь хуруугаа өргөнө)*
Есүс Христийн нэрээр, амен. *(дөрөв дэх хуруугаа өргөнө)*
["Би итгэлээр залбирдаг" (Хүүхдийн дууны ном)]

Дүгнэлт Тэд залбирахдаа Тэнгэрлэг Эцэгтэй ярьж байдаг гэдгийг хүүхдүүдэд сануул. Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсдог талаарх гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Эвхдэг номын үйл ажиллагаанд:* 19-р хуудасны зургийг хувилуул. Хүсвэл будаарай. Шулуун зураасын дагуу хайчилж тасархай зураасын дагуу нугалан эвхдэг ном хийнэ.
Судрын түүх хэлэхэд: Инос 1:1–8-ыг уншаад энэ түүхийг хүүхдүүдэд товчхон ярьж өгөхөд бэлд. Мормоны Ном авчир. Инос 1 –ийг олоход хялбар болгож тэмдэглэ.
Будах үйл ажиллагаанд: 19 –р хуудасны зургийг хүүхэд бүрт будахад зориулан хувилж өгнө. Балчир хүүхдийн ангийн хичээл эхлэхээс өмнө үзүүлэнгийн хувилсан зургийг шулуун зураасын дагуу хайчил.

Эвхдэг ном Энэ удаад бэлтгэсэн, эвхдэг номоо ашиглан залбирахдаа бид юу гэж хэлдэг талаар 16-р хуудасны заавр ыг давтан хэлж өг. Залбирлын хэсэг бүрийг тайлбарлахдаа тохирох хуудсыг нь өөрөө өргөх эсвэл хуудсыг өргөхийг нэг хүүхдээс хүс. 16-р хуудасны шүлэгт үйл ажиллагааг хийхдээ энэхүү эвхдэг номоо бас ашиглаж болно. Дараагийн долоо хоногуудад балчир хүүхдийн ангид энэхүү эвхдэг номоо ашиглахын тулд хадгал.



Судрын түүх Мормоны Номоос Инос 1-ийг нээж Иносын залбирсан тухай түүхийг хүүхдүүдэд ярьж өг. Доорх жишээг үзнэ үү:
Нэгэн өдөр Инос ой мод руу *(хүүхдүүдийг гараа сунган мод болон зогс гэж хэл)* ан агнахаар явсан *(нум сум харваж байгаа дүр үзүүл гэж тэдэнд хэл)*. Тэр ойд байхдаа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсан *(хүүхдүүдийг залбирч байгаа мэт өвдөглөж суу гэж хэлээд, тэднийг өвдөглөж суух хооронд түүхийг дуустал нь ярьж өг)*. Тэнгэрлэг Эцэг түүний залбиралд хариулсан бөгөөд Инос их баяртай байсан. Тэнгэрлэг Эцэг өөрийг нь адисална гэдгийг тэр мэдэж байлаа.
"Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна" гэж хэл. Нэг удаадаа цөөн үгээр хамт хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Будах 19-р хуудасны зургийн хуулбарыг хүүхэд бүрт будуулахаар өг. Будаж дууссаных нь дараа тасархай зураасын дагуу эвх.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Гэрчлэл: Гэрчлэлээ энгийн, товч тодорхой байдлаар хуваалц; жишээлбэл: "Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсдог гэдгийг би мэднэ" хэмээн хуваалц.

Том хүүхдүүд: Ангийн жаахан хүүхдүүдэд залбирахыг заахдаа том хүүхдүүдээр туслуулах талаар бодож үзээрэй. Энэ нь заасан зүйлээ батжуулах сайн арга юм.

Түүхүүд: Түүхийн үйл явдлыг жүжиглэн тогловол хүүхдүүд түүнийг илүү сайн ойлгож санадаг. Түүх жүжиглэн тоглохдоо Бурхан Эцэгийг төлөөлөх ёсгүй гэдгийг сана. Есүс Христийг түүний мэндэлсэн талаарх түүхийг өгүүлэхдээ төлөөлөн дүрсэлж болно. *Teaching, No Greater Call,* 165–166-г үзнэ үү.

Будах: Хүүхдүүдийг будаж байх хооронд хичээл дээр заасан зарчмуудаа давтан хэлж өгөөрэй. Зургууд дээрх тодорхой зүйлсийг зааж юу будаж байгааг нь хүүхдүүдэд тайлбарлаж өг. Зураг дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

Би эхлээд “Тэнгэрлэг Эцэг минь” гэж хэлдэг.



Би адислалуудад нь талархаж байгаагаа Түүнд хэлдэг.

Би Түүнээс адислалуудыг гуйдаг.

Есүс Христийн нэрээр, амен.

Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна

4 ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ БОЛОН ЕСҮС ХРИСТ НАДАД ХАЙРТАЙ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хүн бүрийг төгс хайраар хайрладаг. Тэд биднийг энэ дэлхийд ирэхээс өмнө хайрладаг байсан; Тэд одоо ч биднийг хайрласаар байдаг; мөн биднийг хайрлах Тэдний хайр хэзээ ч өөрчлөгдөхгүй. Аврагч энэ дэлхий дээр тохинуулж байхдаа ялангуяа бяцхан хүүхдүүдэд агуу хайрыг үзүүлсэн (Матай 18:5, 10; Марк 10:13–16; 3 Нифай 17:11–24-ийг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- 3 Нифай 17:11–12, 21–24-ийг уншаад хүүхдүүдэд энэ түүхийг товч хэлж өгөхөд бэлд.
- Мормоны Ном авчир.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3–р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Сургаалын заавар Та нар хүүхдүүдэд хайртайгаа хэлж мөн эцэг эх, ах эгч, өвөө эмээ гэх мэт тэдэнд хайртай өөр хүмүүсийн талаар товчхон ярь. Тэгээд тэдэнд хэнээс ч илүү хайртай байдаг хоёр өөр хүн нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хэмээн тайлбарла. Хүүхдүүдэд "Тэнгэрлэг Эцэг болон Есүс тэдний хэн гэдгийг мэддэг. Тэд чиний нэрийг мэддэг мөн Тэд чамд хайртай" гэж хэлээрэй. Хүүхдүүдийн нэг рүү заан "Тэнгэрлэг Эцэг болон Есүс [хүүхдийн нэр]-д хайртай" гэж хэл. Хүүхэд бүр дээр ийн давтан хий.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хэлж мөн хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Тэнгэрлэг Эцэг намайг мэддэг *(өөр рүүгээ заа)*
Мөн миний юу хийх дуртайг мэддэг.
Тэр миний нэрийг мөн хаана амьдардгийг мэддэг. *(хуруунуудаа нийлүүлэн байшингийн дээврийн хэлбэр гарга)*
Тэр надад бас хайртайг би мэднэ. *(өөрийгөө тэвэр)*

Судрын түүх 22-р хуудасны зургийг үзүүл. Есүс бяцхан хүүхдүүдэд хайртай гэдгийг бид судруудаас сурч авдаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Мормоны Номоо нээгээд Нифайчуудын хүүхдүүдийг Есүс Христ адисалж байгаа түүхийг товчхон ярьж өг. (3 Нифай 17:11–12, 21–24). Дараах жишээг үзнэ үү:

Есүс хүмүүст зааж байсан. *(Зурган дээрх Есүс рүү заа)* Тэр Өөр дээрээ бяцхан хүүхдүүдийг авчрахыг хүссэн *(зурган дээр байгаа хүүхдүүдийг заа)* Тэд Түүнийг тойрон газар сууж мөн Есүс өвдөглөж суугаад залбирсан *(хүүхдүүдийг өвдөглөөд, толгойгоо тонгойлгохыг хүс)*. Тэгээд Тэр хүүхэд бүрийг нэг нэгээр нь адисалсан. Тэр бяцхан хүүхдүүдэд хайртай учраас ийн үйлдсэн юм *(хүүхдүүдийг өөрсдийгөө тэвэрэхийг хүс)*.

Дуу "Би Аврагчийн хайрыг мэдэрдэг" (Хүүхдийн дууны ном) дууг дуулж эсвэл дараах үгсийг давтаж хэл. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг урь.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Танилцуулга: "Багшид зориулсан танилцуулга" хэсэгт жагсаасан судруудаас суралцах нь хичээл бэлдэх явцдаа Сүнсийг урих сайн арга зам юм. (*Teaching, No Greater Call,* 14).

Үйл хөдлөл: Дууны үгтэй эсвэл шүлэгт үйл ажиллагаатай холбоотой үйл хөдлөлийн талаар хэлж өгөхийн тулд хугацаа шаардагдаж магад. Жишээлбэл: та нар хуруунуудынхаа үзүүрийг нийлүүлэх юм бол (энэ шүлэгт үйл ажиллагааны 3-р мөр) тэд байшингийн дээвэр шиг хэлбэр гаргаж байгаа бөгөөд энэ үйл хөдлөл нь "миний амьдардаг" гэдэг үгийг хамтран дагалдах юм гэдгийг та тэдэнд тайлбарлаж өгч болно.

Дуу: Дуу эсвэл үйл ажиллагааны шүлэг нь балчир хүүхдийн ангийн хүүхдүүдийн хувьд дэндүү урт байвал зөвхөн хэсгийг нь ашигла.

Би Аврагчийн хайрыг, *(гараа зүрхэн дээрээ тавь)*
Эргэн тойрон дахь бүх дэлхий дээр мэдэрдэг. *(гараа хажуу тал руугаа дэлгэ) . . .*
Би Аврагчийн хайрыг, *(гараа зүрхэн дээрээ тавь)*
Надад элбэгээр өгөх Түүний хайрыг мэдэрдэг. *(өөр рүүгээ заа)*

Дүгнэлт Тэнгэрлэг Эцэг болон Есүс тэдний хүн бүрт хайртай гэдэг гэрчлэлээсээ хүүхдүүдтэй хуваалцаарай. "Тэнгэрлэг Эцэг болон Есүс надад хайртай" гэдэг үгсийг цөөн үгээр нь таслан хүүхдүүдээр давтан хэлүүл.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Тольтой үйл ажиллагаанд:* Хүүхдүүд нүүрээ харж болохуйц хэмжээтэй жижиг толь авчир.
Зураг үйл ажиллагаанд: Тэнгэрлэг Эцэгийн бидэнд адисалсан гэр бүл, гэр орон, мод, судар гэх мэт дөрөв, таван зүйлийн зургийг авчир. Та нар Сүмийн сэтгүүлүүд дээрх зураг, энэхүү гарын авлагын зургийн хуулбар эсвэл өөрийн зурсан энгийн зургийг ашиглаж болно.
Будах үйл ажиллагаанд: Хүүхэд бүрт зориулан (нэг хүүхдэд нэг дугариг) 23-р хуудасны зургийг хувилуулж, хайчилна. Хүзүүний зүүлт хийхийн тулд дугуй дүрс бүрийн дээд талаар утас сүвлэнэ.

Тольтой үйл ажиллагаа Хүүхдүүдийг тойрог болгон суулгана. Тойргийн хүрээн дотор толио барин явж хүүхэд бүрийн нүүрийг толинд харуулна. Хүүхэд бүрийг толинд харж байхад нэрийг нь асуу (уг хүүхэд нь нэрээ хэлж чадах бол). Тэгээд "Тэнгэрлэг Эцэг болон Есүс [хүүхдийн нэр]-д хайртай" гэж хэлнэ.

Зургууд Авчирсан зургуудаа өрөөний энд тэнд байрлуул. Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бидэнд хайртай учраас Тэд бидэнд олон адислал өгсөн гэдгийг хүүхдүүдэд хэлнэ. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт зургуудын нэг рүү нь очин, уг зураг ямар адислалыг төлөөлж байгааг нэрлэхэд нь тусал. Уг адислалыг илэрхийлэх үйл хөдлөлийг хийхийг тэднээс хүс (судар уншиж байгаа мэт дүр үзүүлэх, мод болж зогсох гэх мэт). Бусад зургуудын талаар үүний адил давтан хийж ярилц.

Шүлэгт үйл ажиллагаа 9-р хуудасны шүлэгт үйл ажиллагааг хийнэ.

Будах Тэдэнд зориулан бэлтгэсэн хүзүүний зүүлтүүдийг хүүхдүүдээр будуулна. Зураг дээрх үгсийг тэдэнд уншиж өгнө.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Гэрчлэл: Гэрчлэлээ хуваалцах нь Сүнсийг урьдаг. Гэрчлэлээ энгийнээр, товч тодорхой хуваалц; жишээлбэл: "Тэнгэрлэг Эцэг болон Есүс бидэнд хайртай гэдгийг би мэднэ."

Жаахан хүүхдүүд: Жаахан хүүхдүүдийг анхаарал тавьж мөн үйл ажиллагаанд оролцоход нь туслахын тулд балчир хүүхдийн ангийн нэг удирдагчийг хичээлээ заах байх хооронд нөгөө удирдагч нь тэдэнд тусалж анхаарал тавина.

Өмнөх хичээлүүд: Хүүхдүүдээр хийлгэх нэмэлт зүйл хэрэгтэй байвал өмнөх хичээлүүдийн үйл ажиллагааануудаас сонго. Хичээлүүдийг бүхлээр нь эсвэл нэг хэсгийг нь нэгээс илүү удаа заах болно. Давтаж хийхэд хүүхдүүд дуртай байдаг бөгөөд энэ нь сайн давтлага болдог.

Тэнгэрлэг Эцэг болон Есус Христ надад хайртай

Тэнгэрлэг Эцэг болон Есус Христ надад хайртай

5 ЕСҮС ХРИСТ БУСДЫГ ХЭРХЭН ХАЙРЛАХЫГ БИДЭНД ХАРУУЛСАН

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад сүнслэг байдлаараа бэлтгэхийн тулд дараах зүйлийг уншиж мөн тунгаан бод:

Есүс Христ найрсаг байдал болон хайрын төгс төгөлдөр жишээг харуулсан. Энэ дэлхий дээр тохинуулж байхдаа Есүс ядууст, өвчтөнүүдэд мөн ядарч зовсон хүмүүст үйлчилж адисласнаараа бусдыг хайрлах Өөрийн хайрыг үзүүлсэн. Тэрээр дагалдагчдадаа "Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол Миний тушаал" гэж хэлсэн (Иохан 15:12; мөн түүнчлэн Иохан 13:34–35; Моронай 7:46–48-ыг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- Энэхүү гарын авлагын 22-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.
- Судраа авчир.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу Есүс Христ энэ дэлхий дээр амьдарч байхдаа бидэнд бусдыг хайрла хэмээн заасан; Тэрээр өөрийн жишээгээрээ бидэнд үүнийг хэрхэн хийхийг харуулсан гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. "Би Есүс шиг байхыг хичээнэ" (Хүүхдийн дууны ном) дууны дахилтыг дуулж эсвэл үгсийг нь давтан доорх үйлдлийг хийнэ. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг урь.

"Есүс биднийг хайрласны адил бие биеэ хайрла. *(өөрийгөө тэврэн, хоёр тал руугаа эргэ)*

Бүх зүйлээрээ эелдэг байхыг хичээ. *(толгойгоороо дээш доош дохино)*

Бодол, үйлсдээ зөөлөн, эелдэг бай, *(өөрийгөө тэврэн, хоёр тал руугаа эргэ)*

Эдгээр зүйлсийг Есүс заасан. *(толгойгоороо дээш доош дохино)*

Судрын түүхүүд Хүүхдүүдэд судраа харуул. Есүс хэрхэн хайрлахыг үзүүлсэн талаар бид судраас сурдаг гэдгийг тэдэнд хэлж өг. Дараах түүхүүдийг товчхон ярьж өг:

Түүх 1 (27-р хуудасны зургийг харуул): Есүсийн заахыг сонсохоор олон хүн ирсэн. Тэр хүмүүс тэнд маш удаан байсан бөгөөд ихэд өлсөж эхэлсэн *(хүүхдүүдээс өлсөж байгаа дүр үзүүлэхийг хүс)*. Бүх хүмүүсийг хооллох нэг жижигхэн талх, загас л тэдэнд байсан. Есүс хоолыг адислаад Өөрийн дагалдагчдадаа хандан хүмүүст тарааж өгнө үү хэмээн хэлсэн. Хүн бүр хангалттай идсэн ба зөндөө их хоол үлдсэн байсан *(хүүхдүүдээс идэж байгаа дүр үзүүлэхийг хүс)*. (Матай 14:13–21-ийг үзнэ үү.)

Хүүхдүүдтэй хамт цөөн үгээр "Есүс бусдыг хэрхэн хайрлахыг бидэнд үзүүлсэн" гэж хэл.

Түүх 2 (26-р хуудасны зургийг үзүүл): Нэг өдөр Есүс хараагүй сохор хүнийг харжээ *(хүүхдүүдээс гараараа нүдээ таглахыг хүс)*. Есүс уг хүнийг харж чаддаг болгохын тулд түүнийг адисалсан *(хүүхдүүдийг гараа нүдэн дээрээсээ авахыг хүс)*. (Иохан 9:1–12-ыг үзнэ үү.)

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуунууд: Хүүхдүүд урьд өмнө нь харж эсвэл сонсож байсан зүйлүүддээ дуртай байдаг. Балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед энэхүү эсвэл өмнөх хичээлүүдэд дуулсан дуут дуулах буюу шүлэгт үйл ажиллагааг хийгээрэй. Ийм давтан хийх нь тэдэнд уг дуут сурахад мөн та нарын заасан сайн мэдээний зарчмыг санахад туслах болно.

Түүхүүд: Түүх ярьж өгөхийн өмнө өөрөө мэддэг болохын тулд хэд хэдэн удаа унш. Түүх ярьж байхдаа хүүхдүүдийн анхаарлыг татахын тулд нуд рүү нь харж яриарай. (*Teaching, No Greater Call,* 181–182-ыг үзнэ үү.)

Жаахан хүүхдүүд нь эдгээр үгсийг давтан хэлж чадахгүй байж магад. Тэднийг "Есүс" болон "хайр" гэх мэт түлхүүр үгсийг хэлэхэд нь тусал.

Хүүхдүүдийг өөртэйгөө хамт “Есүс бусдыг хэрхэн хайрлахыг бидэнд харуулсан” гэж хэлэхийг хүс.

Түүх 3 (22-р хуудасны зургийг үзүүл): Есүс дахин амилуулагдсаныхаа дараа Тэрээр Нифайчууд дээр ирсэн. Тэрээр хүүхдүүдэд хайртай учраас хүүхэд бүрийг адисалсан юм *(хүүхдүүдээс өөрсдийгөө тэврэхийг хүс).* (3 Нифай 17:21–24 -ийг үзнэ үү.)

Хүүхдүүдийг өөртэйгөө хамт “Есүс бусдыг хэрхэн хайрлахыг бидэнд үзүүлсэн” гэж хэлэхийг хүс.

Дуу “Би Есүс шиг байхыг хичээнэ” дууг дахин дуулж эсвэл үгсийг нь давтан хэл. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт дуулж мөн үйл хөдлөл хийхийг хүс.

Дүгнэлт Бид бусдыг Есүсийн адил хайрлаж чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ



Эвлүүлдэг зураг: Аврагчийн зургийг авчир (хүсвэл, 106-р хуудасны зургийг хэрэглэж болно). Зургийн хэмжээтэй адил хэмжээтэй цаас авчир (эсвэл цаасаа адил хэмжээтэй болгож хайчил) мөн эвлүүлдэг зураг болгохын тулд уг цаасаа гурав эсвэл дөрвөн хэсэг болгож хайчилна. Хэсэг болгоны ар талд нь “Би бусдыг хайрлах болно” гэж бич.

Судрын үйл ажиллагаанд: Библийн судраа авчир. Иохан 15:12-ыг олоход хялбар болгож тэмдэглэ.

Зурагт үйл ажиллагаанд: Хүүхэд бүрт зориулан 27-р хуудасны зургийг хувилуулж олшруул.

Эвлүүлдэг зураг Есүсийн зургийг эвлүүлдэг зургийн хэсгүүдээр халхална. Зургийн хэсгүүдээс нэг ширхгийг сонгохыг хүүхдээс хүс. Уг хэсэг дээр бичсэн үгсийг уншаад хүүхдүүдээр давтан хэлүүлнэ. Бусдыг хайрлаж болох нэг арга замын талаар ярилц (баярлалаа гэж хэлэх, хуваалцах, эцэг эхийнхээ гуйсан зүйлийг хийх, тоглоомоо буцааж байранд нь тавих гэх мэт). Зургийг халхалсан жижиг хэсгүүдийг бүгдийг нь автлаа ийн давтан хийнэ. Есүс бусдыг хэрхэн хайрлахыг бидэнд үзүүлсэн гэдэг ойлголтыг бататган хэлж өг.

Судар Нэг нэгнээ хайрлахыг Есүс судруудаар бидэнд заадаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Библи дэх Иохан 15:12 судрыг нээн “Бие биеэ хайрла” гэж унш. Эдгээр үгсийг өөртэйгөө хамт давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Дуу “Есүс бүгдийг хайрла гэсэн” (*Хүүхдийн дууны* ном) дуу дуулан эсвэл үгсийг нь давтан хэлж доорх үйл хөдлөлийг хамт хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт үйлдэхийг хүс.

Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн; *(хоёр гараа хажуу руугаа дэлгэнэ)*

Тэдэнд бас найрсаг ханд гэж хэлсэн. *(толгойгоо дээш доош дохино)*

Зүрх сэтгэл чинь хайраар дүүрэх үед *(гараа зүрхэн дээрээ тавина)*

Бусад хүмүүс чамайг хайрлана. *(өөрийгөө тэвэрнэ)*

Зураг 27-р хуудасны зургийн хуулбарыг хүүхэд бүрт тараана. Тэдэнд урьд өмнө ярьж өгсөн түүхээ сануулахын тулд уг зургийн талаарх асуултуудыг хүүхдүүдээс асуу. Жишээлбэл:

Та нар зураг дээр Есүсийг харж байна уу? *(хүүхдүүдийг өөрсдөд нь байгаа хуулбар дээрээс Есүсийг олж заахыг хүс)*

Сагснуудад юу байна вэ? *(хүүхдүүдийг идэж байгаа дүр үзүүл гэж хэлнэ)*

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Нэмэлт үйл ажиллагаанууд: Хүүхдүүдийг сурч, идэвхтэй оролцуулахын тулд сонсох болон үйл хөдлөл багтаасан үйл ажиллагааг ээлжлэн хийнэ. Үйл ажиллагаа тус бүрийг хоёр, гурван минут үргэлжлүүл.

Давтан хийх: Балчир хүүхдийн ангийн хүүхдүүд дахин давтан хийх дуртай байдаг бөгөөд энэ нь тэдэнд сурахад тусалдаг. Хүүхдүүдийн сонирхол бууруагүй, анхаарал нь төвлөрсөн хэвээр байгаа бол хүүхэд бүрт үйл ажиллагааг давтан хийж, оролцох боломж олгоорой.



Есүс Христ бусдыг хэрхэн хайрлахыг
бидэнд харуулсан

6 АРИУН СҮНС НАДАД ТУСАЛДАГ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Ариун Сүнс нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн хамт Бурхан Тэргүүтэний гишүүн юм. Тэр бол "Сүнсэн хүн" (С ба Г 130:22-ыг үзнэ үү). Эцэг мөн Хүүгийн талаар мөн бүх зүйлсийн үнэний талаар гэрчлэх нь Ариун Сүнсний зорилго юм. (3 Нифай 11:36; Моронай 10:5-ыг үзнэ үү). Түүнчлэн Тэр биднийг зөв сонголтыг хийхэд удирдаж мөн тайтгаруулдаг (С ба Г 31:11-ийг үзнэ үү). Ариун Сүнсний бидэнтэй ярьдаг арга замыг судруудад "намуун аниргүй дуу хоолой-гоор" гэж тайлбарласан байдаг (Хаадын Дээд 19:11–12-ыг үзнэ үү).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу Тэнгэрлэг Эцэгийн тухай дуу дуулах гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. "Эцэг минь амьдыг би мэднэ" (*Хүүхдийн дууны ном*) дууны эхний бадгийг дуулж эсвэл үгсийг нь давтан дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Ариун Эцэг минь амьд, намайг бас хайрлана. *(цээжин дээрээ гараа тавина)*

Ариун Сүнс надад үүнийг үнэн хэмээн шивнэнэ, *(гараа чихэндээ авчирна)*

Тэр үнэн хэмээнэ.

Давтан хийх үйл ажиллагаа Хүүхдүүдээс "Сүнс" гэж хэлэхийг хүс. Бурханы Сүнсний өөр нэг нэр нь Ариун Сүнс юм хэмээн тэдэнд хэл. Хүүхдүүдээс "Ариун Сүнс" гэж хэлэхийг хүс. Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай гэдгийг мэдэхэд Ариун Сүнс тусалдаг хэмээн тайлбарла.

Дүрд тоглох Бид нар зөв зүйлийг хийх үед Ариун Сүнс бидэнд сайн сонголт хийс-нийгээ мэдэхэд тусалдаг хэмээн хүүхдүүдэд хэлж өг. Зөв зүйлсийг хийж байгаа дүрд тоглох үедээ хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг урь. Жишээлбэл:

Сүмд явах нь зөв. Сүм рүү явж байгаа дүр үзүүлцгээе *(тойрон алхах зуураа гараа хаялна)*

Тоглоомоо хуваалцах, ээждээ шал шүүрдэхэд нь туслах гэх мэт өөр жишээ татан үргэлжлүүл.

Түүх Айх үед бас Ариун Сүнс бидэнд тусалж чаддаг гэдгийг тайлбарлан хэл. Дараах түүхийг ярьж өг:

Нэг өдөр Дэвидийн гэрийн гадуур хүчтэй шуурга болж байжээ. Тэнгэр чангаар дуугарч *(хүүхдүүдээр чихийг нь таглуулна),* маш ихээр шуурч *(салхилж байгаа дүр үзүүлэн, улээнэ),* мөн бороо орж байлаа *(хүүхдүүдийн хуруу нь тогшуулан борооны чимээ гаргана).* Дэвид айж байсан. Ээж нь түүнд айсан үедээ Тэнгэрлэг Эцэгт хандан залбирдаг гэж хэлж гэнэ *(30-р хуудасны зургийг үзүүлнэ үү).* Дэвид ээжтэйгээ хамт Тэнгэрлэг Эцэг тэднийг аюул-гүй байлгаасай гэж залбирсан. Тэгээд Дэвид айхаа болж мөн баяр

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Ариун Сүнс: Хүүхдүүд бүр бага насандаа ч гэсэн Ариун Сүнсний нөлөөг хэрхэн таньж мэдэхийг сурч авч чаддаг. Ариун Сүнснээс ирэх хайр, халуун дулаан мэдрэмжийг тэд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тухай сурч байх үедээ хичээлийн туршид таньж мэдэхэд нь туслаарай.

Жаахан хүүхдүүд: Ихэнх хүүхдүүд удаан хугацаагаар анхаарлаа төвлөрүүлж чад-даггүй сана. Хүүхдүүдэд өөр үйл ажиллагаа хийх хэрэгтэй байгааг илтгэсэн ямар нэг шинж тэмдгийг ажиглаарай. Хэрвээ тэд хэсэг зуур суусан бол тэднээр хөдлөх үйл ажиллагаа хийлгэ.

хөөрийг мэдэрсэн. Тэнгэрлэг Эцэг, түүнийг айхгүй байж болохын тулд тийм мэдрэмжийг өгүүлэхээр Ариун Сүнсийг илгээсэн гэж ээж нь хэлсэн.

Хүүхдүүдийг "Ариун Сүнс" гэж хэлэхийг хүс.

Дүгнэлт Ариун Сүнсний талаарх гэрчлэлээ хуваалц. Өөрийн амьдралд тохиолдсон, Ариун Сүнсээр удирдагдсан туршлагаасаа энгийнээр, товчхон хуваалцаж болно.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Судрын үйл ажиллагааанд:* Библийн судрыг авчир. Иохан 14:26 байгаа хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

Зурагт үйл ажиллагааанд: 31-р хуудасны зургийн хуулбарыг хүүхэд бүрт өгөөрэй.

Шоотой тоглоомонд: 31-р хуудасны зургийн хуулбарыг хүүхэд бүрт тараан өгч хүсвэл будуулна. Шулуун зураасын дагуу хайчилж тасархай зураасын дагуу нугална. Өнцгийг нь цавуудаж эсвэл наадаг цаасаар наана.

Шүлэгт үйл ажиллагаа Хүүхдүүдтэй хамт тойрог болж зогсоод дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хий.

Ариун Сүнс намуухнаар ярьдаг. *(хуруугаа урууландаа хүргэнэ)*
Тэр хэзээ ч хашгирдаггүй, энэ нь үнэн шүү. *(хашгирч байгаа мэт гараа амаа тойруулан барина)*
Хийж байгаа бүх зүйлд чинь Тэрээр *та нарыг адисалж, тусалж мөн удирдана*
(гар гараа хөтлөн, тойрон алхана) *(суу)*

Судар Ариун Сүнс бидэнд заах болно хэмээн Есүс судруудад заасан гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. Библийн судраас Иохан 14:26-г нээн, "Ариун Сүнс та нарт бүх зүйлсийг заана" гэж унш. Цөөн үгээр уг шүлгийг өөртэйгөө хамт давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Зураг 31-р хуудасны зургийг хүүхдүүдэд үзүүлэн уг зургийн хуулбарыг хүүхэд бүрт тараана. Сүмийн байрны зураг руу заан сүм рүү явах нь зөв зүйл болохыг мэдэхэд Ариун Сүнс бидэнд тусалдаг хэмээн тайлбарла. Өөрсдөд нь байгаа зургийн хуулбар дээрээс Сүмийн байрыг олж заахыг хүүхдүүдээс хүс. Бусад зургуудыг үүний адилаар давтан хийнэ.



Шоотой тоглоом Өөрийн хийсэн шоогоо хаяна. Шооны дээд талд юу бичсэнийг уншаад хүүхдүүдтэй хамт давтан хэл. Тэгээд уг зурагтай уялдах энгийн үйл хөдлөл хүүхдүүдээр хийлгэ. "Ариун Сүнс надад тусалдаг" гэсэн бичигтэй тал шооны дээд талд гарч ирэхэд ямар нэгэн сайн зүйл хийхэд Ариун Сүнс бидэнд үүнийгээ мэдэхэд тусалдаг хэмээн хүүхдүүдэд хэлж өг. Хүүхэд бүрээр ээлжлэн шоог хаяулж давтан хий.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хувийн туршлага: Хувийн туршлагаасаа хуваалцах нь өөрийн тань заах байгаа тэдгээр хүүхдүүдэд өдөр тутмын амьдралд нь сайн мэдээ ямар нөлөө үзүүлдгийг харуулдаг (*Teaching, No Greater Call,* 45, 180-ыг үзнэ үү). Энэ насныханд та нарын хуваалцах сэтгэгдэл маш энгийн, богинохон, нэг, хоёр өгүүлбэрээс хэтрэхгүй байх хэрэгтэй.

Судруудыг: "Хүүхдүүдэд заах үедээ та нар судрыг байн байн хэрэглэж хүүхдүүд судрыг ашиглаж чаддаг болох арга замыг олох хэрэгтэй" (*Teaching, No Greater Call,* 59). Уншиж сурахаас нь өмнө ч гэсэн тэдэнд судрыг хайрлах хайрыг олж авахад нь та нар тусалж чадна. Хичээл дээр хүүхдүүдэд зориулж шүлгийн зөвхөн нэгээхэн хэсгийг унших байлаа ч хичээлд бэлдэж байх үедээ шүлгээ бүтнээр нь уншаарай.

Ээлжлэх нь заахан хүүхдүүдийн хувьд хэцүү байдаг. Балчир хүүхдийн анхид тань олон хүүхэд байдаг бол хүүхэд бүр ээлжлэн шоо хаяхын оронд өөрөө шоогоо орхиж болно.

Ариун Сүнс надад тусалдаг



Сүмд яв

Залбир



Эелдэг уриалгахан бай

Эцэг эхийнхээ үгэнд ор



Судруудыг унш

7 ЕСҮС ХРИСТ МИНИЙ ТӨЛӨӨ ДЭЛХИЙГ БҮТЭЭСЭН



БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Тэнгэрлэг Эцэгийн удирдамжаар Есүс Христ бидний амьдрах үзэсгэлэнт дэлхийг бүтээсэн (Мосе 2:1-ийг үзнэ үү). Дэлхийг бүтээсний гол зорилго нь Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болохын тулд соригдож, туршлага суух газрыг бидэнд өгөх явдал байсан юм (Абрахам 3:24–25-ыг үзнэ үү). Дэлхий дээрх гайхамшигт үзэсгэлэнт зүйлс нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн агуу хайр мөн хүч чадлыг гэрчилдэг (Мосе 6:63-ыг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

Библийн судраа авчир. Эхлэл 1:1-ийг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу “Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг” (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл дууны үгсийг нь давтан хэлж дараах үйл хөдлөлийг хийнэ. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт үйлдэхийг хүс.

- Хөөрхөн шувуудын дууг сонсох бүртээ *(гараа чихэндээ авчирна)*
- Хөх манхан тэнгэрийг харахдаа *(дээшээ хараад, гараараа нар халхалж байгаа дүр үзүүлнэ)*
- Хацар нүүрэн дээр дуслан буух бороо *(хуруунуудынхаа өндгөөр нүүрэндээ хүрнэ)*
- Хажуугаар өнгөрөх салхийг мэдрээд *(хоёр гараа нааш цааш хөдөлгөнө)*
- Сарнайн дэлбээнд хүрэх бүр *(хоёр гараа нийлүүлнэ)*
- Голт борын дэргэдүүр өнгөрөхдөө *(хоёр хуруугаа нөгөө гар дээгүүрээ “алхуулна”)*
- Тэнгэрлэг Эцэгийнхээ бүтээж өгсөн *(гараа өргөн толгой дээрээ цагираг болгон барина)*
- Энэ хорвоод амьдарч буйдаа баярладаг. *(өөр рүүгээ заана)*

Судар Библийн судраа нээн Эхлэл 1:1-ийг гарган, “Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ” гэж уншина. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт цөөн үгээр уг шүлгийг давтан хэлэхийг хүс. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христээр дэлхийг болон үүнд байгаа бүхнийг бүтээлгэсэн хэмээн тайлбарлаж өг; Есүс бас бидэнд гэрэл өгөхөөр нарыг бүтээсэн. Хүүхдүүдийг толгойныхоо дээр гараа цагираг болгон барьж “нар” гэж хэлэхийг хүс.

Бидний шөнө хардаг оддыг Есүс бүтээсэн гэдгийг хүүхдүүдэд хэл. Гараа хавсарч анивчих оддын адил хөдөлгөж “одод” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Зураг 34-р хуудасны зургийг үзүүл. Модод руу заан Есүс ургамлуудыг бүтээсэн хэмээн хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдээс босч зогсоод гараа дээш өргөн салхинд найгаж байгаа модны дүр үзүүлэхийг хүс. Тэднээс “мод” гэж хэлэхийг хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуу: “Ихэнх хүүхдүүд дуу хөгжимт үйл ажиллагаанд оролцох дуртай байдаг. Дууны хөгжөөнт аялгуу нь . . . үгсийн захиасыг санахад хүүхдүүдэд тусалдаг. Дуу хөгжим нь сайн мэдээний зарчмуудын талаарх хүүхдүүдийн ойлголтыг нэмэгдүүлж мөн тэдний гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг” (*Teaching, No Greater Call,* 174).

Бага хүүхдүүд: Бүх сурах үйл ажиллагааг хийж дуусахаас өмнө хүүхдүүдийн анхаарал бүурч эхэлбэл хичээлээ завсарлаад хүүхдүүд хөдөлж, алхаж, гараа хөдөлгөж болох үйл ажиллагааг хийнэ. Хүүхдүүд том болох тусам тэд арай илүү удаан хугацаагаар анхаарал тавих чадвартай болно.

Зураг дээрх амьтад руу зааж Есүс амьтдыг бүтээсэн гэж тайлбарла. Хүүхдүүдээс амьтдыг нэрлэж мөн амьтдын чимээ гаргахыг хүс.

Дүгнэлт Есүс бидэнд хайртай учраас эдгээр бүх зүйлийг Тэрээр бүтээсэн гэдгийг тайлбарла. Үзэсгэлэнт дэлхийнхээ төлөө талархлаа илэрхийл.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Үртэй үйл ажиллагаанд:* Хүүхэд бүрт зориулж хуванцар аяга авчир. Аяганд хийх шороо бас хүүхэд бүрт өгөх үр (шош, эрдэнэ шиш, буудайны үр гэх мэт) авчир. Аяга бүр дээр "Есүс Христ надад зориулан үрийг бүтээсэн" гэж бичнэ. Үрийг хэрхэн арчлах талаар тайлбарласан бичиг бэлдэн хүүхдүүдэд гэр рүү нь өгч явуулаарай.

Номтой үйл ажиллагаанд: 35-р хуудсыг хүүхэд бүрт зориулан будуулахаар хувилуул. Наадаг цаас эсвэл цавуу авчир.

Дуу "Сайхан дэлхий" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг давтан хэлээд дараах үйл хөдлөлийг хий. Өөртэйгөө хамт хийхийг хүүхдүүдээс хүс.

Их Эзэн ийм сайхан дэлхийг бүтээсэн *(инээмсэглэж буй царай харуул)*
Энд амьдарч буйдаа би маш их баярладаг. *(өөр рүүгээ заа)*
Нарны туяа, *(гараа толгой дээрээ өргө)* цэцэгс, *(цэцэг үнэрлэж байгаа дүр үзүүл)* оддод би дуртай, *(одод анивчиж байгаа мэтээр хуруугаа хөдөлгө)*
Гэр орон, гэр бүлийнхэндээ би хайртай. *(өөрийгөө тэвэрнэ)*

Үртэй үйл ажиллагаа Авчирсан аяга болгондоо бага зэрэг шороо хийгээд хүүхдүүдээр үр суулгуулна. Тэднийг үр суулгаж байх хооронд хэрвээ тэд үрээ услан, нарны гэрэл тусах газар тавибал тэр үрнүүд нь ургамал болж ургах болно гэдгийг хэл. Есүс Христ үр, хөрс шороо, бороо, нарны туяаг бүтээсэн гэдгийг тэдэнд сануулаарай. Үр ургаж байгааг хүүхдүүд ажиглаж болохын тулд хүүхдүүдийн аягыг гэр рүү нь эцэг эхэд нь өгч явуул. Энэ нь ангийн том хүүхдүүдэд хийхэд тохиромжтой үйл ажиллагаа юм.

Ном 35-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуулна. Тэднийг будаж байх хооронд хичээл дээрээ заасан зүйлээ давт. Тэднийг будаж дууссаны дараа зааврын дагуу зургийг нугалж, наана. Тэгээд номоо хүүхдүүдтэй хамт уншина.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Үртэй үйл ажиллагаа: Энэхүү үйл ажиллагааг хийсэн тохиолдолд хүүхдүүдийг гэр рүүгээ явах цаг болтол нь шороотой аягаа аюулгүй газар тавиарай. Хэрвээ балчир хүүхдийн анги ариун ёслолын цуглааны өмнө явагддаг бол цуглааны танхим руу шороотой аягыг өгч оруулж болохгүй. Харин ариун ёслолын цуглааны дараа эцэг эхэд нь аягануудыг өг.

Ном: Балчир хүүхдийн ангид байлгах үйл ажиллагааны хайрцаг хийх талаар бодож үзээрэй. Энэхүү хайрцгандаа энэ хичээлд зориулан хийсэн ном мөн өөр үйл ажиллагаа хийхэд ашигласан бусад зүйлсийг хийж болно. Тэгээд балчир хүүхдийн ангийн дараагийн хичээлүүд дээр тэдгээр үйл ажиллагаануудыг дахин хийж өмнөх хичээлүүдээ давтаж болно. Энэхүү давтлагыг балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч хэсэгт нь хийж болно.

Тэр амьтдыг бүтээсэн.

Тэр ургамлуудыг бүтээсэн.

Тэр сар, оддыг бүтээсэн.

Есүс нарыг бүтээсэн.

1. Үүний дагуу хоёр хуваарь нугал

2. Зураасын дагуу нугал

Тэр шувуудыг бүтээсэн.

3. Зураасын дагуу нугал

Есүс Христ минийн төлөө дэлхийг бүтээсэн

4. Хатуу цаасан дээр тогтоо эсвэл цавуудаж наа

5. Зураасын дагуу нугал

8 НЯМ ГАРАГ БОЛ ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ БОЛОН ЕСҮС ХРИСТИЙГ ДУРСАН САНАХ ӨДӨР БИЛЭЭ



БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Хуучин Гэрээний үеэс хойш Бурханы хүмүүс долоон өдрийн нэгийг нь Хүндэтгэлийн өдөр — бүх хөдөлмөрөөсөө амарч Бурханыг шүтэн бишрэх өдөр болгон зориулсаар ирсэн (Эхлэл 2:2–3; Египетээс гарсан нь 20:8–11-ийг үзнэ үү). Их Эзэн энэ тушаалыг бидний өдрүүдэд дахин өгсөн ба Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалвал "дэлхийгээс толбогүй байхад" бидэнд туслах болно гэж Тэр амласан (С ба Г 59:9–10-ыг үзнэ үү).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг 38-р хуудсан дээрх сүмийн зүг алхаж яваа гэр бүлийн зургийг харуулан энэ гэр бүл Ням гарагт сүм рүүгээ явж байгаа гэдгийг хэл. Ням гараг бол онцгой өдөр бөгөөд бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг бишрэн мөн Тэдний талаар сурахаар сүмд явдаг хэмээн тайлбарлаж өг.

Дуунууд Хүүхдүүдэд "Сүм рүү явж байгаа дүр үзүүлье" гэж хэл. Тэднийг тойргоор алхуулж мөн "Хөгжилтэй" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулуулан эсвэл үгсийг нь давтан хэлүүл:

Сүмд явах нь хөгжилтэй,
Хөгжилтэй, хөгжилтэй, хөгжилтэй!
Сүмд явах нь хөгжилтэй,
Хөгжилтэй, хөгжилтэй, хөгжилтэй!

Хүүхдүүдийг суулгаад бид сүмд ирэх үедээ Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг санаж *(толгой руугаа заа)* тэдний талаар боддог *(дахин толгой руугаа заа)* гэдгийг хэл. "Бишрэлтэй, даруухнаар" (*Хүүхдийн дууны ном*) дууны эхний мөрийг дуулж эсвэл үгийг нь давтан хэл:

Даруухнаар, намуухнаар хайраар бид Таныг бодож.

38-р хуудсан дээрх гэртээ байгаа гэр бүлийн зургийг үзүүл. Гэр бүлийн гишүүдийн хэн болохыг заагаад сүмээс харьсны дараа гэртээ бид Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг гэр бүлийнхэнтэйгээ хамт санан дурсаж болдог хэмээн тайлбарла. Бид хамтдаа судраас уншиж *(хүүхдүүдээс судар уншиж байгаа дүр үзүүлэхийг хүс),* хамтдаа залбирч *(хүүхдүүдийн гарыг зөрүүл),* бие биедээ хайраа үзүүлж *(гараа зүрхэн дээрээ тавь) чадна.* "Аз жаргалтай гэр бүл" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан хэл. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Ээж аав хоёртоо бид хайртай.
Тэд бас бидэнд хайртайдаа;
Бид бие биенээ хайрладаг
Аз жаргалтай гэр бүл билээ.

Дүгнэлт Ням гараг бол сүм дээр болон гэр орондоо гэр бүлтэйгээ Тэнгэрлэг Эцэг, Есүсийг санан дурсах өдөр гэдгийг хүүхдүүдэд сануул. Хүүхдүүдээс "Ням гараг" гэж хэлэхийг хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуу: Заахаар бэлтгэх үедээ дуунуудын болон үйл ажиллагаануудын үгсийг цээжлэхийг хичээ. Энэ нь хүүхдүүдэд мөн тэдний сурахад анхаарлаа хандуулах боломж олгох болно. *Teaching, No Greater Call,* 159-ийг үзнэ үү.

Дуунууд: Хүүхдүүдийн сурч байгаа дууны, ялангуяа тэдний дуулах дуртай дууны жагсаалт хийх талаар бодож үзээрэй. Тэрхүү дуунуудыг бэлчир хүүхдийн ангидаа долоо хоног бүр хүүхдүүдийг тоглоомоор тоглож байхад нь, зууш өгөхийн өмнө буюу дараа эсвэл хүүхдүүд аав, ээжийгээ хүлээж байх хооронд дуулаарай. Энэ нь өмнөх хичээлүүдээ давтах сайн арга зам юм. Эхэндээ хүүхдүүд тантай хамт дуу дуулахгүй байлаа ч тэд сонсож мөн сурч байгаа.

Залбирал Хаалтын залбирал хийхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Ууттай тоглоомонд:* 39-р хуудсыг хувилуул. Хүсвэл зургуудыг хайчлаад, будаж болно. Зургуудаа уутанд эсвэл өөр хайрцганд хийнэ.

Судрын үйл ажиллагаанд: Библийн судраа авчир. Эхлэл 2:2-ын хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ. Мөн энэхүү гарын авлагын 34-р хуудсыг тэмдэглэ.

Номтой үйл ажиллагаанд: 39-р хуудсан дээрх зургийг хүүхэд бүрт будуулахаар хувилуул.

Ууттай тоглоом Уутнаас нэг зураг сонгохыг нэг хүүхдээс хүс. Зурган дээрх бичсэн зүйлийг нь уншаад зургийн дагуу үйл хөдлөл хийхийг ("Ням гарагт би сүмдээ явдаг" гэж уншвал дороо алхаж эсвэл "Ням гараг бол Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг дурсан санадаг өдөр" гэж уншвал толгой руугаа заах гэх мэт) хүүхдүүдээс хүс. Бичсэн зүйл бүрээс "Есүс", "судрууд", "гэр бүл" мөн "сүм" гэх мэт түлхүүр үгсийг нь хэлэхийг хүүхдүүдээс хүс. Зураг бүрийн дагуу ийн үйлдэж эсвэл ээлжлэх хүсэлтэй хүүхэд бүрээр давтан хийлгэ.

Судар 34-р хуудасны зургийг харуулан бүтээлтийн түүхийг хүүхдүүдтэй хамт унш (Эхлэл 1 болон энэхүү гарын авлагын 7-р хичээлийг үзнэ үү). Энэ дэлхийг бүтээхээр Есүс зургаан өдөр ажилласан болохыг тайлбарла.

Долоо дахь өдөр нь Есүс юу хийсэн тухай судрыг унших гэж буйгаа хүүхдүүдэд хэлнэ. Библийн судраа нээн Эхлэл 2:2-ыг гаргаж "Хийж бүтээсэн ажлаа дуусгаж, долоо дахь өдөртөө Тэрээр амарчээ" гэж унш. *Амарчээ* гэдэг үгийг тод томруунаар хэл.

"Есүс долоо дахь өдрөө юу хийсэн бэ?" гэж асуу.
"Тэр амарсан" гэж хариулна.

Долоо хоногийн зургаан өдөр нь бид ажилладаг хэмээн хүүхдүүдэд хэл. Шал шүүрдэх, цэцэрлэгийн хөрсийг ухах гэх мэт янз бүрийн ажил хийж байгаа дүр үзүүлэхийг тэднээс хүс. Ням гарагт бид амардаг хэмээн тайлбарла. Хүүхдүүдийг суулгаад Тэнгэрлэг Эцэг бидэнд ажлаасаа амрах нэг өдөр өгсөнд нь хэчнээн их талархаж буйгаа хэлээрэй.

Ном 39-р хуудасны хуулбарыг хүүхдүүдээр будуулна. Тэднийг будаж байх хооронд зурагнуудын талаар хэлж өгч ням гарагт Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг дурсан санаж, шүтэн бишрэхийн тулд бид эдгээр зүйлүүдийг хийдэг гэдгийг тэдэнд сануул. Тэднийг будаж дууссаны дараа тасархай зураасын дагуу нугалж ном болгоно. Тэгээд уг номыг хүүхдүүдэд уншиж өгнө.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Ууттай тоглоом: Зургуудаа хийх уут эсвэл хайрцаг байхгүй бол тэдгээрийг доош харуулан тавиад хүүхдээр сонгуулж дээш харуул гэж хэл.

Ээлж ээлжээр хийх нь хүүхдүүдэд хэцүү байж болно. Хүүхдүүдийг ээлжээ хүлээж байх хооронд сандал эсвэл шалан дээр суулгаж болно. Балчир хүүхдийн ангийн нэг багшийг зааж байх хооронд нөгөө багш нь хүүхдүүдийг хүлээхэд тусалж болно.

Ном: Номоо гэр бүлийнхэндээ үзүүлэхэд тэднийг урамшуулан дэмж. Ингэснээрээ, эцэг эх нь сурсан зүйлийнх нь талаар тэдэнтэй ярилцах боломжтой болно. (*Teaching, No Greater Call,* 167-г үзнэ үү.)

Ням гараг бол Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг дурсан санадаг өдөр.



Ням гарагт би судруудыг уншдаг.



Ням гарагт би сүмдээ явдаг.



Ням гарагт би гэр бүлдээ оцлоой хайрыг үзүүлж чадна.

9 БИ ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГИЙНХТЭЙ АДИЛ БИЕ МАХБОДТОЙ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Бидний хүн нэг бүр нь Бурханы хүүхэд . Судруудад "Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээсэн" гэж заадаг (Эхлэл 1:27; түүнчлэн Мосе 2:26–27; Абрахам 4:26–27-г үзнэ үү). Энэ нь бидний бие махбод Түүнийхтэй адил гэсэн үг юм. Бошиглогч Иосеф Смит, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан бөгөөд тэрээр "Эцэг хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой; Хүү ч бас адил бөлгөө" гэж заасан (С ба Г 130:22).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу "Би Бурханы хүүхэд" (*Хүүхдийн дууны ном*) дууны эхний бадгийг дуул:

Би Бурханы хүүхэд тул
Энэ эх дэлхийд намайг
Их энэрэнгүй эх эцгийг
Дэлхийн хамт заяав Тэр.

Дахин дуулаад хүүхдүүдийг сонсож эсвэл өөртэйгөө хамт дуулахыг хүс. Бид "Бурхан" гэж хэлэхдээ Тэнгэрлэг Эцэг гэж хэлж байгаа гэдгийг тэдэнд хэл.

Судрын түүх 42-р хуудасны зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэг биднийхтэй адил бие махбодтой гэдгийг заахын тулд хүүхдүүдэд Иосеф Смитийн анхны үзэгдлийн талаарх түүхийг товчхон ярьж өг (Иосеф Смит —Түүх 1:17). Дараах жишээг үзнэ үү:

Иосеф Смит хөвгүүн байхдаа *(зурган дээрээс Иосефыг заана),* Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсан. Үнэхээр гайхамшигтай зүйл тохиосон. Иосеф, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан *(зураг дээр Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг заана).* Тэд ирээд Иосефтой ярьсан. Тэнгэрлэг Эцэг биднийхтэй адил бие махбодтой болохыг Иосеф харсан. Тэнгэрлэг Эцэг гартай. Та нар гартай юу? Надад гараа үзүүлнэ үү. Тэнгэрлэг Эцэг хуруутай. Та нар хуруутай юу? Надад хуруугаа үзүүлнэ үү. Тэнгэрлэг Эцэг нүүртэй. Та нар нүүртэй юу? Нүүрэндээ хүрнэ үү. Та нар жинхэнэ бодит хүн. Тэнгэрлэг Эцэг жинхэнэ бодит хүн. Тэр чиний биеийг бүтээсэн. Чи Тэнгэрлэг Эцэгийнхтэй адил бие махбодтой.

Шүлэгт үйл ажиллагаа Хүүхдүүдийг босч зогсоод дараах шүлэгт үйл ажиллагааг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Би онцгой биетэй
Тэнгэрлэг Эцэг надад өгсөн. *(гараа цээжиндээ хургэнэ)*
Би сонсож болохын тулд Тэр надад чих өгсөн *(гараа чихнийхээ ард барина)*
Харж болохын тулд нүд өгсөн. *(нүд рүүгээ заана)*

Алгаа ташиж болохын тулд надад гар өгсөн *(алгаа таш)*
Эргэлдэж болохын тулд хоёр хөл өгсөн. *(дороо эргэнэ)*
Хүссэн үедээ би хөлийн хуруундаа хүрч чадна *(доош бөхийн хөлийн хуруундаа гараа хургэ)*

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Сурах үйл ажиллагаанууд: Үйл ажиллагаануудад хүүхдүүд хэрхэн оролцож байгааг анхаар. Балчир хүүхдийн ангийнхаа хүүхдүүдийн чадавх болон хэрэгцээг та мэднэ. Шаардлагатай бол үйл ажиллагаагаа өөрчилж болно. (*Teaching, No Greater Call,* 33–34-ыг үзнэ үү.)

Шүлэгт үйл ажиллагаа: Та нар балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед хүүхдүүд босч хөдлөх, тэдний анхаарлыг татах хэрэгтэй болвол шүлэгт үйл ажиллагааг хийж болно. Тэдгээр нь өмнө заасан зарчмуудаа давтах сайн арга юм.

Газар хүртэл доошоо хүрнэ.

Биеийнхээ талаар бодохдоо *(хуруугаа толгойндоо хүргэнэ)*
Хамгийн сайхан нь юу вэ гэвэл
Тэнгэрлэг Эцэг Өөрийнхтэй адил
Харагдуулахаар төлөвлөсөн. *(чимээгүйгээр доош сууна)*

Дүгнэлт Хүүхдүүдийг өөрийг тань даган цөөн үгээр "Би Тэнгэрлэг Эцэгийнхтэй адил бие махбодтой" гэж хэлэхийг хүс. Бие махбодынхоо төлөө талархаж байдгаа илэрхийл.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг хэн нэгэн хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Цаасан хүүхэлдэй ашиглан ярих түүх:* 91-р хуудасны цаасан хүүхэлдэйнүүдийн зургийг хувилуулж, будаж мөн хайчил.
Хуулбар зурагтай үйл ажиллагаанд: Хүүхэд бүрт хоосон цаас, бичих тосон бал, харандаа авчир.
Зурагт үйл ажиллагаанд: 43-р хуудасны зургийг хүүхэд бүрт зориулан хувил.

Дуу "Толгой, мөр, өвдөг, хөл" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг давтан хэлж хэлэх үедээ толгой, мөр, өвдөг, хөл рүүгээ заана. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Толгой, мөр, өвдөг, хөл, өвдөг хөл,
өвдөг хөл,
Толгой, мөр, өвдөг, хөл, нүд, чих, ам,
хамар.



Хүүхдүүдийн хүссэнээр олон удаа давтан хий. Тэнгэрлэг Эцэг Өөрийнхтэйгөө адил харагдах бие махбодыг бидэнд өгсөн гэдгийг сануулан хэл.

Цаасан хүүхэлдэйгээ ашиглан ярих түүх Өөрийн хийсэн цаасан хүүхэлдэйгээ ашиглан Анхны үзэгдлийн түүхийг дахин ярьж өг (Иосеф Смит—Түүх 1:11–17; түүнчлэн 88-р хуудасны жишээг үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ биднийхтэй адил бие махбодтой болохыг Иосеф Смит харсан гэдгийг онцлон хэл.

Хуулах Цаасан дээр хүүхэд бүрийн сарвууг нь дагуулан зурна. Зурсан сарвууны хэвээ тэднээр будуулна. Цаасан дээр нь хүүхдийн нэр, нас, он сар өдрийг бичнэ.

Зураг 43-р хуудасны зургийг харуулан ил тавиад хүүхэд бүрт нэг хувийг өг. Хүүгийн нүүр рүү заагаад бид ч, Тэнгэрлэг Эцэг ч мөн нүүр царайтай гэдгийг хүүхдүүдэд сануул. Өөрсдийн зураг дээрх нүүр рүү заахыг хүүхдүүдээс хүс. Биеийн бусад эрхтнүүдийг заан үүний дагуу хий. Хүсвэл хүүхдүүдээр зургийг будуул.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Цаасан хүүхэлдэй: Балчир хүүхдийн анхид зориулан цаасан хүүхэлдэй эсвэл өөр заахад туслах сурталтын зүйлсийг хийгээд тэдгээрийг хадгалаарай. Дараагийн хичээлүүдэд дахин хэрэглэх боломжтой болно.

Давтан хийх: Өмнөх хичээлүүдийн үйл ажиллагаануудаас сонгон хэдэн удаа давтан хийхээ та шийдэж болно. Давтан хийх нь хүүхдүүдэд зугаатай байдаг бөгөөд тэдэнд сурахад тусалдаг.

Би Тэнгэрлэг Эцэгийнхтэй адил бие махбодтой

Би Тэнгэрлэг Эцэгийнхтэй адил нүүр царайтай.



Би Тэнгэрлэг Эцэгийнх шиг хоёр гартай.

Би Тэнгэрлэг Эцэгийнх шиг хоёр хөлтэй.

10 БИ ӨӨРИЙН БИЕИЙГ АРЧЛАХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Авралын төлөвлөгөөний агуу адислалуудын нэг нь бие махбодыг хүлээн авах боломж юм. Их Эзэн биднийг өөрсдийн бие махбодыг хайрлаж хүндэтгэн арчилж байгаасай хэмээн хүсдэг. Бид үүнийг хийвэл Тэрээр биднийг адисалдаг (1 Коринт 3:16; С ба Г 89:18–21-ийг үзнэ үү).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг Тэнгэрлэг Эцэг бидэнд бие махбод өгсөн бөгөөд бид бие махбодоороо олон гайхамшигтай зүйлсийг хийж чадна гэдгийг хүүхдүүдэд хэл. 46-р хуудасны зургийг үзүүл. Зурган дээрх гэр бүлийн гишүүд рүү заан хэн хэн болохыг нь хэл; нялх хүүхэд рүү заагаад, дор дурдах асуултуудтай төстэй асуултуудыг асуу. Асуулт бүрийнхээ дараа хүүхдүүдийг өөртэйгөө хамт "Үгүй" гэж хэлээд, толгойгоо хоёр тийшээ сэгсрэхийг хүс.

- Нялх хүүхэд алхаж чадах уу?
- Нялх хүүхэд ярьж чадах уу?
- Нялх хүүхэд бөмбөг шидэж чадах уу?

Хүүхдүүдэд өмнө нь тэд нялх хүүхдүүд байсан бол одоо өсч том болж байгаа гэж хэл.

Дуу Хүүхдүүдийг босгож зогсоо. "Цасан хүн"(*Хүүхдийн дууны ном*) дууны аялгуунд дуулж эсвэл дараах үгсийг хэлж үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Нэгэнтээ би нялх, нялх, нялх байсан. *(гартаа хүүхэд бүүвэйлж байгаа дүр үзүүл)*
Нэгэнтээ би бяцхан, бяцхан хүүхэд байсан. *(аажуухнаар доошлон сууна)*
Одоо би том, том, том болж өсч байна. *(аажуухнаар босч зогсоно)*
Одоо би том, өндөр, өндөр болж өсч байна! *(гараа толгойноосоо дээш өргөнө)*

Зураг Зургийг дахин харуулж аавтайгаа тоглож байгаа хүүхэд рүү заа. Энэ хүүхэд өөрсөдтэй нь бараг чацуу гэж хүүхдүүдэд хэл. Дор дурдах асуулттай төстэй асуултуудыг хүүхдүүдээс асуу. Асуулт бүрийн дараа хүүхдүүдийг өөртэйгөө хамт "Тийм" гэж хариулаад толгойгоо дохихыг хүс.

- Чи алхаж чадах уу? *(хүүхдүүдийг байрандаа алхахыг хүс)*
- Чи ярьж чадах уу? *(хүүхдүүдтэй хамт тав хүртэл тоол)*
- Чи бөмбөг шидэж чадах уу? *(хүүхдүүдээс бөмбөг шидээд барьж авч байгаа дүр үзүүлэхийг хүс)*

Тэд сайн хоол идэж, унтаж мөн өөрсдийгөө цэвэр байлгахын тулд угаадаг учраас өсч том болж байгаа гэж хүүхдүүдэд хэл.

Дүрд тоглох 47-р хуудасны зургийг үзүүл. Унтаж буй охины зураг руу заан унтах нь биеэ арчлах нэг арга зам болохыг тайлбарлаж өг. Хүүхдүүдээс

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Тайлбар: Энэхүү хичээлийн явцад балчир хүүхдийн ангид байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдалд мэдрэмжтэй хандах. Зурагт үйл ажиллагааны үеэр асууж байгаа асуултаа өөрчлөх хэрэгтэй байж болно. Хүүхдүүдийн хийж чадахгүй зүйл дээр биш харин тэдний хийж *чадах* зүйл дээр анхаарлаа төвлөрүүл. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст заах талаарх мэдээлэл авахын тулд *Teaching, No Greater Call,* 38–39-ийг үзнэ үү.

Дүрд тоглох: Дүрд тоглох үйл ажиллагаагаар хийх үйл хөдлөлийн зоримыг жаахан хүүхдүүд хэрхэн хийхээ мэдэхгүй байж болно. Заах өөр нэг арга бол тэднээс өөрсдийн эрхтнүүд рүүгээ заахыг хүсэх юм. Жишээлбэл: ам руугаа заагаад "Энэ миний ам. Чи надад амаа зааж харуулж чадах уу?" гэж асуу. Алга ташин хүүхдүүдийг магт. Бусад эрхтнүүдийг нэрлэн үүнчлэн хий.

унтаж буй дүр үзүүлэхийг хүс. Хуудсан дээрх бусад зургуудын дагуу үйл хөдлөл хийнэ.

Дүгнэлт Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн бие махбодод талархаж байгаагаа илэрхийл. Хүүхдүүдийг цөөн үгээр “Би өөрийн биеийг арчлах болно” гэж хэлэхийг хүс.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Таах тоглоомонд:* Эрүүл мэндэд тустай гурав, дөрвөн жимс ногоо гэх мэт хүнсний зүйлийг тавган дээр авчирч тавь. Тавагтай хүнсний зүйлийг бүтээх бүтээлэг мэт зүйлийг авчир.

Будах үйл ажиллагаанд: 47-р хуудасны зургийг хувилуулан хүүхэд бүрт будуулахаар өгнө.

Таах тоглоом Хүүхдүүдэд тавагтай хүнсний зүйлийг харуулна. Тавган дээрх зүйл бүр рүү заан нэрлэхэд нь хүүхдүүдэд тусал. Хүнсний зүйлээ бүтээлгээр бүтээгээд аль нэгийг нь авсны дараа бүтээлгээ ав. Ямар зүйл байхгүй болсныг хүүхдүүдээр таалга. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохирно.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хэлээд хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Энэ жаахан хүүхэд орондоо орох гэж байна. *(нэг хуруугаа гозойлго)*
Толгойгоо тэр дэрэн дээрээ тавина. *(хуруугаа нөгөө гарынхаа алган дээр тавь)*
Өөрийгөө хөнжлөөрөө сайн хучаад *(хуруугаа нөгөө гараар таглана)*
Тэр шөнөжингөө ийн унтдаг.
Өглөө болж тэр нүдээ нээнэ.
Хөнжлөө түлхэн холдуулна. *(хуруугаа харуулахын тулд гараа өргөнө)*
Удалгүй тэр босч хувцаслаад мөн гарна, *(хуруугаа босгоно)*
Инээмсэглэж, ажиллаж, тоглоход бэлэн болно.

Будах 47-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуулна. Тэднийг будаж байх хооронд уг зургууд биеэ арчлах арга замуудыг харуулж байгааг хэл.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Нэмэлт үйл ажиллагаа нь та нарт балчир хүүхдийн ангийн хүүхдүүдийн онцлог, хэрэгцээнд тохируулах боломж олгодог. Та тэдгээрээс аль үйл ажиллагааг хэрхэн мөн хэдэн удаа хийхээ сонгож болно. Хүүхдүүдийн дуртай мөн тэдэнд сурахад нь туслах үйл ажиллагаануудыг сонго. Өөрсдийн нөхцөл байдал болон хэрэгцээнд тохируулан өөрчилж болно.

Будах: Хүүхэд бүр будах дуртай байдаггүй. Зарим хүүхдүүд хуудсан дээр ганц хоёр зураас татаж ч магадгүй. Тэд нэг их удаан будахгүй ч зургуудаас ямар нэгэн зүйл сурч авдаг.

Би өөрийн биеийг арчлах болно



11 БИ ГЭР БҮЛДЭЭ ХАЙРТАЙ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Гэр бүл нь авралын төлөвлөгөөний гол цөм билээ. Аз жаргал өгч, биднийг мөнхийн амьдралд бэлтгэхийн тулд Тэнгэрлэг Эцэг гэр бүлүүдийг бүтээсэн. Гэр бүлдээ бид хайрын орчинд зөв зарчмуудыг сурч чаддаг. Гэр бүлийн гишүүд бие биеэ хайрлаж халамжлах нь маш чухал. Бид тусархаг мөн хүндэтгэлтэй байснаар хайраа харуулдаг (Ефес 6:1–3). Нэг нэгэндээ эелдэг [мөн] зөөлөн ханд хэмээн судрууд бидэнд заадаг (Ефес 4:32; түүнчлэн "Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"-ийг үзнэ үү. *Ensign,* 1995 оны 11 сар, 102).

БЭЛТГЭЛ

51-р хуудсан дахь гэр бүлийн гишүүдийн дүрсний хуулбарыг хий. Хүсвэл будаж болно. Тэдгээрийг хайчлан хайрцганд хий.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг 50-р хуудсан дахь аз жаргалтай гэр бүлийн зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэг бидний хүн бүрт гэр бүлийг өгсөн хэмээн хүүхдүүдэд хэл. Гэр бүлийнхэн маань бидэнд хайртай бөгөөд бид найрсаг, тусч байдлаараа өөрийн хайрыг гэр бүлийнхэндээ үзүүлдэг хэмээн тайлбарла.

Дүрд тоглох Дүрс хайчилж хийсэн хайрцгаа бариад нэг хүүхдээс дүрс сонгохыг хүс. Энэ нь гэр бүлийн ямар гишүүн болохыг (ээж, аав, ах, эгч, нялх дүү) хэлж өгөөд өөртэйгөө хамт давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс. Уг гэр бүлийн гишүүнд бид хайраа хэрхэн үзүүлж болох арга замыг (тоглоомоо хуваах, тоглоомоороо хамт тоглох, инээмсэглэх гэх мэт) санал болго. Үйлдлийг хийж байгаа дүр үзүүлэхийг тэднээс хүс. Энэхүү үйл ажиллагааг гэр бүлийн гишүүн бүр дээр давтан хий.

Дуу "Аз жаргалтай гэр бүл" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан хэлээд дараах хөдөлгөөнийг хийнэ. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт үйлдэхийг хүс.

Би ээждээ хайртай; тэр надад хайртай. *(гараа цээжин дээрээ тавь)*
Бид аавдаа хайртай, тийм шүү; *(толгойгоо дээш доош болгон дохино)*
Тэр бидэнд хайртай, тиймээс *(гараа дэлгэнэ)*
Бид аз жаргалтай гэр бүл. *(өөрийгөө тэвэрнэ)*

Би эгчдээ хайртай; тэр надад хайртай. *(гараа цээжин дээрээ тавь)*
Бид ахдаа хайртай, тийм шүү; *(толгойгоо дээш доош болгон дохино)*
Тэр бидэнд хайртай, тиймээс *(гараа дэлгэнэ)*
Бид аз жаргалтай гэр бүл. *(өөрийгөө тэвэрнэ)*

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дүрсүүд: Хувилагч машин байхгүй тохиолдолд зургийн дүрсүүд дээр нь цэвэр цаас тавин тосон бал эсвэл харандаагаар зур. Зургийг бүхэлд нь хуулбарлах гэж санаа зовох хэрэггүй; дүрс танигдахуйц байхаар л зураасуудыг дагуулан зур.

Эдгээр дүрсүүдийг дараа дараагийн хичээлүүдэд ашиглахаар хадгал (13-р хичээл гэх мэт). Балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед энэ хичээлийг давтан тэдгээрийг дахин ашиглаж болно.

Тайлбар: Энэхүү хичээлийн явцад хүүхдүүдийн гэр орон болон гэр бүлийнх нь нөхцөл байдлын талаар ойлгож мэдрэмжтэй ханд.

Дүгнэлт Хүүхдүүдэд гэр бүлийнхээ гишүүдэд хайраа үзүүлж мөн найрсаг байхыг уриал. “Би гэр бүлдээ хайртай” гэж хэлэхийг тэднээс хүс.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Түүх хэлэхэд:* Энэхүү гарын авлагын 18-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

Цаасан самбарт: Балчир хүүхдийн ангийн хүүхэд бүрийн аав ээжээс гэр бүлтэйгээ авахуулсан жижиг зураг авчрахыг хүс (тэд хүүхэд нь балчир хүүхдийн ангид анх ороход уг зургийг өгчихсөн байж болно; 7-р хуудсыг үзнэ үү). Цаасан самбар дээр зургуудыг тогтооно. Дээд талд нь “Би гэр бүлдээ хайртай” гэж бич.

Түүх Есүс болон Түүний эхийн зургийг хүүхдүүдэд үзүүл (18-р хуудас). Есүсийн зураг руу заан энэ нь Түүний хүүхэд байх үеийн зураг гэдгийг хүүхдүүдэд хэл. Мариагийн зураг руу заан энэ бол Есүсийн ээж нь гэж хэл. Есүсийг жаахан байхад нь түүнийг сайн асран халамжилдаг хайртай гэр бүл түүнд байсан бөгөөд Тэр гэр бүлийнхэндээ маш их хайртай байсан гэдгийг тайлбарла. Ээжүүддээ хайраа үзүүлж болох арга замуудыг хүүхдүүдэд санал болго (инээмсэглэх, цэвэрлэхэд нь туслах, тэврэх гэх мэт). Тэднээс тэдгээр зүйлийг хийж байгаа дүр үзүүлэхийг хүс.

Дуу Гэр бүлийнхэндээ хайраа үзүүлж болох зарим арга замыг хүүхдүүдэд заахын тулд “Хөгжилтэй” (*Хүүхдийн дууны ном*) дуунд шинэ үгсийг нэмнэ. Жишээлбэл, “Эгчдээ (охин дүүдээ) хайраа яаж үзүүлж болохоо харуулья” гэж хүүхдүүдэд хэл. “Тоглоомоороо хамтдаа тоглох нь хөгжилтэй” гэж дуулаад энгийн үйл хөдлөлийг хийнэ. “Тоглоомоо хураах нь хөгжилтэй”, “Өрөөгөө цэвэрлэх нь хөгжилтэй”, “Инээмсэглэх нь хөгжилтэй”, “Аавдаа туслах нь хөгжилтэй” гэх мэт өөр үгсийг та нар хэрэглэж болно.

Цаасан самбар Өөрийн бэлтгэсэн цаасан самбараа үзүүл. Нэг зураг руу заан “Энэ бол [хүүхдийн нэр]-ын гэр бүл. Энэ [хүүхдийн нэр]” гэж хэл. Хүүхэд бүр дээр ийн давтан хийнэ. Бид өөрсдийг маань хайрладаг гэр бүлтэй мөн тэдэндээ хайртай гэдгийг онцгойлон хэл. Цаасан самбараа долоо хоног бүр ил тавьж гэр бүлийнх нь талаарх асуултыг хүүхдүүдээс асуу ([хүүхдийн нэр]-н гэр бүл хаана байна вэ?) “[Хүүхдийн нэр] хаана байна вэ?” “Аав нь хаана байна вэ?” гэх мэт). Балчир хүүхдийн ангид шинээр хүүхэд элсэж орох бүрт зургийг нь цаасан самбар дээр наагаарай.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлтгэл: Балчир хүүхдийн ангийн хичээл эхлэхээс өмнө бэлтгэлээ хийвэл хүүхдүүдийг ирэхэд тэдэнд анхаарал тавих боломжтой болно. Тэднийг инээмсэглэн угт. (*Teaching, No Greater Call,* 79-р хуудсыг үзнэ үү.)

Давтан хийх: Балчир хүүхдийн ангийн хүүхдүүдэд заах хамгийн чухал арга замуудын нэг нь давтан хийх явдал юм. Хүүхдүүд нэг ижил дуу, түүхийг дахин дахин сонсох дуртай байдаг. Давтах бүртээ ижил үгсийг хэрэглэ.

Би гэр бүлдээ хайртай



12 БИ ГЭР БҮЛТЭЙГЭЭ ХАМТ ЗАЛБИРЧ ЧАДНА

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Аврагч "[Гэр бүлүүд] тань адислагдаж болохын тулд гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж залбир" гэж хэлсэн (3 Нифай 18:21). Гэр бүлүүд хамтдаа залбирснаар Тэнгэрлэг Эцэгт болон бие биедээ илүү ойр дотно болж мөн Ариун Сүнсийг гэр орондоо урьдаг (С ба Г 19:38-ыг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- 106-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.
- Мормоны номоо авчир. 3 Нифай 18:21-ийг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу Хэд хэдэн удаа хүүхдүүдээс "гэр бүлийн залбирал" гэж хэлэхийг хүс. Гэр бүлийн залбирлын талаар дуу сурах гэж байгаагаа тэдэнд хэл. Хүүхдүүдтэй хамт тойрч зогсоод гар гараасаа хөтөл. "Гэр бүлийн залбирал" (*Хүүхдийн дууны ном,*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан хэлээд хүүхдүүдийг өөртэйгөө хамт үйл хөдлөл хийхэд тусал:

Тойрон суугаад *(тойрон алх)*
Гэр бүлээрээ Түүнд, *(алхахаа болиод, өвдөглөнө; өөрийгөө дагуулан "гэр бүлийн залбирал" гэж хүүхдүүдээр хэлүүл)*
Бурхан Эцэгтээ *(гараа урдаа тэвэрнэ)*
Тийн хайрлах адислалд нь талархаад хамт залбирья.

Зураг Гэр бүлээрээ залбирч байгаа зургийг үзүүл (54-р хуудас). Гэр бүлийн гишүүдийн хэн болохыг хэлэхэд нь хүүхдүүдэд тусалж, тэд өвдөглөж суугаад гараа цээжиндээ тэврэн толгойгоо бөхийн мөн нүдээ аньсан байхыг хэл. Энэ гэр бүл нь гэр бүлийн залбирал хийж байна гэж тэдэнд хэл. Хүүхдүүдийг "гэр бүлийн залбирал" гэж хэлэхийг хүс. Тэднийг өвдөглөж суун гараа цээжиндээ тэврээд мөн толгойгоо бөхийлгөхийг хүс. Бид гэр бүлийн залбирал хийх үедээ Тэнгэрлэг Эцэгтэй ярьдаг гэдгийг тайлбарлаж өг. Бидэнд өгсөн адислалын төлөө Түүнд бид талархаж, гэр бүлд маань тусалж мөн адислахыг гуйдаг.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтаж мөн хүүхдүүдийг өөртэйгөө хамт хэлэхийг хүс:

Энэ бол миний ээж. Тэр надад тоглоход тусалдаг. *(эрхий хуруугаа гозойлгоно)*
Энэ бол миний аав. Тэр өдөржингөө ажилладаг. *(долоовор хуруугаа гозойлгоно)*
Энэ бол миний ах. Тэр чадалтай бас их өндөр. *(дунд хуруугаа гозойлгоно)*
Энэ бол миний эгч. Тэр бөмбөгөөр тоглох дуртай. *(ядам хуруугаа гозойлгоно)*

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуу: Дуу эсвэл шүлэгт үйл ажиллагааг хийхийн тулд үгс болон үйл хөдлөлийг хичээлээс өмнө цээжил. Дуулж эсвэл үгсийг давтахдаа үг, үйл хөдлөл бүрийг чухалчлан үз. Ямар ч дуу, шүлэгт үйл ажиллагаанд энгийн, зохистой үйл хөдлөл нэмбэл хүүхдүүдийн анхаарлыг татаж, сайн сурахад нь туслах болно. (*Teaching, No Greater Call,* 159-ийг үзнэ үү.)

Жаахан хүүхдүүдийн анхаарал богино хугацаанд төвлөрдөг. Бүх үйл ажиллагааг дүүсахаас өмнө хүүхдүүдийн анхаарал сарниж эхэлбэл хичээлээ түр завсарлуулан хүүхдүүдийг босгож явуулан, хөдөлгөөн хийлгэж болох ба хэсэг хугацааны дараа хичээлээ үргэлжлүүлж болно.

Судрууд: Хүүхдүүдэд заахдаа мөн заахад бэлтгэхдээ судруудыг ашигла. Энэ нь Сүнсийг урьдаг ба Бурханы үгийг хайрлах хайр хүүхдүүдэд бий болоход тусалдаг. Та нарын тэдэнд заах байгаа зүйлс судруудаас ирдэг болохыг харуул.

Энэ бол би; Би баяртай байна *(чигчий хуруугаа өргө)*
Манай гэр бүл залбирахаар өвдөглөн суудаг гэж хэлнэ.
(гараа атгана)

Судар 106-р хуудсан дахь Есүс Христийн зургийг харуул. Мормоны Номоос 3 Нифай 18:21–ийг нээн "'Гэр бүлдээ залбир хэмээн Есүс хэлсэн" гэж хэл. Энэ өгүүлбэрийг цөөн үгээр тасалж өөртэйгөө хамт давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Дүгнэлт "Би гэр бүлтэйгээ залбирч чадна" гэдэг үгсийг цөөн үгээр хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Цаасан хүүхэлдэй ашиглан түүх ярих:* 59-р хуудсан дахь цаасан хүүхэлдэйнүүдийн дүрсийг хувилуулж мөн хайчил. Хүсвэл тэдгээрийг будаж болно.

Ууттай тоглоомонд: Дөрвөн жижиг уутан дээр "Бид хүлээн авсан адислалуудаа талархдаг" гэж бич. Уут бүрт бид өөрсдийн талархаж байдаг зүйлсийн зургийг хийнэ (хоол, хувцас, гэр орон, гэр бүл гэх мэт). Хүсвэл 55-р хуудасны эсвэл энэхүү гарын авлагын аль ч зургийг сонгон олшруулж болно.

Будах үйл ажиллагааны: 55-р хуудасны зургийг хүүхэд бүрт зориулан олшруул. Хайч, наадаг цаас авчир.

Цаасан хүүхэлдэй ашиглан ярих түүх Гэр бүлийн залбирлын талаарх дараах түүхийг хэлж өгөхдөө цаасан хүүхэлдэйнүүдийг хэрэглэ:

Энд нэг гэр бүл байна. Энэ аав нь, энэ бол ээж нь. Энэ эгч нь, энэ бол ах нь. Энэ бол бага дүү Петр *(нялх хүүхдийн зурагтай хүүхэлдэй рүү заана.)* Нэг өдөр Петр тоглож байгаад нүдээ өвтгөсөн *(хүүхдүүдээс гараараа нүдээ таглахыг хүс).* Аав ээж хоёр нь түүнийг эмчид аваачиж үзүүлсэн *(хүүхэлдэйг хуруунаасаа аван шалан дээр тавь).* Петрийн гэр бүл, гэр бүлээрээ залбирахаар өвдөглөн суусан *(хүүхдүүдээс өвдөглөж суухыг хүс).* Тэд Петрийг адислаач гэж Тэнгэрлэг Эцэгээс гуйсан. Тэнгэрлэг Эцэг тэдний залбирлыг сонссон. Тэрээр Петрийг эдгэрэхэд тусалсан *(хүүхэлдэйгээ хуруундаа буцааж хий).* Тэгээд Петр болон түүний гэр бүл дахин гэр бүлийн залбирал хийж Петрийг адисалсанд нь Тэнгэрлэг Эцэгт талархаж байгаагаа хэлсэн.

Ууттай тоглоом Уутнуудыг шалан дээр тавь. Хүүхэд бүрийг гар гараасаа хөтлөн уутнуудыг тойрч зогсоод "Гэр бүлийн залбирал" дууг дуулах хооронд тойрон алхахыг хүс. Тэгээд алхахаа завсарлан хүүхдээр нэг уут сонгуулж доторх зургийг нь үзүүл. "Бид [зураг дээрх зүйлийг нэрлэ] төлөө талархдаг" гэж хэл. Хүүхдүүдийг оролцож байгаагийнх нь төлөө магтаарай. Оролцох хүсэлтэй хүүхэд бүр ээлжлэн хийтэл үргэлжлүүлэн давтан хий.

Будах 55-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж дуусаны дараа шулуун зураасын дагуу хайчлан хүүхэд бүр гэр рүүгээ авч явахаар хооронд нь наадаг цаасаар холбон нааж гинж мэт болгоно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүүхэлдэйнүүд: "Хичээлийн хэсгийг эсвэл түүхийг жүжиглэн үзүүлж, хүүхдүүдийг ангид нь урих, заавархлах, дуу дуулах, жүжиглэх, асуулт асуух эсвэл хүүхдүүдийг анхааралтай байх зэрэгт нь туслахын тулд хүүхэлдэйнүүдийг ашиглаж болно" (*Teaching, No Greater Call,* 176–177).

Ууттай тоглоом: Уут байхгүй тохиолдолд зургуудыг доош харуулан тавиад хүүхдийн сонгосныг эргүүлэн дээш харуулна.

Тайлбар: Хайч мөн өөр бусад аюултай зүйлсийг хүүхдээс хол байлга.

之典
李福子
聚繇之本

Би гэр бүлтэйгээ залбирч чадна.



Бид гэр бүлийнхээ төлөө талархдаг.



Бид гэр орныхоо төлөө талархдаг.



Бид идэх хоолныхоо төлөө талархдаг.

Бид хувцасныхаа төлөө талархдаг.

13 МИНИЙ ГЭР БҮЛ ҮҮРД ХАМТДАА БАЙЖ ЧАДНА

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Тэнгэрлэг Эцэг, гэр бүлийн харилцааг энэ амьдралын дараа үргэлжлэх боломжтой болгосон юм. Хэрэв гэр бүлийн гишүүд ариун сүмд лацдагдан холбогдож, зарлигуудыг итгэлтэйгээр дагавал тэд гэр бүлээрээ мөнхөд нэгдэж мөн Тэнгэрлэг Эцэгийн дэргэд амьдарч чадна. (Матай 16:19; С ба Г 138:47–48-ыг үзнэ үү.)

БЭЛТГЭЛ

Боломжтой бол өөрийн бүс дэх ариун сүмийн зургийг авчир.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг Өөрийн бүсэд байрладаг ариун сүмийн зургийг үзүүл (эсвэл 58-р хуудасны зургийг үзүүл). Энэ бол ариун сүмийн зураг гэж хүүхдүүдэд хэлж өг. Дээврийн үзүүр, цонх, хаалга гэх мэтийг нарийвчлан зааж уг зургийг тайлбарла. Тэднээс "ариун сүм" гэдэг үгийг хэд хэдэн удаа давтан хэлэхийг хүс. Толгой дээрээ ариун сүмийн шовх дээврийг дүрслэн гар гараасаа барьж сайхан ариун сүм мэт дүр үзүүл гэж хэл.

Дуу Хүүхдүүдээс босч зогсохыг хүс. "Би Ариун сүм харах дуртай" (*Хүүхдийн дууны ном,*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Би ариун сүм харах дуртай. *(хуруунуудаараа дээврийн шовх үзүүрийн дүрсийг гаргана)*
Ариун Сүнсийг мэдэрч, *(гараа зүрхэн дээрээ тавь)*
Сонсож, залбирахаар
Би нэгэн цагт тэнд очно (дороо алхална) *(гараа урдаа тэвэрнэ)*

Ариун Сүм бол Их Эзэний өргөө гэж хүүхдүүдэд хэл. Тэднийг "Их Эзэний Өргөө" гэж хэлэхийг хүс. Ариун сүм бол маш онцгой газар; ариун сүм байдаг болохоор гэр бүлүүд үүрд хамтдаа байж чадна гэдгийг чухалчлан хэлж өг.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хэлж хүүхдүүдээс өөртэйгөө хамт хийхийг хүс:

Энэ бол ээж. *(гараа өргөн; эрхий хуруу руугаа заа)*
Энэ бол аав. *(долоовор хуруу руугаа заа)*
Энэ бол өндөр ах. *(дунд хуруу руугаа заа)*
Энэ бол эгч. *(ядам хуруу руугаа заа)*
Энэ бол нялх хүүхэд. *(чигчий хуруу руугаа заа)*
Өө, бид бүгдэд нь хэчнээн хайртай гээч. *(хоёр гараа цээжин дээрээ тавь)*

Дуу "Гэр бүлүүд үүрд хамт байх болно" (*Хүүхдийн дууны ном*) дууны дахилтын эхний хоёр мөрийг дуул эсвэл давтан хэл:

Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөснөөр
Гэр бүлүүд үүрд хамт байх болно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Тайлбар: Энэхүү хичээлийн явцад хүүхдүүдийн гэр бүл ба гэр орны нөхцөл байдлыг ойлгон мэдрэмжтэй хан д.

Дуу: Хүүхдүүдийн дуулах дуртай дууны жагсаалтыг гарган долоо хоног бүр балчир хүүхдийн ангийн хичээлийн туршид дуулах талаар бодож үзээрэй. Жишээлбэл: хүүхдүүдийг тоглоомоор тоглож байхад, зууш идэхийн өмнө эсвэл дараа нь, хүүхдүүдийг аав ээжээ хүлээж байх хооронд тэдгээр дуунуудыг дуулж болно. Энэ нь өмнөх хичээлүүдийг давтах сайн арга юм.

Дүгнэлт: Дүгнэлт нь маш товч, тодорхой байж болно. Жишээлбэл: "Би ариун сүмд хайртай! Гэр бүлүүд үүрд хамтдаа байж чадна гэдгийг би мэднэ."

Энэхүү хоёр мөрийг өөртэйгөө хамт хэд хэдэн удаа удаанаар давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Дүгнэлт Ариун сүмийн талаарх сэтгэгдлээ товчхон хуваалц. Гэр бүлүүд үүрд хамтдаа байж чадах талаар гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Шүлэгт үйл ажиллагаанд:* 59-р хуудсан дахь дүрсүүдийг хувилуулж мөн хайчилж ав эсвэл 12-р хичээлд зориулан хийсэн дүрсүүдийг ашигла. Хүсвэл дүрсүүдийг буд.

Таах тоглоомонд: 51-р хуудасны гэр бүлийн зургийг хувилан, хайчил эсвэл 11-р хичээлд зориулан бэлтгэсэн зургийг ашигла. Уг зургуудын дээр тавьж халхалж болох хөнжил эсвэл даавуу гэх мэт зүйлийг авчир. Боломжтой бол өөрийн бүс дэх ариун сүмийн зургийг авчир.

Будах үйл ажиллагаанд: 59-р хуудсан дээрх дугуй дүрсүүдийг хүүхэд бүрт зориулан хувилж мөн хайчил. Хүзүүний зүүлт хийхийн тулд хоёр дугуй дүрсний дээд талаар утас сүвлэнэ.

Хуруугаар хийх үйл ажиллагаа Ариун Сүмд явахын тулд бид бэлтгэх ёстой гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэднийг таван хуруугаа өргөхийг хүсэн том болоод ариун сүмд явахад бэлтгэхийн тулд тэдний хийж чадах таван зүйлийг хуруугаараа тоолоход (залбирах, аав ээжийнхээ үгийг дуулгавартай сонсох, бусдыг хайрлах, сүмдээ явах, бошиглогчийг дагах гэх мэт) нь тусал. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохирно.

Шүлэгт үйл ажиллагаа 56-р хуудасны шүлэгт үйл ажиллагааг давтан хий, энэ удаа цаасан хүүхэлдэйг ашигла.

Таах тоглоом Шалан дээр ариун сүмийн зураг, хажуу талд нь гэр бүлийн гишүүдийн дүрс бүхий зургуудыг тавь (авчирсан зургаа эсвэл 58-р хуудасны зургийг ашиглаж болно). Зургуудыг бүтээлэг эсвэл даавуугаар бүтээ. Дүрсүүдээс нэгийг нь сугалж ав. Бүтээлгийг аваад аль дүрс нь байхгүйг таахыг хүүхдүүдээс хүс. Тэгээд авсан зургаа буцааж тавиад Тэнгэрлэг Эцэг хэнийг ч орхилгүйгээр бүх гэр бүлүүдийг мөнхөд хамтад нь байлгахыг хүсдэг гэдгийг хүүхдүүдэд хэл. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохирно.

Будах Өөрийн бэлтгэсэн хүзүүний зүүлтийг будахыг хүүхдүүдээс хүс. Тэднийг будаж байх хооронд ариун сүм байдаг болохоор гэр бүлүүд үүрд хамтдаа байж чадна гэсэн зарчмыг дахин зааж өгнө.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Цаасан хүүхэлдэй: Эдгээр хичээлүүдэд зориулан бэлтгэсэн зураг, цаасан хүүхэлдэй, тоглоом болон өөр бусад зүйлсийг хадгалах хэрэгтэй. Дараа дараагийн хичээлүүд болон балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед өмнө заасан зарчмуудаа давтахын тулд тэдгээрийг ашиглаж болно.

Будах: Хүзүүний зүүлтээ гэр бүлийнхэндээ үзүүлэхэд хүүхдүүдийг урамшуул. Энэ нь тэднийг сурсан зүйлээ санахад тусалж мөн хичээл дээр сурсан зарчмуудын талаар ярилцах боломжийг эцэг эхэд нь олгох болно. *Teaching, No Greater Call,* 167-г үзнэ үү.

HOLINESS TO THE LORD
THE HOUSE OF THE LORD

Эдгээр хуудсыг хувилуулан мөн дүрсүүдийг шулуун зураасын дагуу хайчил. Тасархай зураасын дагуу нугална. Тэгээд хажуу талуудыг хооронд нь наадаг цаасаар наан, доод хэсгийг онгорхой орхиж цаасан уут болгоход хүүхдүүд уутанд хуруугаа хийснээр хуруун хүүхэлдэй мэт болно.



14 БИ ДУУЛГАВАРТАЙ ДАГАНА

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Хүүхдүүддээ зарлигуудыг заах, тэдний сүнслэг хийгээд махбодын хэрэгцээг хангах мөн тэднийг аюул ослоос хамгаалах үндсэн үүрэг хариуцлагыг эцэг эхчүүдэд, Тэнгэрлэг Эцэг өгсөн юм. Тэрээр биднийг эцэг эхээ хүндэлж мөн дагахыг хүсдэг, бид тийн үйлдэх аваас Тэрээр биднийг аз жаргал болон аюулгүй байдлаар адисалдаг. Египетээс гарсан нь 20:12; Ефес 6:1–3; Колоссай 3:20; "Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг," *Ensign,* 1995 оны 11-р сар, 102–ыг үзнэ үү.)

БЭЛТГЭЛ

- Библийн судраа авчир. Ефес 6:1-ийг олоход хялбар болгож тэмдэглэнэ үү.
- Энэхүү гарын авлагын 106-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Үйл хөдлөл Хүүхдүүдээс босч зогсох, гараа өргөх, эргэх, алгаа таших, суух гэх мэт 5-6 хөдөлгөөн хийхийг хүс. Дуулгавартай сонсож байгаагийнх нь төлөө хүүхдүүдийг магт.

Зураг 62-р хуудасны зургийг нэг хүүхдээр бариул. Зураг дээр аав ээжийг нь заа. Аав ээж хоёр нь хүүхдүүдээсээ тариалангийн талбайд ажиллахыг хүсэхэд хүүхдүүд нь "Би дуулгавартай дагана" гэж хэлсэн болохыг тайлбарла. Зураг дээрх хүүхдүүдийг заан тэд аав ээждээ тусалж байгааг нь чухалчилж хэл.

Судар Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ биднийг эцэг эхээ дуулгавартай дагаасай хэмээн хүсдэг гэдгийг бид судруудаас сурдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Библийн судраас Ефес 6:1–ийг нээн "Хүүхдүүд ээ, Эзэн дотор эцэг эхээ дага. Учир нь энэ бол зөв юм" хэмээн унш. Хүүхдүүдийг "Би дуулгавартай дагана" гэж хэлэхийг хүс. (*Тайлбар:* Зарим хүүхдүүдийг зөвхөн эмээ өвөө нь эсвэл хамаатан нь өсгөн хүмүүжүүлдэг байж магад. Хичээлийн туршид иймэрхүү нөхцөл байдалд мэдрэмжтэй ханд.)

Дуу Хүүхдүүдийг босч зогсохыг хүс. "Би дуулгавартай дагана" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтаж хэлээд дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Ээж минь намайг дуудах үед *(гараа амандаа барина)*
Би даруй дуулгавартай дагана. *(дороо чимээгүй гүйнэ)*
Би хамгийн сайн бүхнийг хийхийг хүсдэг *(толгойгоо дээш доош дохино)*
Өдөр болгон, өдөр бүр.

Аав минь намайг дуудах үед *(гараа амандаа барина)*
Би даруй дуулгавартай дагана. *(дороо чимээгүй гүйнэ)*
Би хамгийн сайн бүхнийг хийхийг хүсдэг *(толгойгоо дээш доош дохино)*
Өдөр болгон, өдөр бүр.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хайр: Балчир хүүхдийн ангийнхаа хүүхдүүдийг хайрлахыг хичээ. "Бид заах байгаа хүүхдүүдээ хайрлах үед тэдний төлөө залбирдаг. . . . Илүү цаг хугацаа, хичээл зүтгэл шаардаж байсан ч бид өөрсдийн заах зүйлээ тэдний онцлогт тохируулан өөрчилдөг. Тэдний хэн нь ирээгүй, хэн нь ирснийг ажиглаж мөн анзаардаг. Хэрэгтэй үед туслахыг хүсдэг" *Teaching, No Greater Call,* 32).

Тэнгэрлэг Эцэг надад хайртай, *(өөрийгөө тэвэр)*
Өдөр бүр намайг адисалдаг. *(өөрийгөө тэврэн хоёр тал руугаа эргэнэ)*
Би хамгийн сайн бүхнийг хийхийг хүсдэг *(толгойгоо дээш доош дохино)*
Өдөр болгон, өдөр бүр.

Зураг 106-р хуудсан дээрх Есүсийн зургийг үзүүл. Есүс, Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагасан мөн биднийг дуулгавартай дагаасай хэмээн Тэрээр хүсдэг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Дүгнэлт Хэрвээ бид дуулгавартай байвал аз жаргалтай байх болно гэсэн гэрчлэлээсээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Үйл ажиллагаа:* Борооны шүхэр, гутал, малгай, хүрэм эсвэл бээлий гэх мэт өөрсдийгөө хамгаалахын тулд хэрэглэж болох хэдэн зүйлийг хайрцаг буюу сагсанд хийж авчир. Хүүхэд бүрт нэг нэгээр нь хүртээлтэй байхаар тооцон төчнөөн тооны зүйлс авчрахыг хичээ.



Цаасан хүүхэлдэй: 63-р хуудасны зургийг хүүхэд бүрт зориулж хувилуулан, хайчил. Хүүхэлдэйг хийхийн тулд саваанд эсвэл цаасан уутан дээр цавуугаар болон наадаг цаасаар наа.

Дүрд тоглох Хүүхдүүдтэй хамт дараах өгүүлбэрүүдийг хэлж мөн хий:

Ээж: “Хувцсаа өмсөөрэй” гэж байна. Хувцсаа өмсөцгөөе *(хувцаслаж байгаа дүр үзүүл).*
Аав: “Нүүрээ угаагаарай” гэж байна. Нүүрээ угаацгаая *(нүүрээ угааж байгаа дүр үзүүл).*

“Өглөөний хоолоо идээрэй”, “Унтаарай” гэх мэтээр өөр үйл хөдлөл давтан хий. Дуулгавартай дагаж байгаагийнх нь төлөө хүүхдүүдийг магт.

Үйл ажиллагаа Хайрцган дотроос нэг зүйл сонго, сонгосон зүйлээ өмсөж эсвэл хэрэглэж үзүүлэхийг нэг хүүхдээс хүс. Уг зүйл ямар хамгаалалт болдог талаар хүүхдүүдэд ярьж өг (жишээлбэл: гутал нь хөлийг гэмтэж мөн бохирдохоос хамгаалдаг; шүхэр нь биднийг бороонд норохоос эсвэл наранд халахаас хамгаалдаг гэх мэт.) Эдгээр зүйлс нь биднийг аюулгүй байлган хамгаалдаг; түүнчлэн бид эцэг эхээ дуулгавартай дагавал аюулгүй, аз жаргалтай байдаг гэдгийг тайлбарлаж өг.

Хүүхэлдэйтэй үйл ажиллагаа Өөрийн бэлтгэсэн хүүхэлдэйгээ хүүхдүүдээр будуул. Дараах жишээнүүдийг унш (эсвэл өөрөө зохио). Жишээ бүрийн дараа хүүхдүүдийг хүүхэлдэйгээ ашиглан, “Би дуулгавартай дагана” гэж хариулахыг тэднээс хүс.

Ээж: “Эгчдээ найрсаг хандаарай” гэж байна. Чи юу гэж хэлэх вэ?
Аав: “Унтах цаг боллоо” гэж байна. Чи юу гэж хэлэх вэ?
Эмээ: “Оройн хоолоо идээрэй” гэж байна. Чи юу гэж хэлэх вэ?
Багш: “Залбирахад бэлдэцгээе” гэж байна. Чи юу гэж хэлэх вэ?
Есүс: “Бие биеэ хайрла” гэж байна. Чи юу гэж хэлэх вэ?

Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохирно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Залбирал: Хүүхдийг залбирахад нь туслах шаардлагатай тохиолдолд цөөн энгийн үгсийг давтан хэлүүл. Том хүүхдүүд нь өөрсдийн үгээр залбирах чадвартай байж болно.

Хүүхдүүдийг магтах нь тэдэнд маш чухал байдаг. Тэд хайрладаг ба хайрлуулж хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэг. Тэднийг өөрсдөдөө итгэлтэй байхад тусалж, боломж гарах бүрийд хичээл зүтгэлийг нь чин сэтгэлээсээ магтан тэдэнд хайртайгаа илэрхийл.

Давтлага: Хүүхдүүдийг балчир хүүхдийн английн хичээлээсээ тараад сурсан зүйлээ аав ээждээ тайлбарлаж өгөхөд нь тусал.



15 БИ ТАЛАРХАЛТАЙ БАЙХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж тунгаан бод:

Их Эзэн "Чи Их Эзэн Бурхандаа бүх зүйлд талархах ёстой" гэж зарлигласан билээ (С ба Г 59:7). Бурханы бидэнд өгдөг олон адислалынх нь төлөө бид Түүнд талархлаа илэрхийлж байх хэрэгтэй. Бас бидэнд тусалдаг эцэг эх, багш нар, найзууд болон өөр бусдад бид талархаж байх хэрэгтэй. (Мөн Дуулал 100:3–4-ийг үзнэ үү.)

БЭЛТГЭЛ

- Лук 17:11–19-ийг уншаад, уяман өвчтэй арван хүний түүхийг товчхон ярьж өгөхөд бэлд.
- Библийн судраа авчир. Лук 17:11–19-ийг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Сургаалын заавар Тэнгэрлэг Эцэг бидэнд бие махбод, ургамал амьтан, гэр бүлүүд, Сүм гэх мэт олон адислалыг өгсөн болохыг хүүхдүүдэд хэл. Бид "баярлалаа" гэж хэлснээр Түүнд хайраа үзүүлдэг мөн бидэнд найрсаг ханддаг гэр бүл, найзууд болон бусдад бид "баярлалаа" гэж хэлдэг хэмээн тайлбарла.

Судрын түүх 66-р хуудасны зургийг үзүүл. Хүнд өвчтэй арван хүн болон Есүсийг зааж өг. Библийн судраас Лук 17:11–19-ийг нээгээд уяман өвчтэй арван хүний түүхийг хэлж өг. Дараах жишээг үзнэ үү:

Хүнд өвчтэй арван хүн байж гэнэ. Есүс тэднийг эдгээжээ *(зурган дээрээс Есүсийг олж заа)*. Тэд маш их баяртай байсан *(зурган дээрээс уяман өвчтэй хүмүүсийг заа)*. Гэтэл ганцхан хүн Есүст "баярлалаа" гэж хэлсэн *(талархсан уяман өвчтэй хүнийг зурган дээрээс олж заа)*. Бид "баярлалаа" гэж хэлж чадна *(хүүхдүүдийг "баярлалаа" гэж хэлэхийг хүс)*.

Зураг 67-р хуудасны зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгдөг бүх зүйлсийн төлөө Түүнд талархснаараа бид Түүнийг хайрлах хайраа үзүүлдэг хэмээн хүүхдүүдэд хэл. Нэг зураг руу зааж зурагтай холбоотой үйл хөдлөл хийхийг хүүхдүүдээс хүс (байшингийн дээвэр мэт гараа толгой дээрээ өргөх, модноос жимс түүгээд идэх, гутлаа өмсөж байгаа дүр үзүүлэх гэх мэт). Зураг бүрийн дагуу ийнхүү үйлд.

Дуу "Тэнгэрлэг Эцэгтээ талархъя" (*Хүүхдийн дууны ном*) дууны 1, 2 дугаар бадгийг дуулж эсвэл үгийг нь давтан дараах үйлдлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Тэнгэрлэг Эцэг минь бидэнд *(гараа тэвэрнэ)*
Бүхнийг өгсөнд баярлалаа *(гараа хоёр тал руугаа дэлгэнэ)*
Тэр бидэнд хувцас *(хувцас руугаа заа)*,
идэх хоол *(идэж байгаа дүр үзүүл)* Нүд, чих, гар, хөл өгсөн юм.
(Нүд, чих, гар, хөл рүүгээ заа)

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Цугларах үйл ажиллагаа: Нэг үйл ажиллагаанаас нөгөөд шилжихдээ байнгын хийдэг хэвшмэл, мэддэг зүйлийг хийхэд хүүхдүүдэд дотно санагддаг. Энэ нь тэднийг анхаарал тавьж мөн оролцоход тусалдаг.

Түүх: Хүүхдүүдийн ойлгох чадвар янз бүрийн түвшинд байдагт анхааралтай хан. Хэлээ хозож ярих эсвэл хэцүү үг хэрэглэхээс зайлсхий. Жишээлбэл: "уяман өвчтөн" гэж хэлэхийн оронд "хүнд өвчтэй хүмүүс" гэдэг үгс хэрэглэ.

Дүгнэлт Хүүхдүүдээс “баярлалаа” гэж хэлэхийг хүс. Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд талархаж байдаг сэтгэгдлээсээ товч хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Зурагт үйл ажиллагаанд:* Талархаж байдаг зүйлсийнхээ зургийг авчир; энэхүү гарын авлагын болон Сүмийн сэтгүүлүүд дээрх зургийг ашиглаж болно эсвэл өөрөө зурж болно.

Будах үйл ажиллагаа болон хослуулах тоглоомонд: 67-р хуудасны зургийг будуулахаар хүүхэд бүрт зориулан хувилуул. Хослуулах тоглоом тоглоход зориулж жижиг, жижгээр хайчилсан цаас эсвэл тиймэрхүү зүйлсийг хүүхдүүдэд тохируулах тэмдэг болгон хэрэглэхэд зориулж авчир; хүүхэд бүр доод тал нь дөрвөн тэмдэгтэй байхуйц хангалттай цаас авчир.

Шүлэгт үйл ажиллагаа Бидэнд өгсөн бие махбодын төлөө бид Тэнгэрлэг Эцэгтээ талархдаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг босч зогсоод дараах шүлэгт үйл ажиллагааг хамт хийхийг хүс. Үгсийн утгын дагуу үйл хөдлөл хий.

Нүдэндээ хүр, хамраа дар,
Чихээ дар, хөлийн хуруундаа хүр.
Гараа бүүр дээшээ, бүр өндөрт,
Тэнгэрийн зүг өргө.
Гараа толгой дээрээ тавь.
Чимээгүйгээр сандал дээрээ суу.

Ам руугаа заагаад “Надад ам байгаад би талархдаг” гэж хэл. Үгс болон үйл хөдлөлийг давтахыг хүүхдүүдээс хүс. Нүд, хамар, чих, гар, хөл гэх мэт үгсийг ашиглан давтан хий. Хүүхдүүдээс тэдний талархаж байдаг зүйлс юу болохыг асууж хэлсэн үгсийг хэрэглэн давтан хий.

Зургууд Өөрийн авчирсан зургуудыг хүүхдүүдэд үзүүлж яагаад эдгээр зүйлд талархаж байдгаа товч тайлбарлаж өг. Талархаж байдаг нэг зүйлээ нэрлэхийг хүүхдүүдээс хүс.

Будах 67-р хуудасны зургийн хувилбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж байх хооронд зурган дээрх жижиг зүйлсийг заан тэдний юу будаж байгааг тайлбарла. Зурган дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

Хослуулах тоглоом Хүүхэд бүрт дөрвөн ширхэг жижиг цаас өг. 67-р хуудасны зургийг үзүүлж, гэр бүлийн зураг руу заан, бичсэн зүйлийг хүүхдүүдэд уншиж өг. Хүүхдүүдийг өөрсдийн зургийн хувь дээрх гэр бүл дээр нэг жижиг цаас тавихыг хүс. Зурган дээрх үгсийг өөртэйгөө хамт хэлэхийг тэднээс хүс. Бусад зургууд дээр үүний адилаар хий.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Жаахан хүүхдүүд нь бүтэн хичээлийн туршид оролцохгүй байж магадгүй. Хэдий тийм ч хайраа үзүүлж урамшуулснаараа өөрийн хийдэг зүйлсийг дуурайж хийхийг тэдэнд та нар заах чадна. Талархсан үедээ “баярлалаа” гэж хэлж сурахад нь тэдэнд тусал. Таны үлгэр жишээ бол хамгийн хүчирхэг заах зэмсэг болж чадна. Хүүхдүүд өөрийг тань ажиглан хэрхэн хувцаслах, ямар үг хэллэг хэрэглэх, биеэ хэрхэн авч явахыг сурч байдаг. *Teaching, No Greater Call,* 109-г үзнэ үү.

Давтан хийх нь хүүхдүүдэд сурахад нь тусалдаг ба тэдэнд зугаатай байдаг. Тэд дахин дахин сонсох дуртай байдаг. Олон давтагддаг, санахад амархан богино бадгийг тэд сурч чадна.



Би гэр бүлийнхээ төлөө талархдаг.



Би хувцасныхаа төлөө талархдаг.



Би гэр орныхоо төлөө талархдаг.



Би идэх хоолныхоо төлөө талархдаг.

16 БИ "НАМАЙГ УУЧЛААРАЙ" ГЭЖ ХЭЛЭХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Буруу зүйл хийж алдаа гаргах бүртээ бид буруугаа хүлээн, засч залруулахыг хичээх ёстой (Иаков 5:16-г үзнэ үү). Бид өөрсдийгөө даруусгаж, уучлалт гуйхад бэлэн байгаа нь зүрх сэтгэлийг зөөлөж мөн биднийг Христэд ирэхэд бэлтгэдэг (3 Нифай 12:23–24-ийг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- Энэхүү гарын авлагын 106-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.
- 1 Нифай 17:7–8, 17–19, 49–55; 18:1-ийг унш. Нифай ах дүү нартайгаа усан онгоц барьдаг түүхийг товчхон ярихад бэлд.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг 106-р хуудсан дээрх Есүс Христийн зургийг үзүүл. Есүс бидэнд хэрхэн аз жаргалтай байхыг заасан гэдгийг хүүхдүүдэд хэл. Найрсаг үгс хэлэх нь биднийг бас бусдыг баяр хөөртэй болгож чаддаг; бид алдаа гаргаж эсвэл буруу зүйл хийхдээ "Намайг уучлаарай" гэсэн найрсаг үгсийг хэрэглэх хэрэгтэй. Хүүхдүүдээс "Намайг уучлаарай" гэж хэлэхийг хүс.

Дуу "Би Есүс шиг байхыг хичээнэ" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг давтан дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт үйлдэхийг хүс.

Есүс биднийг хайрласны адил бие биеэ хайрла. *(өөрийгөө тэврэн, хоёр тал руугаа эргэ)*

Бүх зүйлээрээ эелдэг байхыг хичээ. *(толгойгоо дээш доош дохино)*

Үйл болон бодолдоо дөлгөөн, хайрлаж бай, *(өөрийгөө тэврэн, хоёр хажуу руугаа эргэ)*

Эдгээр зүйлсийг Есүс заасан. *(толгойгоо дээш доош дохино)*

Судрын түүх Нифайн усан онгоц барьж байгаа зургийг үзүүлэн Нифай ах дүү нарынхаа хамт хөлөг онгоц барьсан түүхийг ярьж өг. Доорх жишээг үзнэ үү:

Энэ бол Нифай *(зураг дээр байгаа Нифай руу заа)*. Их Эзэн, Нифайд усан онгоц барь гэж хэлсэн. Усан онгоц бол том завь юм *(зурган дээрх усан онгоц руу заа)*. Эд нар бол Нифайн ах дүү нар *(зурган дээрээс тэднийг олж заа)*. Тэдний зарим нь Нифайд эелдэг бус үг хэлж усан онгоц барихад нь туслахгүй байсан. Нифай гунигтай байсан. *(хүүхдүүдээр гунигтай байгаа дүр үзүүл)*. Хожим нь Нифайн ах нар гэмшиж мөн усан онгоц барихад нь түүнд тусалсан. Тэгээд бүгдээрээ баяр хөөртэй болсон *(хүүхдүүдийг баяр хөөртэй байгаа дүр үзүүлэхийг хүс)*.

Бид "Намайг уучлаарай" гэж хэлснээр өөрсдөө баяр хөөртэй байж мөн бусдыг баяр хөөртэй байхад тусалдаг гэдгийг хүүхдүүдэд сануул. "Намайг уучлаарай" гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуунууд: Хүүхдүүдийг дуу сурахад нь туслахын тулд цөөн үгийг дуулаад хүүхдүүдээс өөрийгөө даган давтан хэлэхийг хүс. Тэгээд бүтэн мөрийг, дараа нь дууг бүтнээр нь давтан дуулуул.

Түүхүүд: Дахин давтан хийснээрээ хүүхдүүд сурч байдаг. Хүүхдүүдийн сонсох дуртай түүхийг болчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед дахин ярьж өг. Энэ нь хүүхдүүдийн сурсан зүйлийг давтах зугаатай арга юм.

Жүжиглэл Хүүхдүүдийг усан онгоц барих, мод хагалах, далайн эрэг тийш зөөх, модонд хадаас хадах, далбааг өргөх гэх мэтэд Нифайд тусалж байгаа дүр үзүүлэхийг хүс. Хүүхдүүдийг оролцоход нь туслахын тулд хөдөлгөөн хийж дуу авиа гарга.

Дүгнэлт Бид "Намайг уучлаарай" гэж хэлбэл баяр хөөртэй байдаг гэсэн гэрчлэлээсээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Таах тоглоомонд:* 71-р хуудасны зургийг хувилуулан дугуй дүрсүүдийн аль нэгийг нь хайчилж авна. Хүсвэл будаж болно. Гурван ширхэг хамрын алчуур эсвэл жижигхэн даавуу авчир.

Бугуйвчтай үйл ажиллагаа: 71-р хуудасны хүүхдийн нүүрний дүрс бүхий дугуй дүрсийг хүүхэд бүрт зориулан хувилуулан, хайчил. Хүүхэд бүрт зориулан бугуйвч эсвэл хүзүүний зүүлт хийхээр дээд талаар нь утас сүвлэ.

Таах тоглоом Гурван ширхэг хамрын алчуурыг шалан дээр тавь. Хүүхдүүдээс нүдээ дарахыг хүсээд хамрын алчууруудын нэгнийх нь дор хайчилж авсан нүүрний дүрсүүдээ нууна. Нүүрний дүрсийг олох хүртэл нь хүүхдүүдээр ээлжлэн алчуурыг сөхүүл. Тэгээд бичсэн зүйлийг нь уншаад өөртэйгөө хамт давтан хэлэхийг тэднээс хүс. Ээлжлэн хийхийг хүсэж байгаа хүүхэд бүр тоглотол тоглоомоо үргэлжлүүл.

Түүхүүд Хүүхдүүдэд "Намайг уучлаарай" гэж хэлж сурахад нь туслах хэдэн энгийн түүхийг дараах маягаар ярьж өг:

- Нэг охин, эрэгтэй дүүгийнхээ тоглоомыг авчихаж гэнэ. Тэр маш гунигтай байсан *(хүүхдүүдийг гуниглахыг хүс).* Тэгтэл эгч нь "Намайг уучлаарай" гэж хэлээд тоглоомыг нь буцааж өгсөн *(хүүхдүүдээр "Намайг уучлаарай" гэж хэлүүл).* Түүний дүү баярласан! *(хүүхдүүдийг инээмсэглүүл)*
- Нэг хүү гүйж байгаад эгчийгээ мөргөчихөж гэнэ. Түүний эгч гунигтай байсан *(хүүхдүүдийг гуниглахыг хүс)* Тэгтэл дүү нь "Намайг уучлаарай" гэж хэлсэн *(хүүхдүүдээр "Намайг уучлаарай" гэж хэлүүл).* Түүний эгч нь баярласан! *(хүүхдүүдийг инээмсэглүүл)*

Өөр жишээ ашиглан давтан хий.

Бугуйвчнууд Хүүхэд бүрт зүүх хүзүүний зүүлт эсвэл бугуйвч өг. Зурган дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Жүжиглэл: Судрын түүхийг жүжиглэн үзүүлэх нь таны заах зүйлийг хүүхдүүд ойлгож мөн санахад тусалдаг. *Teaching, No Greater Call,* 165–166-г үзнэ үү.

Сургалтын материал: Балчир хүүхдийн ангид Сүмээс хэвлэн гаргасан материалуудыг ашиглана. Хүүхдүүдээр нэмэлт зүйл хийлгэх тохиолдолд Сүмийн сэтгүүлүүдээс эсвэл энэхүү гарын авлагаас авсан түүх, тоглоом, хүүхэлдэй буюу бусад үйл ажиллагааг ашигла. Эдгээр үйл ажиллагаануудыг хэдэн удаа хийх, нэг хичээлийг хоёр эсвэл гурван долоо хоног дараалан заах эсэхээ та сонгож болно.

Давтан хийх: Хүүхдүүд аливаа нэгэн үг хэллэгийг олон дахин сонсож байвал тэдгээр нь тэдний сонсох үгсийн нэг хэсэг болдог. Хэрвээ тэд тухайн үг хэллэгийг олон дахин хэлж байвал эдгээр нь тэдний хэлэх үгсийн нэг хэсэг нь болдог.

Би "Намайг уучлаарай" гэж хэлснээрээ баяр хөөртэй байж чадна.

Би "Намайг уучлаарай" гэж хэлснээрээ баяр хөөртэй байж чадна.

Би "Намайг уучлаарай" гэж хэлснээрээ баяр хөөртэй байж чадна.

Би "Намайг уучлаарай" гэж хэлснээрээ баяр хөөртэй байж чадна.

17 БИ ХУВААЛЦАХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Есүс Христийн үнэн дагалдагчдыг өөрсдөдөө байгаа зүйлсийг бусадтай хуваалцахад бэлэн байснаар нь мэддэг (жишээлбэл, Үйлс 2:44–45; Мозая 18:28; 4 Нифай 1:3-ыг үзнэ үү). Өөрсдийн хүлээн авсан адислалыг бусадтай хуваалцсанаар бид эдгээр адислалууд нь Бурханаас ирдгийг харуулдаг ба Түүний хүүхдүүдэд өөрсдийн хайрыг үзүүлдэг.

БЭЛТГЭЛ

Хуваалцах жишээнд хэрэглэж болох ямар нэгэн энгийн зүйлийг авчир (тоглоом, ном гэх мэт балчир хүүхдийн ангид хэрэглэж болох зүйлс).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу “Би Есүс шиг байхыг хичээнэ” (*Хүүхдийн дууны ном*) дууны дахилтыг дуулж эсвэл үгсийг нь давтан хэлээд дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Есүсийн адил бие биенээ хайрла. *(өөрийгөө тэврэн, хоёр хажуу руугаа эргэ)*

Бүх зүйлээрээ эелдэг байхыг хичээ. *(толгойгоо дээш доош дохино)*

Үйлс, бодолдоо зөөлөн байж, хайраа үзүүл, *(өөрийгөө тэврэн, хоёр хажуу руугаа эргэ)*

Есүс энэ бүхнийг заасан юм. *(толгойгоо дээш доош дохино)*

Тэнгэрлэг Эцэг биднийг нэг нэгэндээ эелдэг хандаасай хэмээн хүсдэг гэдгийг хүүхдүүдэд хэл. Мөн бид хуваалцах үедээ эелдэг байдлыг харуулдаг гэдгийг тайлбарлаж өг.

Үзүүлбэр Та хэрхэн хуваалцаж болохыг суралцах гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Өөрийн авчирсан зүйлийг балчир хүүхдийн ангийн нөгөө багшид өгөхдөө “Би хуваалцах болно” гэж хэлээд тэдэнд хэрхэн хуваалцдагийг үзүүл. Хуваалцсанаар ирэх баяр хөөрийн талаар чухалчлан хэлж өг. Хүүхдүүдийг “Би хуваалцах болно” гэж хэлэхийг хүс.

Зургууд 74-р хуудасны эхний зургийг үзүүл. Зургийн зүүн гарт талд байгаа охин руу заагаад тэр тоглох дуртай нэг хүүхэлдэйтэй; найз нь тоглохоор ирэх үед охин “Би чамтай хүүхэлдэйгээ хуваалцана” гэдэг хэмээн хүүхдүүдэд хэл. Тэр хоёр баяр хөөртэй байгааг тодотгон хэл. Хүүхдүүдийг “Би хуваалцах болно” гэж хэлэхийг хүс.

74-р хуудасны хоёр дахь зургийг үзүүл. Баруун гар талд нь байгаа хүү рүү заагаад энэ хүү тоглоомоороо тоглох их дуртай, найз нь тоглохоор ирэх үед “Би чамтай тоглоомоо хуваалцана” гэдэг хэмээн хүүхдүүдэд хэлж өг. Тэд хоёулаа баяртай болдог хэмээн тайлбарла. Хүүхдүүдийг “Би хуваалцах болно” гэж хэлэхийг хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хуваалцах нь жаахан хүүхдүүдэд ихэвчлэн хэцүү байдаг. Тэд таны үлгэр жишээнээс сурах болно. Хичээлийн туршид болон балчир хүүхдийн ангид байх үедээ тэдэнд хэрхэн хуваалцдагийг үзүүлээд тэднээс багш нараа дуурайн хийхийг хүс. *Teaching, No Greater Call,* 168-г үзнэ үү. Хэрвээ тэд дурамжхан байвал хуваалцахыг албадахгүй, тэдэнд дахин харуул.

Дуу Хүүхдүүдтэй хуваалцаж байгаа дүр үзүүлэх үедээ “Хөгжилтэй” (*Хүүхдийн дууны ном*) дууг дуул эсвэл дараах үгсийг хэл. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Чамтай хуваалцах нь хөгжилтэй,
Хөгжилтэй, хөгжилтэй, хөгжилтэй!
Чамтай хуваалцах нь хөгжилтэй,
Хөгжилтэй, хөгжилтэй, хөгжилтэй!

Дүгнэлт Бусадтай хуваалцах үедээ мэдэрдэг баяр хөөрийн талаар хүүхдүүдэд ярьж өг. Биднийг хуваалцах үед Тэнгэрлэг Эцэг бас баярладаг хэмээн тайлбарла.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Зурагт үйл ажиллагаанд:* 75-р хуудасны зургийг хүүхэд бүрт зориулан хувилуул.

Шоотой тоглоомонд: 75-р хуудасны зургийг хувилж хайчил. Хүсвэл будаж болно. Тасархай зураасын дагуу нугалж шоо болгохын тулд ирмэг хэсгүүдийг наа.

Зураг 75-р хуудасны зургийг үзүүлж хүүхэд бүрт зургийн хувийг өг. Инээж байгаа хүү рүү заагаад бид бас инээмсэглэлээ хуваалцаж чадна хэмээн тайлбарла. Өөрсдөдөө байгаа зурагнаас инээж буй хүүгийн зургийг олж заахыг хүүхдүүдээс хүс. Бусад зургуудыг үүний адил давтан хий.

Шоотой тоглоом Хийсэн шоогоо орхи. Шооны дээд талд байгаа зурагтай уялдаатай энгийн үйл хөдлөлийг хүүхдүүдээр хийлгэ. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт “Би [инээмсэглэлээ, тоглоомоо, хоолоо гэх мэт] хуваалцах болно” гэж хэлэхийг хүс. “Би хуваалцах болно” гэсэн бичигтэй тал шооны дээд талд буувал хүүхдүүдтэй хамт алгаа ташин, “Би хуваалцах болно” гэж хэл. Ээлж ээлжээр хүүхэд бүр шоо хаятал үргэлжлүүл.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Би Есүсийг дагахыг,
Найрсаг мөн хайрлаж байхыг хүснэ. *(өөрийгөө тэвэр)*
Би инээмсэглэлээ хуваалцана; *(ам руугаа заан, инээмсэглэ)*
Би тоглоомоо хуваалцана. *(тоглоом өгч байгаа дүр үзүүл)*
Тэр намайг хуваалцаасай хэмээн хүсдэг.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Олшруулах : Хувилагч байхгүй тохиолдолд цэвэр цаас зурган дээрээ тавиад тосон бал эсвэл харандаагаар хуулбарлан зурж болно. Зургийг бүхэлд нь хуулбарлах гэж санаа зовох хэрэггүй; дүрс танигдахуйц байхаар л зураасуудыг дагуулан зур.

Шоотой тоглоом: Балчир хүүхдийн анги тань олон хүүхэдтэй бол шоогоо багш өөрөө орхиж хүүхдүүдээр үйл хөдлөл хийлгэж болно.

Шүлэгт үйл ажиллагаа: Хүүхдүүд энгийн хөдөлгөөнтэй дуу, шүлгэнд дуртай байдаг. Сүмээс зөвшөөрөгдсөн шүлэгт үйл ажиллагаануудыг та нар хүүхдүүдийг урих, залбирахад бэлэн болгох, сайн мэдээний зарчмуудыг сурах эсвэл хичээлд оролцоход нь туслахын тулд ашиглаж болно.

Би будгийн харандаагаа хуваалцах болно.
Би тогтоомоо хуваалцах болно.
Би инээмсэглэлээ хуваалцах болно.
Би хуваалцах болно
Би хоолоо хуваалцах болно.
Би номоо хуваалцах болно.

18 БИ БУСДЫГ ХАЙРЛАХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Бусдыг, биднээс өөр байж болох тэднийг ч хайрлах нь Аврагч Есүс Христийг дагах хамгийн чухал замуудын нэг юм (Иохан 13:34–35-г үзнэ үү). Бид найрсаг байж, тэднийг сонсож, тайвшруулж мөн үйлчилснээрээ тэдэнд хайраа үзүүлдэг. (Матай 25:34–40; Мозая 18:8–9-ийг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- Лук 10:25–37-г уншин сайн Самари хүний түүхийг энгийнээр ярихад бэлтгэ.
- Библийн судраа авчир.
- Энэхүү гарын авлагын 74-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зургууд 74-р хуудасны зургийг үзүүл. Эдгээр зургууд дээр хүүхдүүд хамтдаа эелдгээр тоглож байгааг тайлбарлан хэл. Бид бусдад найрсаг хандах үед тэдэнд хайраа үзүүлдэг.

Дуу "Есүс бүгдийг хайрла гэсэн" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан дараах үйлдлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Бүгдийг хайрлаж, найрсаг бай; *(гараа хоёр тал руугаа тэл)*
Гэж Есүс хэлсэн.
Сэтгэл тань хайраар дүүрэхэд *(гараа зүрхэн дээрээ тавь)*
Тэд таныг хайрлана. *(өөрийгөө тэвэр)*

Судрын түүх 78-р хуудсан дээрх сайн Самари хүний зургийг үзүүл. Библийн судраа нээн бусдыг хайрлах талаар Есүсийн хэлсэн нэгэн түүхийг хуваалцах гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Энгийн үг хэллэг хэрэглэн сайн Самари хүний түүхийг ярьж өг. Доорх жишээг үз:

Нэгэн өдөр нэг хүн газар хэвтэж байсан *(зурган дээрээс гэмтсэн хүнийг заа)*. Тэр гэмтсэн байсан. Хоёр хүн хажуугаар нь өнгөрсөн. Тэд түүнийг харсан боловч түүнд туслаагүй. Гурав дахь хүн ирсэн *(зурган дээрээс сайн Самари хүнийг заа)*. Тэр газар хэвтэж байгаа хүнийг хараад түүнд тусалсан. Тэр хайраа үзүүлсэн.

Дүрд тоглох Бид өөрсдийн хайраа үзүүлэх ёстой гэж Есүс хэлсэн хэмээн хүүхдүүдэд ярьж өг. Гадаа салхилж яваа мэт дүр үзүүлэхийг тэднээс хүсээд бусдад хайраа харуулж буй дүр үзүүлэх боломжуудыг тэдэнд олго. Жишээлбэл:

Салхинд гарцгаая *(дороо алхал)*. Хар даа, нэг найз маань уначихлаа. Найзыгаа босоход нь тусалцгаая *(найздаа босоход нь тусалж байгаа дүр үзүүл)*. Цааш алхая. Нэгэн цангасан найзтайгаа тааралдлаа. Найздаа уух ус өгье *(уух зүйл өгч байгаа дүр үзүүл)*. Цааш алхая. Бид аав ээжийгээ харж байна. Тэднийг тэврээд "Би танд хайртай" гэж хэлье *(өөрийгөө тэврээд, "Би танд хайртай" гэж хэл)*.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлтгэл: "Бид сайн мэдээг заах үед жинхэнэ багш нь Ариун Сүнс байдаг гэдгийг даруухнаар таньж мэдэх хэрэгтэй. Ариун Сүнсээр дамжуулан заах, гэрчилж, тайвшруулж мөн урамшуулах зэмсэг болон үйлчлэх нь бидний завшаан юм. Тийм болохоор бид Сүнсийг хүлээн авахаар зохистой байх ёстой. . . . Өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэж, заахдаа Их Эзэний оролцоог таньж мэдэх аваас та Түүний мутарт зэмсэг нь болох болно. Ариун Сүнс таны үгийг хүчирхэг болгох болно" (*Teaching, No Greater Call,* 41).

Судрууд: Хүүхдүүдэд заахдаа судраа ашигла. Судраас түүх ярьж өгөхдөө уг түүхийг өгүүлдэг хэсгийг судар дээр зааж өг. Сударт талархаж мөн хүндэтгэлтэй хандахыг хүүхдүүдэд зааж өг.

Дүгнэлт Та нар хүүхдүүдэд хайртай хэмээн чин сэтгэлээсээ хэл. Бусдад хайраа үзүүлэх үед та нар маш их баярладгаа тэдэнд хэл.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Судрын үйл ажиллагаанд:* Библийн судраа авчир. Иохан 15:12-ыг олоход хялбар болгож тэмдэглэ.

Будах үйл ажиллагаа болон зүрхний хэлбэртэй дүрстэй үйл ажиллагаанд: 79-р хуудасны зургийг хүүхдийн тоогоор хувилуул.

Судар Есүс бидэнд бие биеэ хайрла хэмээн заасан болохыг бид судруудаас сурдаг гэж хүүхдүүдэд хэл. Иохан 15:12-ыг уншаад дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Энэ бол миний тушаал,
Би та нарыг яаж хайрласан шиг *(хоёр гараа зүрхэн дээрээ тавь)*
та нар бие биеэ хайрлагтун. *(гараа хоёр тал руугаа дэлгэ)*

Будах 79-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж байх хооронд бид бүгд Бурханы хүүхдүүд бөгөөд бүгдээрээ онцгой юм гэдгийг ойлгоход тэдэнд тусал. Тэнгэрлэг Эцэг болон Есүс биднээс хүн бүрийг хайрлахыг хүсдэг хэмээн тэдэнд сануул.



Зүрхний хэлбэртэй дүрстэй үйл ажиллагаа Дараах жишээнүүдийг уншаад (эсвэл өөрөө зохиож болно) “Энэ нь хайрыг үзүүлж байна уу?” гэж асуу. Жишээ бүрийн дараа хүүхэд бүрийг зүрхний хэлбэртэй дүрсээ дээш барин “Хайр” гэж хэлэхийг хүс.

Та нар цэвэрлэхэд туслах үед.
Та нар “тэгнэ үү” болон “баярлалаа” гэж хэлэх үед.
Та нар тоглоомоо хуваалцах үед.
Та нар гэмтсэн нэгэндээ туслах үед.

Хүүхдүүдийг оролцсоных нь төлөө магтаарай. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохирно.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт: Хүүхдүүдэд хайртайгаа инээмсэглэн хэл. Тэдний нүд рүү нь хар. Таны нүүр царай болон үйл хөдлөлийн илэрхийлэл нь хүүхдүүдэд үгсээс тань илүүг хэлэх болно.

Будах: Жаахан хүүхдүүд зургаа будахдаа зураасны дотор талаар будаж чадахгүй байж болно. Тэд хуудсан дээрээ ганц хоёр зураас ч зурж болно. Тэднээс сайн будахыг хүсэлгүйгээр хичээл зүтгэл гаргасанд нь талархан магт. Энэхүү гарын авлагын зургууд нь хичээлд зааж байгаа зарчмуудыг зурган үзүүлэн болгон хүүхдүүдэд харуулах зорилготой юм.

Би бусдыг хайрлах болно



19 БИ БАЯР ХӨӨРТЭЙ БАЙЖ ЧАДНА



БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Тэнгэрлэг Эцэг маань биднийг баяр хөөртэй байгаасай гэж хүсдэг; Түүний бидэнд зориулан гаргасан төлөвлөгөө нь "аз жаргалын агуу төлөвлөгөө" гэж нэрлэгддэг (Алма 42:8). Саад бэрхшээл нь амьдралын чухал хэсэг боловч бид үүнд эерэг байдлаар хандахыг сонгож чадах ба бидний баяр хөөртэй байдал бусдыг өдрөг байхад тусалж чадна.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Түүх 82-р хуудасны зургийг нэг хүүхдээр бариул. Дараах түүхийг ярьж өг:

Мэри, ээжтэйгээ хамт салхинд алхаж байжээ *(зурган дээрээс Мэри, ээж хоёрыг заа)*. Тэдний хажуугаар өнгөрсөн зарим хүмүүс ууртай харагдаж байсан *(хүүхдүүдийг гуниглахыг хүс)*. Мэри ээжээсээ, "Энэ хүмүүс яагаад гунигтай байгаа юм бэ?" гэж асуусан. Ээж нь, "Мэдэхгүй, гэхдээ бид тэдэн рүү хараад инээмсэглэвэл тэдэнд баяр хөөртэй байхад нь тусалж магад" гэж хэлсэн. Тэд цааш алхаж байх үедээ Мэри өөрсөд рүү нь ирж байгаа нэгэн эмэгтэйг харсан. Мэри чадахынхаа хэрээр инээмсэглэсэн *(чадахынхаа хэрээр инээмсэглэхийг хүүхдүүдээс хүс)*. Уг эмэгтэй Мэригийн баяр хөөртэй царайг хараад хариуд нь инээмсэглэсэн. Мэри "Ингэж болдог юм байна!" гэж хэлсэн. Ээж нь "Бид нар баяр хөөртэй байхыг сонгохдоо бусдыг баяр хөөртэй байхад тусалдаг" гэж хэлсэн.

Хүүхдүүдийг бие бие рүүгээ харан инээхийг хүс. Тэдний инээмсэглэл, хүн бүрийг баяр хөөртэй байхад тусалдаг хэмээн тэдэнд хэлж өг. Хүүхдүүдийг "баяр хөөртэй" гэж хэлэхийг хүс.

Дуу "Инээмсэглээрэй" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг давтаад доорх үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Хэрвээ чи гунигтай царайтай байвал *(урвайн гунигтай царай харуул)*
Энэ хэвээрээ байж болохгүй. *(толгойгоо хоёр хажуу тийш сэгсэр)*
Үүнийг даруйхан өөрчлөөд
Гуниглалаа зайлуулаад инээмсэглээрэй. *(инээмсэглэсэн царай харуул)*

Хэн ч гунигтай царайнд дургүй. *(урвайн гунигтай царай харуул)*
Үүнийг инээмсэглэлээр соль. *(инээмсэглэсэн царай харуул)*
Үргэлж инээмсэглэн
дэлхийг илүү сайхан газар болго. *(толгойгоо дээш доош дохино)*

Тоглоом Хүүхдүүдийг тойруулан зогсоо. Та нар инээмсэглэлээ хуваалцахыг сурч байгаа гэж тэдэнд хэл. Нэг хүүхдийн өмнө зогсоод түүн рүү харан инээмсэглэ. Хүүхдийг инээмсэглэхийг хүс. Тэгээд "Хоёулаа инээмсэглэлээ хуваалцая" гэж хэл. Уг хүүхдийг гараас нь хөтлөөд өөр хүүхэд дээр очин инээмсэглэ. Хоёр дахь хүүхдийг эхний

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Дуу: Хүүхдүүд урьд өмнө нь харж сонсож байсан зүйлсдээ дуртай байдаг. Балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед энэхүү хичээлээр болон өмнөх хичээлүүд дээр сурсан дуунаас дуулаарай. Ийн давтан хийх нь тэднийг дуу сурч мөн та нарын заасан сайн мэдээний зарчмуудыг санахад тусалдаг.

Тоглоом: Бусад бүх үйл ажиллагааг хийдгийн адил энэхүү тоглоомыг балчир хүүхдийн ангийн хүүхдийн тооноос шалтгаалан өөрчлөөрэй. Танай ангид олон хүүхэд байдаг бол та нар нэг удаадаа хоёроос гурван хүүхэдтэй зэрэг инээмсэглэл хуваалцаж болно.

хүүхдийн гараас хөтлөн өөр хүүхэд дээр очиж инээмсэглэлээсээ хуваалцахыг хүс. Хүүхэд бүр гар гараасаа хөтөлтөл үргэлжлүүлэн хий.

Дүгнэлт Бид баяр хөөртэй байхыг сонгосноор бусдыг баяр хөөртэй байхад тусалдаг гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. Хүүхдүүдээс "Би баяр хөөртэй байж чадна!" гэж хэлэхийг хүс.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Давтан хийх үйл ажиллагаанд:* Энэхүү гарын авлагын 67-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ. Талархаж байдаг зүйлсийнхээ зурагнуудыг авчир; энэхүү гарын авлагын эсвэл Сүмийн сэтгүүлүүд дээрх зурагнуудыг, өөрийн зурсан зургийг ашиглаж болно.

Зурагт үйл ажиллагаанд: 83-р хуудасны зургийг хүүхэд бүрт зориулан хувилуул.

Дуу "Хэрвээ сайхан амьдарч байвал" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг давтан дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Хэрвээ сайхан амьдарч байвал алгаа таш. *(алгаа таш, таш)*
Хэрвээ сайхан амьдарч байвал алгаа таш. *(алгаа таш, таш)*
Хэрвээ сайхан амьдарч байвал бие бие рүүгээ инээмсэглээд. *(инээмсэглэ; царай руугаа заа)*
Хэрвээ сайхан амьдарч байвал алгаа таш. *(алгаа таш, таш)*

"Алгаа таш" гэсэн үйлдлийг "Дороо эргэ", "Өвдгөө цохь" гэх мэт үйлдлээр солин, давтан хий.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Инээмсэглэлийг хараад инээмсэглэх нь амархан. *(инээмсэглэсэн царай харуул)*
Мөн би гуниглах үедээ *(гунигтай царай харуул)*
Би инээмсэглэлээ түгээхийг хичээдэг, *(инээмсэглэсэн царай харуул)*
Мөн удалгүй би баяртай болдог! *(хоёр гараа зүрхэн дээрээ тавь)*

Дүгнэлт 15-р хичээлийн хоёр зурагтай үйл ажиллагааг давтан хий (64-65-р хуудас). Тэнгэрлэг Эцэгийн өгсөн гайхамшигтай бүх зүйлсийг санах нь биднийг баяр хөөртэй байхад тусалдаг гэдгийг тайлбарла.

Зураг 83-р хуудасны инээж-гуниглаж байгаа царайн дүрсийг хүүхэд бүрт өгнө. "Инээмсэглэл" дуугаа дахин дуулах үедээ зураг руу харахыг хүүхдүүдээс хүс. Дууны үгсийн утганд тааруулан хүүхдүүдийг гунигтай царайгаа инээмсэглэсэн болгон өөрчлөхөд нь тэдэнд тусал.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Нэмэлт үйл ажиллагаанууд: Хүүхдүүдийн сонирхол, идэвхийг хэвээр байлгахын тулд янз бүрийн заах аргыг ашигла; дуу, шүлэгт үйл ажиллагаа, тоглоом болон үйл хөдлөлийг ээлжлэн хий. Үйл ажиллагаа бүрт хоёр, гурван минутаас илүү хугацаа бүү төлөвлө. (*Teaching, No Greater Call*, 72, 89–90 үзнэ үү).

Давтан хийх: Өмнөх хичээлүүдийн үйл ажиллагаануудыг хэдэн удаа давтан хийхээ сонго. Давтан хийх нь хүүхдүүдэд зугаатай байдаг бөгөөд энэ нь тэдэнд сурахад тусалдаг.

Би баяр хөөртэй
байж чадна



20 БИ ХҮНДЭТГЭЛ БИШРЭЛТЭЙ БАЙХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Хүндэтгэл бишрэл гэдэг нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг хайрлан гүнээ хүндэлж байгааг харуулдаг. Бидний хүндэтгэл бишрэлтэй байдал сүм дээр, өөр бусад ариун газарт биеэ хэрхэн авч явж байгаагаас харагддаг ч энэ нь хичээл дээр чимээгүй, хөдөлгөөнгүй суухаас илүү утга учиртай юм. Бид илүү хүндэтгэл бишрэлтэй байхыг хичээх тусам Ариун Сүнсний нөлөөг амьдралдаа илүү ихээр мэдэрдэг (С ба Г 63:64; 84:54; 109:21-ийг үзнэ үү).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг 86-р хуудасны зургийг үзүүл. Энэхүү гэр бүл сүм дээр хүндэтгэл бишрэлтэй байна гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг "хүндэтгэл бишрэл" гэж хэлэхийг хүс. Хүндэтгэл бишрэлтэй байна гэдэг нь чимээгүйгээр Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн талаар бодно гэсэн үг гэдгийг тайлбарла. Зурган дээрх гэр бүл хүндэтгэл бишрэлтэй байгаагаа харуулж юу хийж байгааг хэлж өг. Зурган дээрх хүүхдүүдэд онцгой анхаарал хандуул.

Дадлага Бид сүм дээр ирэхдээ Тэнгэрлэг Эцэг болон Есүст хайртайгаа хүндэтгэл бишрэлтэй байснаараа харуулж чаддаг гэдгийг ойлгоход хүүхдүүдэд тусал. Сүм дээр хүндэтгэл бишрэлтэй байгаагаа харуулах арга замуудыг тайлбарлан хэлж өгөөд хүүхдүүдтэй хамт дадлага хий. Жишээлбэл:

- Бид намуухан дуугаар ярьдаг. *(намуухан дуугаар ярих дадлага хий)*
- Бид чимээгүй алхдаг. *(чимээгүй алхах дадлага хий)*
- Бид чимээгүй суудаг. *(чимээгүй суух дадлага хий)*
- Бид багшийгаа сонсдог. *(гараа чихэн дээрээ тавина)*
- Бид Есүсийн тухай боддог. *(толгой руугаа заа)*

Дуу Хүндэтгэл бишрэлтэй байгаагаа харуулах өөр нэг арга зам бол хүндэтгэл бишрэлийн дуу дуулах явдал юм гэдгийг тайлбарла. "Би даруу байхыг хичээнэ " (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан доорх үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Би Тэнгэрлэг Эцэгтээ хайртай,*(гараа зүрхэн дээрээ тавь)*
Тиймээс түүний өргөөнд *(өөр рүүгээ заа)*
Даруухан байхыг хичээнэ. *(хуруунуудаа нийлүүлэн байшингийн дээвэр мэт болго)*
Тэгснээр би Түүнд ойр байна. *(өөрийгөө тэвэр)*

Дүгнэлт Хүндэтгэл бишрэлтэй байгаад нь хүүхдүүдийг магт. Эдгээр зүйл нь биднийг болон бидний эргэн тойронд байгаа хүмүүсийг Тэнгэрлэг Эцэг, Есүсийн талаар бодоход тусалдаг хэмээн тайлбарла. Хүүхдүүдийг "Би хүндэтгэл бишрэлтэй байх болно" гэж хэлэхийг хүс. Тэднийг өнөөдөр хүндэтгэл бишрэлтэй байгаарай хэмээн хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүндэтгэл бишрэл: "[Хүүхдүүдийг] хүндэтгэл бишрэлтэй байхыг сануулах энгийн зүйлс хийхэд бэлтгэ. Хүндэтгэлтэй дуу аялж эсвэл намуухан дуулснаар, зураг үзүүлснээр, хүүхдүүдэд хүндэтгэл бишрэлтэй байхыг сануулах танил дохио зангааг ашигласнаар хүндэтгэл бишрэлтэй уур амьсгалыг дахин бий болгоно.

"Хүүхдүүдэд удаан хугацаагаар хөдөлгөөнгүй суух нь их хэцүү байдгийг сана. Сонсож мөн идэвхтэй оролцоход нь хүүхдүүдэд тусал. Тэдэнд үе үе завсарлага өг" (*Teaching, No Greater Call,* 83).

Давтах хэллэг: Зарим хүүхдүүд өөртэй тань хамт давтан хэлэхгүй байж болно. Энэ нь хэвийн асуудал юм. Тэд өөрийг тань болон бусад хүүхдүүдийг харж сонссоноор сурах болно.

Залбирал Хаалтын залбирал хийх цаг боллоо гэж хүүхдүүдэд хэл. “Та нар залбирлын туршид хэрхэн хүндэтгэл бишрэлтэй байж чадах вэ?” гэж асуу. Тэдэнд гараа урдаа тэвэрч, толгойгоо бөхийлгөн нүдээ анин залбирал хийж сурахад нь тусал. Үүнийг хийх нь Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг хайрлах бидний хайрыг харуулдаг гэдгийг хүүхдүүдэд сануул. Хүндэтгэл бишрэлтэй байгааг нь магтаарай.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Эвхдэг номонд:* 87-р хуудасны зургийг хувилуул; хүсвэл буд. Эвхдэг номын хоёр хуудсыг хийхийн тулд шулуун зураасын дагуу хайчил. Хуудсаа нугалан, зургийг халхал.

Будах үйл ажиллагаанд: 87-р хуудасны зургийг хүүхэд бүрт будуулахаар хувилуул. Шулуун зураасын дагуу хайчилж хүүхдүүдэд эвхдэг ном хийж өг.

Эвхдэг ном Өөрийн бэлдсэн хуудастай номынхоо зургийг нь халхлан харуул. Залбирлын үед хэрхэн хүндэтгэл бишрэлтэй байхыг харуулсан зурагнуудыг тэдэнд үзүүлэх гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Дээд талын хуудсыг нээн хуудасны дотор бичсэн үгсийг унш. Доод талын хуудсыг мөн үүний адил унш. Энэхүү үйл ажиллагааг дахин хий; гэхдээ энэ удаа хүүхдүүдээс толгойгоо бөхийлгөн нүдээ аньж гараа тэврэхийг хүс.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлгийг уншаад хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Тэдгээрийг нээ, хаа; *(гараа нээ, тэгээд атга)*
Тэдгээрийг нээ, хаа; *(гараа нээ, тэгээд атга)*
Алгаа таш. *(Алгаа таш)*
Тэдгээрийг нээ, хаа; *(гараа нээ, тэгээд атга)*
Тэдгээрийг нээ, хаа; *(гараа нээ, тэгээд атга)*
Гараа өвөр дээрээ тавь. *(гараа өвөр дээрээ хамтад нь тавь)*

Будах Тэдэнд зориулан бэлдсэн эвхдэг номоо хүүхдүүдээр будуул.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Магтаал: ”Хүндэтгэл бишрэлтэй зан чанарыг идэх зүйл эсвэл шагналаар бүү урамшуул. Хэн хамгаас илүү хүндэтгэл бишрэлтэй байж чадах вэ гэсэн тэмцээн зохиох хэрэггүй. Эдгээр нь буруу зүйл дээр анхаарал төвлөрөхөд хүргэдэг. Хүндэтгэл бишрэлтэй байдлын жинхэнэ шагнал болох Сүнсний нөлөө болон өсөн нэмэгдэх мэдлэгийн талаар заа” (*Teaching, No Greater Call,* 83). Тэднийг хүндэтгэл бишрэлтэй байх үед тодорхой үгс хэрэглэн хүүхдүүдийг магт; жишээлбэл: “Мэри ингэж хүндэтгэл бишрэлтэй сууж байгаад нь би дуртай байна. Баярлалаа, Мэри” гэж хэлж болно.

Будах: Хүүхдүүдийг будаж байх хоорондхичээлд зааг дсан зарчмыг давт. Зураг дээрх зүйлсийг заан тэдний юу будаж байгааг тайлбарла. Зураг дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

Залбирал хэлэх үед
би нүдээ аниад мөн

толгойгоо бөхийлгөн
гараа урдаа тэвэрнэ.

21 ИОСЕФ СМИТ, ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ БОЛОН ЕСҮС ХРИСТИЙГ ХАРСАН

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Иосеф Смит бол манай үеийн анхны бошиглогч юм. Тэрээр, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харж мөн Тэдэнтэй ярьсан. Бошиглогч Иосефоор дамжуулан Их Эзэн үнэн Сүмийг болон сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг сэргээсэн. Иосеф Смит— Түүх 1:9–19-ийг үзнэ үү.

БЭЛТГЭЛ

- Иосеф Смит—Түүх 1:9–19-ийг уншин Анхны үзэгдлийн түүхийг товчхон ярьж өгөхөд бэлд.
- Библийн судраа авчир.
- "Агуу Үнэт Сувд" судраа авчир. Иосеф Смит—Түүх 1:17–г олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Судрын түүх 90-р хуудасны зургийг үзүүлэн Анхны үзэгдлийн түүхийг товчхон ярь (Иосеф Смит—Түүх 1:9–19–ийг үзнэ үү). Доорх жишээг үзнэ үү:

Энэ бол Иосеф Смитийн зураг *(Иосефын зураг руу заана; хүүхдүүдийг "Иосеф Смит" гэж хэлэхийг хүс).* Тэр аль сүм үнэн болохыг мэдэхийг хүссэн. Тэр Библийн судраас *(Библийн судраа нээ)* үнэнийг мэдэхийн тулд залбирч болно гэж уншсан *(хүүхдүүдийг уншиж байгаа дүр үзүүлэхийг хүс).* Иосеф ойн төгөл рүү *(модод руу заа)* Тэнгэрлэг Эцэгээс залбиран асуухаар явсан. Тэрээр залбирах үедээ Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан.

Агуу Үнэт Сувд судраас Иосеф Смит—Түүх 1:17–г нээн Тэнгэрлэг Эцэг, Иосеф Смитэд юу гэж хэлснийг унших гэж байна гэж хүүхдүүдэд хэл. Тэр, Есүс Христ рүү заагаад: "Энэ бол Миний Хайрт Хүү. Түүнийг сонс!" гэж хэлсэн хэмээн тайлбарла. Есүс Христийн үнэн Сүмийг буцааж авчрах болно гэж Есүс, Иосеф Смитэд хэлсэн гэж тайлбарла.

Дасгал Энэ түүхээ дахин ярьж өг. Энэ удаа хүүхдүүдийг Ариун ойн цоорхой дахь модод мэт дүр үзүүлэн гараа дээш сунган зогсохыг хүс. Иосефын залбирсан талаар зааж байх үедээ тэд салхинд найгах модод адил хоёр тал руугаа найгахыг хүүхдүүдээс хүс. тэдэнд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ, Иосефт үзэгдсэн тухай ярих үед хөдөлгөөнгүй чимээгүй зогсохыг тэднээс хүс.

Дуу "Хаврын нэгэн сайхан өдөр" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл доорх үгсийг давтан дараах үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Хаврын нэгэн сайхан өдөр ойн цоорхойд *(гараа мод адил өргөнө)*
Иосеф залбирахад Бурхан, Есүс хоёр үзэгдсэн. *(өвдөглөн, гараа цээжиндээ тэвэр)*

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Түүхүүд: Жаахан хүүхдүүдийн анхаарал богино хугацаанд төвлөрдөг. Түүх ярьж өгөх үедээ тэднийг оролцуулах арга замуудыг төлөвлө. Жишээлбэл: та тэднээр зураг бариулж эсвэл үгсийг давтан хэлүүлж болно. Зургууд дээрх зүйлүүдийг нэг бүрчлэн заахдаа үе үе завсарлаж түүхээ үргэлжлүүлэхээс өмнө хүүхэд бүрт харж амжих хугацаа өг. *Teaching, No Greater Call,* 181-ийг үзнэ үү.

Дуунууд: "Дуу хөгжмийн аялгуу нь хүүхдүүдэд юу дуулж байгаагаа болон үгсийн захиасыг санахад тусалдаг" (*Teaching, No Greater Call,* 174). Түүнчлэн дуу хөгжим нь Сүнсийг ангидаа урих үр дүнтэй арга зам юм.

Дүгнэлт Иосеф Смит, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан гэдэг гэрчлэлээсээ товчхон хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Цаасан хүүхэлдэйтэй үйл ажиллагаанд:* 91-р хуудасны хүүхэлдэйний дүрсүүдийг хувилуулан хайчил эсвэл 9-р хичээлийн нэмэлт үйл ажиллагаанд зориулан хийсэн дүрсээ ашигла. Хүсвэл дүрсүүдээ буд.

Будах үйл ажиллагаанд: 91-р хуудасны зургийг хүүхэд бүрт будуулахаар хувилуул.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Иосеф ойд өвдөглөн сууж, *(гараа дээш өргөн модод мэт харуул)*
онцгой залбирлыг хэлсэн. *(гараа цээжиндээ тэвэр)*
Тэр, Эцэг Хүү хоёрыг харсан *(дээшээ хараад нүдээ нарнаас халхал)*
Тэгээд Тэднийг сонссон. *(гараа чихэндээ барь)*



Цаасан хүүхэлдэйтэй үйл ажиллагаа Анхны үзэгдлийн түүхийг дахин товчхон ярьж өгөхдөө энэ удаа өөрийн бэлтгэсэн хуруун хүүхэлдэйнүүдийг ашигла. Хэрвээ хүүхдүүд хүсэж байвал хүүхэлдэйнүүдийг бариул.

Будах 91-р хуудасны зургийн хуулбарыг хүүхэд бүрээр будуул. Тэднийг будаж байх хооронд Анхны үзэгдлийн түүхийг давтан хэлж өг. Зурган дээрх зүйлүүдийг зааж тэдний будаж байгаа зүйлийг хүүхдүүдэд тайлбарла. Зурган дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Гэрчлэл: Гэрчлэлээ энгийнээр, товч тодорхой хуваалц; жишээлбэл: "Иосеф Смит, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг харсан гэдгийг би мэднэ."

Цаасан хүүхэлдэй: Хэрвээ та энэ үйл ажиллагааг хийхээр сонгосон бол хүүхэд бүр өөрийн гэсэн цаасан хүүхэлдэйтэй байхаар хангалттай олныг хийх хэрэгтэй.

Том хүүхдүүд: Том хүүхдүүдээр жаахан хүүхдүүдэд Анхны үзэгдлийн түүхийг дахин яриулах талаар бодож үзээрэй. Тэдэнд цаасан хүүхэлдэйг хэрхэн хэрэглэхийг үзүүл эсвэл 42-р хуудасны зургийг ашиглан түүх ярьж өг. Хүүхдүүдийг бие биедээ заахад туслах нь тэдэнд заасан зүйлээ баталгаажуулах сайн арга юм.



Иосеф Смит, Тэнгэрлэг Эцэг болон Есус Христийг харсан

Энэхүү хуудсыг хувилуулан хүүхэлдэйнүүдийн дүрсүүдийг шулуун зураасын дагуу хайчил. Тасархай зураасын дагуу нугал. Тэгээд дүрсүүдийн хажуу талуудыг наадаг цаасаар наан доод хэсгийг нь онгорхой орхисноор хүүхдүүд хуруугаа хийн хуруун хүүхэлдэйтэй болно.



22 МОРМОНЫ НОМ НАДАД ЕСҮС ХРИСТИЙН ТУХАЙ ЗААДАГ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Мормоны Ном бол Есүс Христийн хүчирхэг гэрч юм. Энэ нь Түүний ирэлтийг урьдаас харж, номлолыг нь ойлгосон эртний бошиглогчдын гэрчлэлийг багтаадаг. Түүнчлэн амилалтынхаа дараа Тэрээр Америк тивд айлчилсан тухай цэдгийг агуулдаг (3 Нифай 11–27-г үзнэ үү). Мормоны Номын гол зорилго нь "өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан хэмээн" бүх хүмүүст итгүүлэх явдал юм (Мормоны Номын оршил хуудас; түүнчлэн 1 Нифай 13:40–41; 2 Нифай 25:26; 33:10–11-ийг үзнэ үү).

БЭЛТГЭЛ

- Энэхүү гарын авлагын 22, 94 болон 126-р хуудсуудыг олоход хялбар болгож тэмдэглэ.
- Мормоны Номоо авчир.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу "Эрэлхийлж, эргэцүүлэн бодож, залбир" (*Хүүхдийн дууны ном*) дууны дахилтыг дуулж доорх үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Эрэлхийлж, *(номоо нээж байгаа дүр үзүүл)* тунгааж, *(толгой руугаа заа)* мөн залбирна *(гараа цээжиндээ тэвэр)*
Эдгээр нь миний хийх ёстой зүйлс. *(өөр рүүгээ заа)*
Сүнс удирдан би зүрхнийхээ гүнд *(гараа цээжин дээрээ тавь)*
Судрууд үнэн гэдгийг мэдэх болно. *(толгой руугаа заа)*

Зургууд Мормоны Номыг дээш барь. Хүүхдүүдэд "Энэ бол Мормоны Ном. Мормоны Ном бидэнд Есүсийн талаар заадаг" гэж хэл. Хүүхдүүдийг "Мормоны Ном" гэж хэлэхийг хүс. Мормоны Номоо нээж өөрийнхөө өмнө тавь.

Есүсийн мэндэлсэн өдрийн зургийг үзүүл (энэхүү гарын авлагын 126-р хуудас). Мормоны Ном руу заан энэ нь Есүс Христийг энэ дэлхий дээр ирсэн талаар заадаг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Есүс Нифайчуудыг эдгээж байгаа зургийг үзүүл (94-р хуудас). Мормоны Ном руу заан энэ нь Есүс өвчтэй хүмүүсийг эдгээсэн талаар заадаг хэмээн хүүхдүүдэд хэл.

Есүс Нифайчуудын хүүхдүүдийг адисалж байгаа зургийг үзүүл (22-р хуудас). Мормоны Ном руу заан энэ нь Есүс хүүхдүүдийг адисалсан тухай заадаг хэмээн хүүхдүүдэд хэлж өг.

Дүгнэлт Хүүхдүүдээр цөөн үгээр "Мормоны Ном надад Есүс Христийн тухай заадаг" гэж хэлүүл. Мормоны Ном үнэн гэдгийг мэддэгээ тэдэнд хэл.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлтгэл: Та нар балчир хүүхдийн ангийн хичээл эхлэхээс өмнө түүх, зургууд болон тоглоомуудаа сайтар бэлдвэл хүүхдүүд илүү анхаарах боломжтой байх болно. Заахаар бэлдэж байхдаа Сүнсний удирдамжийг залбиралтайгаар эрэлхийл.

Дуунууд: Хүүхдийн дуут аль ч хичээлд танилцуулга эсвэл дүгнэлт болгон хэрэглэж болно. Хүүхдийн хэсгийн дуунууд нь хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудыг сурч санахад тусалдаг. Түүнчлэн тэдгээр нь хүүхдүүдэд гэрчлэлээ энгийнээр, сайхнаар хуваалцах боломжийг өгдөг.

Судрууд: Заах явцдаа судраа нээн түүн рүү заах нь Есүсийн талаарх түүхүүд судруудаас ирдэг юм байна гэдгийг ойлгоход хүүхдүүдэд тусална.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Ууттай тоглоомонд:* 95-р хуудасны зургийг хувилуул. Тасархай зураасыг дагуулан хайчил. Зургуудыг уут эсвэл саванд хий.

Номонд: 95-р хуудсыг хувилуулан хүүхэд бүрээр будуул.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Мормоны Номыг унш. *(гарын алгаа нийлүүлэн, ном адил нээ)*
Үүнийг өдөр бүр унш.
Суралцаж эхлэхээсээ өмнө *(толгой руугаа заа)*
Залбирахаа бүү март. *(гараа тэвэр)*

[Тэрри Кларк, "Read the Book of Mormon," *Friend,* 2004 оны 3-р сар, 11]

Ууттай тоглоом Уут эсвэл савнаас зураг сонго хэмээн нэг хүүхдээс хүс. Зурган дээр бичсэн зүйлийг хүүхдүүдэд уншиж өг. Ээлжлэхийг хүсч буй хүүхэд бүр зураг сонготол үргэлжлүүлэн хий.

Ном 95-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж байх хооронд уг зургийн талаар ярь. Зураг бүр дээр Есүсийг заа. Тэднийг дууссаны дараа тасархай зураасын дагуу нугалж ном болго. Тэгээд уг номыг хүүхдүүдэд уншиж өг.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Үйл ажиллагаанууд: Хүүхдүүдийн анхаарлыг татахын тулд янз бүрийн үйл ажиллагааг явуул. Энэ нь бусдад садаа болох зан авир гаргахаас сэргийлэх хамгийн сайн арга байж магад. *Teaching, No Greater Call,* 72–80-ыг үзнэ үү.

Жаахан хүүхдүүд амархан сатаардаг. Балчир хүүхдийн анхаарлыг нэг багшийг заах эсвэл үйл ажиллагаа явуулж байх хооронд нөгөө багш нь хүүхдүүдийн анхаарлыг үйл ажиллагаанд хандуулахад тусалж болно. Хүүхдийн гарт нь ямар нэг барих зүйл өгвөл түүнийг үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход тусалдаг.

Мормоны Ном надад Есүс Христийн тухай заадаг

Мормоны Ном Есүсийг дэлхийд ирсэн тухаар заадаг (Алма 7:10–12-ыг үзнэ үү).



Мормоны Ном Есүс хүүхдүүдийг адисалсан талаар заадаг (3 Нифай 17:21–24 -ийг үзнэ үү).



Мормоны Ном Есүс өвчтөй хүмүүсийг эдгээсэн тухаар заадаг (3 Нифай 17:7–10-ыг үзнэ үү).

23 БИ СУДРУУДАД ХАЙРТАЙ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд гэсэн дөрвөн номыг судар хэмээн хүлээн зөвшөөрдөг. Судруудын зорилго бол Есүс Христийн талаар гэрчлэн биднийг Түүнд ирж мөнхийн амьдралыг хүлээн авахад туслах явдал юм (2 Нифай 25:26; Хиламан 3:29–30-ийг үзнэ үү). Түүнчлэн судрууд нь Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагаснаар адислагдсан хүмүүсийн тухай түүхүүдийг агуулдаг. Нифай судруудад хайртайгаа: "Дотоод сэтгэл минь судруудад баясна, мөн зүрх минь тэдгээрийг тунгаана" хэмээн илэрхийлсэн (2 Нифай 4:15).

БЭЛТГЭЛ

- Марк 10:13–16 болон 1 Нифай 17:7–10; 18:1–4-ийг унш. Эдгээр түүхийг хүүхдүүдэд товчхон ярьж өгөхөд бэлд.
- Судраа авчир.
- Энэхүү гарын авлагын 70-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Сургаалын заавар Хүүхдүүдэд судраа харуулан тэрхүү сударт хэр их хайртайгаа хэл. Хүүхдүүдийг "судрууд" гэж хэлэхийг хүс. Бид судруудаас Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тухай сурдаг; Тэд бидэнд хайртай мөн биднийг аз жаргалтай байгаасай хэмээн хүсдэг гэдгийг сурдгаа тэдэнд хэл.

Судрын түүхүүд 98-р хуудасны зургийг үзүүлэн Есүсийн зураг руу заа. Судруудад Есүсийн талаар заадаг хэмээн тайлбарла. Библийн судраа нээж Есүсийн хүүхдүүдийг адисалж байгаа түүхийг товчхон ярьж өг. (Марк 10:13–16-г үзнэ үү). Доорх жишээг үзнэ үү:

> Есүс хүүхдүүдэд хайртай. Нэгэн өдөр, хэдэн хүмүүс хүүхдүүдээ Есүс дээр авчирсан *(зурган дээрх хүүхдүүдийг заа)*. Тэр тэднийг гартаа аван, адисалсан.

70-р хуудасны зургийг үзүүл. Судруудад Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагаснаар адислагдсан хүмүүсийн тухай өгүүлдэг хэмээн тайлбарла. Мормоны Номоо нээн Нифайн усан онгоц барьдаг түүхийг товчхон ярьж өг (1 Нифай 17:7–10; 18:1–4-ийг үзнэ үү). Доорх жишээг үзнэ үү:

> Энэ бол Нифай *(зурган дээрээс Нифайг заа)*. Их Эзэн Нифайд усан онгоц барь гэж хэлсэн. Нифай өмнө нь хэзээ ч усан онгоц барьж байгаагүй, гэхдээ тэр дуулгавартай дагасан. Их Эзэн түүнд усан онгоц хэрхэн барихыг үзүүлсэн. *(Хүүхдүүдийг усан онгоц барьж байгаа дүр үзүүл гэж хэл)*

Дуу "Эрэлхийлж, эргэцүүлэн бодож, залбир" дуу *(Хүүхдийн дууны ном)* -оос дуулж доорх үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг урь.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Судрууд: "Хүүхдүүдэд заах үедээ, та нар судруудыг олонтоо ашиглаж мөн хүүхдүүд судруудыг ашиглаж сурах арга замыг олох хэрэгтэй" *Teaching, No Greater Call,* 59). Судрууд дээрх хүмүүс болон түүхүүдийг мэддэг болоход тэдэнд тусал. Та нарын заах байгаа зүйлс нь судруудаас ирж байгааг олж харахад нь тэдэнд тусал.

Дуунууд: Хүүхдүүдэд дуулж, шүлэг уншиж өгч байхдаа үгс болон үйл хөдлөлийг нь заахаасаа өмнө тогтоон цээжлээрэй. Энэ нь тэдэн рүү харж үйл ажиллагаа хийх дуртай байгаагаа харуулах боломжийг та нарт олгох болно.

Эрэлхийлж, *(судар нээж байгаа дүр үзүүл)* тунгааж мөн залбир *(гараа цээжиндээ тэвэр)*
Эдгээр нь миний хийх ёстой зүйлс. *(өөр рүүгээ заа)*
Сүнс удирдан би зүрхнийхээ гүнд
судрууд үнэн гэдгийг мэдэх болно. *(нээлттэй ном барьж байгаа дүр үзүүл)*

Дүгнэлт "Би судруудад хайртай" гэдэг үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Судруудад хайртайгаа мөн тэдгээр нь үнэн гэсэн гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Цаасан хүүхэлдэйтэй үйл ажиллагаанд:* 99-р хуудасны дүрсүүдийг хүүхэд бүрт болон өөртөө зориулан хувилуулан хайчил. Саваан дээрх хүүхэлдэйг хийхийн тулд дүрс бүрийн ард саваа наа.

Цаасан хүүхэлдэйтэй үйл ажиллагаа Хайчилж авсан дүрсээ хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж дууссаны дараа Адам ба Ева гэсэн дүрсээ дээш барин мөн хүүхдүүдийг өөрсдийн дүрсээ дээшээ барихыг хүс. Хүүхдүүдийг "Адам ба Ева" гэж хэлэхийг хүс. Хуучин Гэрээ судраа нээн Адам Ева хоёр дэлхий дээрх анхны хүмүүс байсан ба тэд Едений цэцэрлэгт амьдарч байсан гэдгийг судрууд бидэнд хэлдэг болохыг хүүхдүүдэд ярьж өг. Хүүхдүүдийг цаасан дүрсээ цэцэрлэгт алхуулж байгаа дүр үзүүл гэж хэл.

Ноаг төлөөлөх цаасан дүрсээ дээш өргөн мөн хүүхдүүдийг өөрсдийн дүрсээ дээш өргөхийг хүс. Тэднээс "Ноа" гэж хэлэхийг хүс. Ноа усан онгоц барьж түүндээ амьтдыг цуглуулсан гэж судруудад хэлдэг тухай тэдэнд ярь. Хүүхдүүдийг амьтны дүр үзүүл гэж хэл.



Мосег төлөөлөх цаасан дүрсээ дээшээ бариад мөн хүүхдүүдийг өөрсдийн дүрсээ дээш барихыг хүс. Тэднээс "Мосе" гэж хэлэхийг хүс. Их Эзэн Мосед арван зарлиг өгсөн гэж судруудад заадгийг тэдэнд хэл. Арав хүртэл тоолох үедээ хүүхдүүдийг арван хуруугаа өргөхийг хүс.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан мөн хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Надад судруудыг заагаач; *(судар уншиж байгаа дүр үзүүл)*
Тэд надад үнэнийг хэлдэг. *(өөр рүүгээ заа)*
Бошиглогчид хэрхэн дуулгавартай дагадгийг заадаг.
Надад судруудыг заагаач; *(судар уншиж байгаа дүр үзүүл)*
Би үнэнийг мэдэх ёстой. *(өөр рүүгээ заа)*
Би замыг мэдэж болохын тулд надад заагаач.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Будах: Хүүхдүүдийг будаж байх хооронд зурган дээрх хүмүүсийн талаар тэдэнд ярьж өг. Судруудад Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагасан эдгээр хүмүүс болон өөр бусад хүмүүсийн талаар үнэн бодит түүхүүдийг өгүүлдэг хэмээн тайлбарла.

Хэрвээ хүсвэл хүүхдүүд зурагнуудыг будаж дууссаны дараа саваанд тогтоосон цаасан дүрсийг хураан авч болно. Эсвэл хүүхдүүдэд зургуудыг гэр рүү нь өгч явуулан аав ээжээр нь гүйцээн будуулж болно.

Шүлэгт үйл ажиллагаа: Балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед хүүхдүүд хөдлөх хэрэгтэй байвал эсвэл тэдний анхаарлыг татах хэрэгтэй бол шүлэгт үйл ажиллагааг хийж болно. Тэдгээр нь өмнө заасан зарчмуудаа давтах сайн арга юм.



Адам ба Ева

Ноа



Мосе

24 БИ БОШИГЛОГЧИЙГ ДАГАХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Бошиглогч бол Бурханаас, Өөрийг нь төлөөлөн ярихаар дуудагдсан хүн юм. Бошиглогчид илэрхийллээр Бурханы үгийг хүлээн авдаг бөгөөд хүмүүст тэдгээрийг номлохоор зарлигдуулсан байдаг (Амос 3:7; 1 Нифай 22:2; С ба Г 1:38; Библийн Толь Бичиг, "Бошиглогч," 754). Бид амьд бошиглогчдоор удирдуулахаар адислагдсан юм. Эрт цагийн бошиглогчдын адил өнөөгийн бошиглогчид Есүс Христийн талаар гэрчилж Түүний сайн мэдээг заадаг. Тэдний заадаг зүйлс нь Их Эзэний оюун санаа болон хүсэл билээ.

БЭЛТГЭЛ

Боломжтой бол Сүмийн өнөө үеийн бошиглогчийн зургийг авчир.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Тоглоом Хүүхдүүдийг өөртэйгөө хамт "удирдагчийг дага" гэдэг тоглоом тоглохыг хүс. Алхах, алгаа таших эсвэл өөр хөдөлгөөн хийх нэг хүүхдийг сонго. Бусад хүүхдүүдэд нь эхний хүүхдийг дагаж түүний хийж байгаа үйлдлийг хий гэж хэл. Удирдагч болохыг хүссэн хүүхэд бүр ээлжлэн хийж дуустал үргэлжлүүл. Хүүхдүүдийг хичээлийн хэсэг рүү өөрийг тань даган явахыг хүсээд тэднийг суухыг урь.

Сургаалын заавар Бидний дагадаг онцгой удирдагч, бошиглогч байдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Бошиглогч бол Бурхантай ярьдаг хүн бөгөөд Бурхан бошиглогчид бидний юу хийх ёстойг хэлж өгдөг хэмээн тайлбарла. Хэрвээ бид бошиглогчийг дагавал аз жаргалтай байж мөн Тэнгэрлэг Эцэг биднийг адислах болно гэж хүүхдүүдэд хэл. Бошиглогчийг дагана гэдэг нь түүний бидэнд хий гэж хэлсэн зүйлсийг хийхийг хэлдэг гэж тайлбарла.

Зургууд Иосеф Смитийн зургийг үзүүл (102-р хуудас). "Энэ бол Бошиглогч Иосеф Смит. Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ, Иосеф Смиттэй ярьсан" гэж хэл. Уг зургийг нэг хүүхдээр бариул. Бошиглогч Иосеф Смитийн бидэнд хий гэж заасан нэг зүйлийг, тухайлбал судар унш гэх зэргийг хүүхдүүдэд хэлж өг. Хүүхдүүдийг судар уншиж байгаа дүр үзүүлэхийг хүсээд мөн тэднээс "Бошиглогчийг дага" гэж хэлэхийг хүс. Зургийг өөр нэг хүүхдэд бариулаад үйл ажиллагааг давтан хийхдээ уг бошиглогчийн заасан өөр нэг зүйлийг залбирах, сайн хоол идэх гэх мэт үйлдлийг хий. Үйл хөдлөл бүрийн дараа хүүхдүүдээр "Бошиглогчийг дага" гэж хэлүүл. Хүүхэд бүр зураг барих боломжтой болох хүртэл үргэлжлүүлэн хий.

Боломжтой бол Сүмийн одоогийн Ерөнхийлөгчийн зургийг үзүүл. Хүүхдүүдэд түүний нэрийг хэлээд, бидэнд хий гэж заасан зүйлсээс нь заримыг хэлж өг. Бид эдгээр зүйлсийг хийх үед адислагдах болно гэдгийг тайлбарла.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Багшид зориулсан танилцуулга: Хичээлд бэлтгэхийнхээ өмнө өөрийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэх цаг гарга. Жишээлбэл: та хичээлийн эхэнд байгаа танилцуулгыг болон жагсаасан судруудыг уншиж болно. Хичээл дээр судлах сургаалын талаар суралцах нь хичээлд бэлдэх, хүүхдүүдэд заах явцдаа Сүнсний өдөөлтийг хүлээн авахад та нарт туслах болно. *Teaching, No Greater Call,* 14-г үзнэ үү.

Дүрд тоглох Бошиглогчийг дагаж болох арга замуудыг жүжигчлэн үзүүлэхийг хүүхдүүдээс хүс.

Дуу “Бошиглогчийг дага” (*Хүүхдийн дууны ном*) дууны дахилтыг дуулан эсвэл үгсийг нь давтах үед өөртэйгөө хамт өрөөн дотор жагсан алхахыг хүүхдүүдээс хүс:

Бошиглогчийг дага, бошиглогчийг дага,
бошиглогчийг дага; буруу зүйл бүү хий .
Бошиглогчийг дага, бошиглогчийг дага,
бошиглогчийг дага; тэр зам мэднэ.

Хүүхдүүдийг өөртэйгөө хамт дуулахыг хүс. Хүүхдүүдэд ээлж ээлжээр жагсаалыг удирдах боломж олгож давтан хий. Төөрч одох гэдэг нь буруу зүйлсийг хийх гэсэн үг гэж тайлбарла.

Дүгнэлт Бид бошиглогчийг дагаснаар адислагдах болно гэдгийг мэдэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдээс цөөн үгээр “Би бошиглогчийг дагах болно” гэж хэлэхийг хүс.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Дүрстэй үйл ажиллагаа болон таах тоглоомонд:* 103-р хуудасны зургийн дүрсийг хувилуулж мөн хайчил. Хүсвэл буд. Босоо байрлуулж болох дүрсүүдийг хийхийн тулд дүрсээ тасархай зураас дагуулан нугал.

Будах үйл ажиллагаанд: 103-р хуудасны дүрсүүдийг хүүхэд бүрт будуулахаар хувилуулж мөн хайчил.

Зургийн дүрс Эрт дээр үед амьдарч байсан зарим бошиглогчдын талаар сурч авахад нь туслах гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Босоо байрлалд байлгах дөрвөн дүрсийг шалан дээр эсвэл ширээн дээр тавь. Дөрвөн хүүхдээр дөрвөн дүрсээ сонгуулан бариул. Хүүхдүүдэд бошиглогчийн нэрийг хэлээд бичсэн зүйлийг уншиж өг. Бичсэн зүйлсээс “залбирах”, “баптисм”, “дуулгавартай дагах” болон “судрууд” гэх мэт түлхүүр үгсийг нь хүүхдүүдээр давтуулан хэл. Ээлжлэхийг хүсч буй хүүхэд бүр хийтэл давтан хий.

Таах тоглоом Босоо дүрсүүдийг өрөөний хаа нэгтээ тавих үедээ хүүхдүүдээс нүдээ таглан эсвэл буруу харж зогсохыг хүс. Тэдгээрийг хялбархан олдох газар байрлуул. Хүүхдүүдээс уг дүрсүүдийг хайж олохыг хүс. Тэдгээрийг олсных нь дараа хичээл хийж байгаа газраа авчруул. Хүүхдүүдэд уг бошиглогчийн нэрийг хэлээд дор нь бичсэн зүйлийг тэдэнд уншиж өг. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохиромжтой.

Будах 103-р хуудасны дүрсүүдийн хувилбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж дуусмагц тасархай зураасуудын дагуу нугалж босоо байрлалтай дүрсүүдийг хүүхдүүд гэр рүүгээ авч явахад зориулан хий. Балчир хүүхдийн ангид уг дүрснүүдийг хийх цаг хангалтгүй үед хүүхдүүдийн эцэг эхээс гэртээ хийж өгөхийг хүс.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Нэмэлт үйл ажиллагаануудыг хүсвэл хичээл дээрээ нэмэлт болгон ашиглаж болно. Хичээлийн үзүүлэн хийхэд шаардлагатай материалууд олдохгүй тохиолдолд ижил төстэй зүйлсээр орлуулж болно.

Дүрсүүд: Эдгээр бошиглогчдын талаарх түүхийг хүүхдүүд сонсох дуртай байж магад. Даниел 6:4–23 (Даниел арслангийн үүрэнд), Матай 3:13–16 (Иохан Баптист, Есүст баптисм хүртээсэн нь), Хиламан 13:2–4; 16:1–3 (Лемен үндэстэн Самуел), болон Мормоны Номын Удиртгал (Иосеф Смит алтан хуудсуудыг орчуулсан нь) түүхүүдийг ашигла. Эдгээр түүхүүдийг товч, энгийнээр ярьж өг.

Таах тоглоом: Жаахан хүүхдүүд маш сониуч байдаг ба таныг дүрсүүдээ нууж байх үед нүдээ таглахгүй эсвэл буруу харж зогсохгүй байж магад. Тэд таныг дүрсүүдээ хаана нууж байгааг харах мөн хэлсэн үед тань гүйж очин олж авахдаа дуртай байх болно.



Иосеф Смит бидэнд судруудыг
уншихыг заасан.

Би бошиглогчийг дагах болно.

Лемен үндэстэн Самуел бидэнд
Тэнгэрлэг Эцэгийг дагахыг заасан.

Би бошиглогчийг дагах болно.

Иохан Баптист бидэнд баптисм
хийлгэ гэж заасан.

Би бошиглогчийг дагах болно.

Даниел бидэнд залбирах ёстой
хэмээн заасан.

Би бошиглогчийг дагах болно.

25 БИ ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМД ХАРЬЯАЛАГДДАГ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Есүс Христ дэлхий дээр байхдаа Өөрийн Сүмийг байгуулсан. Христийн цовдлуулалт болон Түүний дагалдагч нарыг нас барсны дараа сайн мэдээний бүрэн дүүрэн байдал алдагдаж үнэн Сүм дэлхийгээс авагдсан. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сайн мэдээний бүрэн дүүрэн байдал дахин сэргээгдсэн бөгөөд Есүс Христийн Сүм дэлхий дээр дахин бий болсон юм. (С ба Г 1:15–30; Иосеф Смит—Түүх 1:68–72-ыг үзнэ үү.)

БЭЛТГЭЛ

- Судраа авчир. С ба Г 115:4-ийг олоход хялбар болгож тэмдэглэ.
- Боломжтой бол Сүмийн одоогийн Ерөнхийлөгчийн зургийг авчир.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг 106-р хуудасны зургийг үзүүл. Энэ бол Есүс Христийн зураг мөн бид Түүний Сүмд харьяалагддаг гэж хүүхдүүдэд хэл. Зураг руу заагаад, "Энэ хэн бэ?" гэж асуу.

Хариулт: "Есүс Христ."

Судар Сүмийн нэрийг Есүс судруудад хэлж өгсөн хэмээн хүүхдүүдэд хэл. Судраа нээн С ба Г 115:4-ийг унш: "Учир нь эцсийн өдрүүдэд миний сүм ийн, бүр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэмээн нэрлэгдэх ёстой." Хүүхдүүдийг цөөн үгээр Сүмийн нэрийг өөртэйгөө хамт давтан хэлэхийг хүс.

Судраа дээш барь. Есүс биднийг мэдээсэй хэмээн хүсдэг зүйлсээ судруудад хэлсэн байдаг ба Есүс Христийн Сүмд бидэнд судрууд байдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг судар уншиж байгаа мэтээр гараа дэлгэхийг хүс. Тэднээс "Есүс Христийн Сүм" гэж хэлэхийг хүс.

Есүс Бошиглогчидтойгоо ярьдаг бөгөөд Есүс Христийн Сүмд бидэнд бошиглогчид байдаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс "Есүс Христийн Сүм" гэж хэлэхийг хүс. Сүмийн одоогийн Ерөнхийлөгчийн зургийг үзүүл. Тэр бол өнөө үеийн бошиглогч хэмээн тайлбарла. Түүний нэрийг өөртэйгөө хамт хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Дуу "Есүс Христийн Сүм" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл доорх үгсийг хэлэх үедээ өрөөгөө тойрон жагсаад алхахыг хүүхдүүдээс хүс:

Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг.
Би хэн гэдгээ мэднэ.
Би Бурханы төлөвлөгөөг мэднэ.
Би түүнийг итгэлтэйгээр дагана.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Зургууд: Зургийг ашиглан заахдаа юуны өмнө зурган дээр хэн, юу байгааг хүүхдүүдэд хэлж өг. Хүүхдүүдийн анхаарлыг татахын тулд зурган дээрх жижиг зүйлүүдийг заа. Тэгээд өөртэйгөө хамт нэг хоёр үгсийг давтан хэлэхийг хүс. Хүүхдүүд зураг руу харах үедээ эдгээр үгсийг сонсож мөн хэлбэл тэд сайн мэдээний үгсийг сурч эхэлдэг.

Хөдөлгөөн: Балчир насны хүүхдүүд их хөдөлгөөнтэй байдаг. Хүүхдүүдийн сонирхлыг татаж байхын тулд алга таших, жагсах, алхах гэх мэтийг оролцуулсан үйл ажиллагааг хий.

Дүгнэлт Бид Есүс Христийн үнэн Сүмд харьяалагддаг талаарх гэрчлэлээсээ товчхон хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Будах үйл ажиллагаа болон хослуулах тоглоомд:* 107-р хуудасны зургийг хүүхэд бүрт будуулахаар хувилуул. Жижиг хэрчсэн цаас эсвэл өөр төстэй зүйл хослуулах тоглоомонд хэрэглэхээр авчир; хүүхэд бүрт гурван тодруулагч байхаар бодон хүрэлцэх тооны тодруулагч авчир.

Будах 107-р хуудасны хувилбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж байх хооронд хичээл дээр заасан зарчмуудаа давт. Зургууд дээрх зүйлсийг нэг бүрчлэн заан юу будаж байгааг нь хүүхдүүдэд тайлбарла. Зургууд дээрх үгсийг тэдэнд уншиж өг.

Хослуулах тоглоом Хүүхэд бүрт гурван ширхэг цаас өг. 107-р хуудасны зургийг үзүүл. Есүсийн зураг руу заан "Энэ бол Есүс Христийн зураг"гэдгийг хэл. "Бид Түүний Сүмд харьяалагддаг" гэж хэл. Хүүхдүүд өөрсдөд нь байгаа Есүсийн зураг дээр нэг ширхэг цаас тавихыг тэднээс хүс.

Тэгээд бошиглогчийн зураг руу заан бичсэн үгсийг уншиж өг. Хүүхдүүдээр "бошиглогч" гэж хэлүүлээд нэг ширхэг цаас дээр нь тавихыг хүс. Судрын зураг дээр үүний адил давтан хий. Тэгээд хүүхдүүдийг өөртэйгөө хамт цөөн үгээр "Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг" гэж хэлэхийг хүс.

Дүгнэлт Судрууд болон бошиглогчдын талаар хүүхдүүдийн сурсан зүйлсийг давтахаар 23-р эсвэл 24-р хичээлийн үйл ажиллагаануудын нэгийг сонго. Эдгээр үйл ажиллагаануудыг хийсний дараа Есүс Христийн Сүмд бидэнд судрууд болон бошиглогчид байдаг гэдгийг хүүхдүүдэд сануул.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Будах: Хүүхэд бүр будах дуртай байдаггүй. Зарим нь цаасан дээрээ ганц хоёр зураас ч зурж магадгүй. Эдгээр хичээлүүдийн будах үйл ажиллагааны гол зорилго нь хүүхдүүдэд сурсан зүйлсээсээ гэртээ авч харихад оршино. Тэд зургаа сайн муу зурж будаж байгаа эсэх нь чухал биш.

Давтан хийх: Хүүхдүүд дахин давтан хийснээр сурч байдаг. Тэдний дуртай түүхүүд болон үйл ажиллагаануудаас дахин хий. Үүнийг зуушны үеэр эсвэл хүүхдүүд эцэг эхээ хүлээж байхад гэх мэт балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч хэсэгт хийж болно.



Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг



Есүс Христийн Сүмд
бошиглогчид байдаг.



Есүс Христийн Сүмд
судрууд байдаг.

26 БИ БАПТИСМ ХҮРТЭЖ МӨН ГИШҮҮНЭЭР БАТЛАГДАХ БОЛНО

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Есүс Христ "Эцэгийн өмнө . . . түүний зарлигуудыг дагахаар түүнд дуулгавартай байх болно" гэдгээ харуулахаар мөн бидэнд үлгэр жишээ үзүүлэхээр баптисм хийлгэсэн (2 Нифай 31:7, 9-ийг үзнэ үү; түүнчлэн Матай 3:13–17-г үзнэ үү). Бид баптисм хийлгэх үедээ Аврагчийг дагаж мөн Түүний зарлигуудад дуулгавартай байхад бэлэн байгаагаа харуулдаг. Есүсийг баптисм хүртсэний дараа, "Ариун Сүнс түүний дээр . . . бууж ирсэн бөлгөө" (2 Нифай 31:8). Бид баптисм хийлгэснийхээ дараа Ариун Сүнсний бэлгийг баталгааны ёслолоор дамжуулан хүлээн авдаг. Энэ нь хэрвээ бид зарлигуудыг сахих юм бол Ариун Сүнсийг байнгын хамтрагчаа байлгаж чадна гэсэн үг юм.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг Есүс Христийн баптисм хийлгэж байгаа зургийг үзүүл (110-р хуудас). Зурган дээр байгаа зүйлсийг заа (Есүс, ус, Иохан Баптист гэх мэт). Есүс, Тэнгэрлэг Эцэгт хайртай мөн Түүнийг дуулгавартай дагахыг хүссэн учраас баптисм хийлгэсэн гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт "Есүс", "баптисм хийлгэсэн" гэж хэлэхийг хүс.

Шүлэг "Баптисм" (*Хүүхдийн дууны ном*) дууны эхний бадгийг давтан хэлэх үедээ зурган дээрх зүйлс рүү заа. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт заахыг хүс.

Олон жилийн өмнө Есүс, Иохан Баптист дээр ирж, *(Есүс рүү, тэгээд Иохан руу заа)*
Иудейд
Иордан голын усанд
умбуулан, баптисм хүртсэн. *(ус руу заа)*

"Умбуулах" гэдэг нь Есүс баптисм хүртэхдээ бүх биеэрээ усан дор орох гэсэн үг юм гэдгийг тайлбарла.

Зураг Баптисм хийлгэж байгаа охины зургийг (110-р хуудас) үзүүлээд уг хоёр зураг дээрх адил зүйлүүдийг хэлж өг. Тэд найман нас хүрээд Есүсийн адил баптисм хийлгэж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Дөрөв дөрвөөр нь найман хуруугаа гозойлгон тоол. Дахин давтаад хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс. Баптисм хийлгэх нь Есүсийг дагах нэг арга зам юм; бид баптисм хийлгэснээр Тэнгэрлэг Эцэгт хайртайгаа мөн Түүнийг дуулгавартай дагахыг хүсч байгаагаа харуулдаг гэдгийг хэлж өг.

Зураг 111-р хуудасны зургийг үзүүл. Зураг нь юуны тухай болох талаар хүүхдүүдтэй ярилц. Баптисм хийлгэснийхээ дараа бид гишүүнээр батлагддаг. Хүүхдүүдийг "гишүүнээр батлагддаг" гэж хэлэхийг хүс. Энэ нь санваартан ах нар толгой дээр гар тавин бидэнд Ариун Сүнсний бэлэг өгдөг гэдгийг тэдэнд хэл.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Зургууд: Нэг хуудсан дээр хоёр зураг байгаа тохиолдолд нэг зургийг нь далдалснаар хүүхдүүдийг зөвхөн нэг зураг дээр л анхаарлаа төвлөрүүлэхэд нь тусалж чадна.

Жаахан хүүхдүүд: Хүүхдүүдийн зарим нь, ялангуяа бүр жаахан хүүхдүүд эдгээр хичээлүүдэд зааг даж байгаа зүйлсийн утгыг ойлгохгүй байж болно. Гэсэн ч тэд долоо хоног бүр ямар нэг зүйлийг сурч байгаа бөгөөд тэдэнд Сүнсийг мэдэрч мөн сайн мэдээтэй холбоотой үг хэллэгийг мэддэг болоход нь та нар тусалж чадна.

Дүгнэлт Хүүхдүүдээс цөөн үгээр “Би баптисм хийлгэж мөн гишүүнээр батлуулна” гэж хэлэхийг хүс. Баптисм хийлгэж гишүүнээр батлуулах үед танд ямар сэтгэгдэл төрж байсан талаараа хүүхдүүдэд товчхон хэлж өг.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Судрын үйл ажиллагаанд:* Мормоны Номоо авчирна уу. 3 Нифай 12:1-ийг олоход хялбар болгож тэмдэглэ.

Таах тоглоомонд: 111-р хуудасны зургийг хувилуулан, хүсвэл буд. Уг цаасыг дундуур нь нугалбал зургийн нэг тал дээр баптисмын, нөгөө дээр нь гишүүнээр батлуулж буй зураг харагдах болно.

Будах үйл ажиллагаанд: 111-р хуудасны зургийг хүүхэд бүрээр будуулахаар хувилуул.

Судар Есүс Христ биднийг баптисм хүртээсэй хэмээн хүсдэг гэж судруудад өгүүлсэн байдгийг хүүхдүүдэд хэл. Мормоны Номоос 3 Нифай 12:1-ийг нээн “Надад итгэж мөн баптисм хүрт гэж Есүс хэлсэн” хэмээн унш. Хүүхдүүдийг энэ шүлгийг, цөөн үгээр өөртэйгөө хамт давтан хэлэхийг хүс. Найман нас хүрээд баптисм хийлгэж болно гэдгийг тэдэнд сануул.

Таах тоглоом Баптисмын зургаа хүүхдүүдэд харуулаад бичсэн зүйлийг нь уншиж өгөн хүүхдүүдийг “баптисм хийлгэсэн” гэж хэлэхийг хүс. Хуудсаа эргүүлэн гишүүнээр батлуулж буйг харуулсан зургийн тухай ярилц.

Зургаа нурууныхаа ард нуу. Тэгээд хүүхдүүдэд зургийн нэг талыг үзүүлээд “Энэ хүү баптисм хийлгэж байна уу? эсвэл гишүүнээр батлуулж байна уу?” гэж асуу. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хариулахыг хүс. Хүүхдүүдийн сонирхол буураагүй байвал зургаа нурууныхаа ард нуун энэхүү үйл ажиллагааг давтан хий. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохиромжтой.

Будах 111-р хуудасны зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуул. Тэднийг будаж байх хооронд хичээл дээр заасан зарчмаа давтан хэлж өг. Зураг дээрх зүйлсийг заан бичсэн зүйлсийг хүүхдүүдэд уншиж өгч тэдний юу будаж байгааг тайлбарла.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хувилуулах нь: Хувилагч машин байхгүй тохиолдолд та зургуудын дээр цэвэр цаас тавин зургийг харандаа эсвэл тосон балаар давхарлан зурж хуулбарлаж болно. Зургийг бүхэлд нь хуулбарлах гэж санаа зовох хэрэггүй; дүрс танигдахуйц байхаар л зураасуудыг дагуулан зур.

Будах: [Хүүхдүүдийг] зургуудаа аав ээждээ үзүүлэхэд нь урамшуулан дэмж. Энэ нь тэднийг сурсан зүйлээ санахад туслах болно. Энэ нь эцэг эхчүүдэд сайн мэдээний зарчмыг хүүхдүүдтэйгээ ярилцах боломж өгдөг (*Teaching, No Greater Call,* 167).

Би баптисм хүртэнэ



Би гишүүнээр батлуулна

27 АРИУН ЁСЛОЛ НЬ ЕСҮС ХРИСТИЙН ТАЛААР БОДОХОД НАДАД ТУСАЛДАГ

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Загалмай дээр насан эцэслэхийнхээ өмнөх орой Есүс Христ Төлөөлөгчиддөө ариун ёслолыг хүртээсэн бөгөөд "Намайг дурсаж үүнийг үйлд" хэмээн хэлсэн (Лук 22:19–20-ийг үзнэ үү). Амилалтынхаа дараа, Тэр Нифайчуудын дунд мөн ийн үйлдсэн (3 Нифай 18:1–11-ийг үзнэ үү). Өнөөдөр ч бид Аврагчийн бидний төлөө хийсэн золиослолыг дурсан санаж, ариун ёслолоос хүртдэг. Бид Есүс Христийг үргэлж санан Түүний зарлигуудыг сахина гэдгээ Бурханд амладаг. (С ба Г 20:77, 79-ийг үзнэ үү.)

БЭЛТГЭЛ

- Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр ариун ёслолын хоосон тавгийг балчир хүүхдийн ангид авчир.
- Библийн судраа авчир. Лук 22:19-ийг олоход хялбар болгож тэмдэглэ. Түүнчлэн энэхүү гарын авлагын 106-р хуудсыг тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Дуу "Бишрэлтэй, даруухнаар" (*Хүүхдийн дууны ном*) дууны эхний мөрийг дуулах үедээ 106-р хуудасны Есүсийн зургийг үзүүл:

Даруухнаар, намуухнаар хайраар бид Таныг бодно. *(Есүсийн зураг руу заа)*

Хүндэтгэл бишрэлтэй уур амьсгалыг бий болгохоор хэд хэдэн удаа давтан хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт дуулахыг хүс.

Судар Ням гараг бүр Есүсийг дурсан санахаар нэгэн онцгой зүйлийг бид хийдэг бөгөөд ариун ёслолын цуглааны үеэр талхны жижиг өөдөс идэж, жижиг аягатай ус уудаг хэмээн хүүхдүүдэд хэлж өг. Энэ нь ариун ёслол гэж нэрлэгддэг гэдгийг тэдэнд хэл. Хүүхдүүдээс "ариун ёслол" гэж хэлэхийг хүс. Есүс, Өөрийг нь дурсан санахын тулд ариун ёслолоос хүртэхийг биднээс хүсдэг гэдгийг бид судруудаас сурдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Библийн судраас Лук 22:19 –ийг нээн "Намайг дурсаж үүнийг үйлд" гэж Есүс хэлсэн.

Зураг Ариун ёслолыг түгээж байгаа диконы зургийг үзүүл (114-р хуудас). Дикон, чимээгүй сууж байгаа хүмүүс гэх мэт зурган дээрх тодорхой зүйлсийг заа. Өөрийн авчирсан ариун ёслолын тавгаа хүүхдүүдээр бариулж, ариун ёслолыг хэрхэн түгээдэг тухай энгийнээр ярьж өг; ариун ёслолыг адислах үед бид чимээгүй сонсдог; бид нэг ширхэг талх авдаг; бид усыг нь уугаад аягыг нь буцаан тавьдаг; бид Есүсийн талаар боддог хэмээн тайлбарла.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах шүлэгт үйл ажиллагааг давтан хэлээд хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Би талхыг чимээгүй иднэ *(талх идэж байгаа дүр үзүүл)*

Хүндэтгэл бишрэлтэй байдал: Ариун ёслол нь ариун болохыг хүүхдүүдийг ойлгоход нь туслан намуухан дуугаар ярьж хүндэтгэл бишрэлтэй байдлыг харуул.

Барих зүйлс: Жаахан хүүхдүүд энгийнээр, үгчлэн боддог. Тэд хийсвэрлэн бодож чаддагүй. Хичээлтэй холбогдолтой зүйлсийг тэдний гарт бариулах нь сурахад тусалдаг. Тэд ариун ёслолын тавгийг хүндэтгэл, бишрэлтэйгээр барьж байгаад анхаарал тавиарай. Энэхүү үйл ажиллагаанд зориулж таваг дээр талх, ус тавих ёсгүй.

Мөн усыг ч бас ууна. *(ус ууж байгаа дүр үзүүл)*
Би гараа урдаа тэврэн Есүсийн талаар боддог— *(гараа цээжиндээ тэвэр)*
Би тийн үйлдэх ёстой. *(толгойгоо дээш доош дохино)*
[М.В.Вербика, "The Sacrament," *Friend,* 1995 оны 2 сар, 17]

Дүгнэлт 106-р хуудсан дээрх Есүсийн зургийг үзүүл. "Ариун ёслолыг хүртэх үедээ бид хэний тухай бодож байх ёстой вэ?" гэж хүүхдүүдээс асуу. Хүүхдүүдээс "Есүс" гэж хэлэхийг хүс.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Зочинтой үйл ажиллагааны:* Нэгэн Аароны санваартныг балчир хүүхдийн ангидаа урьж түүнийг ариун ёслол түгээхэд хэрхэн тусалдаг талаар ярилц.
Дүрд тоглох ба тоглоомонд: 115-р хуудасны зурагтай хэсгийг хувилуул. Хүсвэл зурагтай хэсгүүдийг будаад мөн хайчил.
Номонд: 115-р хуудасны зурагтай хэсгүүдийг хүүхэд бүрт зориулан хувилуулж мөн хайчил. Утас эсвэл ээрмэл утас авчир.

Зочин Хүүхдүүдэд зочноо танилцуул. Тэрээр санваартай гэдгийг тайлбарлаж өг. Түүнээс ариун ёслолыг хэрхэн бэлдэж, адисалж, түгээдэг талаар товчхон хэлж өгөхийг хүс. Ариун ёслолын талаарх сэтгэгдлээ хуваалцахыг түүнээс хүс.

Дүрд тоглох Өөрийн бэлдсэн зурагтай хэсгүүдийг нэг нэгээр нь дээш барь. Бичсэн зүйлийг нь уншиж өгөөд, зурган дээрхийн адил зүйл хийж байгаа дүр үзүүлэхийг хүүхдүүдээс хүс (зөвхөн эхний гурван жижиг хуудсанд). Жишээлбэл: тэднийг гараа тэврэн, толгойгоо бөхийлгөн талх, уснаас хүндэтгэл бишрэлтэйгээр хүртэж байгаа дүр үзүүлэхийг хүс. Хүүхдүүдээ хичээх бүрт нь магтаарай. Есүсийн зургийг дээш барин хүүхдүүдээс "Ариун ёслолоос хүртэх үедээ бид хэний тухай бодож байх ёстой вэ?" гэж асуу.

Тоглоом Өөрийн бэлтгэсэн зурагтай хэсгүүдээ шал эсвэл ширээн дээр зургийг нь доош харуулан тавь. Зурагтай хэсгүүдийн нэгийг эргүүлэн дээш харуулахыг хүүхдүүдийн нэгээс хүс. Зурагтай хэсэг дээр бичсэн зүйлийг унш. Ээлжлэхийг хүсч буй хүүхэд бүрт хийх боломж өг.



Ном Хүүхэд бүрт дөрвөн ширхэг урьдчилж бэлдсэн зурагтай хэсгүүдээ өгнө. Хэсэг бүрийн өнцөгт цоолж нүх гарга. Хүүхэд бүрт эдгээр хэсгүүдээ ном болгож өгөхийн тулд нүхээр нь утас сүвлэн утсыг нь зангид. Тэгээд уг номыг хүүхдүүдэд уншиж өг.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Залбирал: Хүүхдүүдэд залбирал хэрхэн хэлдгийг харуулахын тулд та өөрөө нээлтийн буюу хаалтын залбирлыг зарим үед хэлж болно. Тэд та нарын үлгэр жишээнээс бас тэдэнд хэлж өгч байгаа зүйлсээс сурч байдаг.

Хүндэтгэл бишрэлтэй байдал: Ариун ёслолын үеэр бид хэний тухай бодож байх ёстой талаар хүүхдүүдээс асуухад тэдний зарим нь хариулахдаа хашгиралдаж магад. Ийм тохиолдолд Есүс Христийн нэрийг хүндэтгэл бишрэлтэйгээр хэлэх ёстойг эвтэйхэн тайлбарла.

Үйл ажиллагааануудыг өөрсдийн хэрэгцээ болон сургалтын материалд үндэслэн өөрчилж болно. Жишээлбэл: энэхүү үйл ажиллагаанд хэрэглэх утас байхгүй тохиолдолд зурагтай хэсгүүдийг өөр аргаар багцалж болно. Эсвэл тэдгээр хэсгүүдийг номын хэлбэрээр биш хуудас хуудсаар нь хүүхдүүдэд өгч будуулж болно.



Ариун ёслолын залбирал
хэлэх үед би сонсож чадна.

Талхнаас хүртэх үедээ би
Есүсийн талаар бодож чадна.



Уснаас хүртэх үедээ би Есүсийн
талаар бодож чадна.

Ариун ёслол нь Есүсийн талаар
бодоход надад тусалдаг.

28 ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ САНВААРААР ДАМЖУУЛАН НАМАЙГ АДИСАЛДАГ

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Санваар гэдэг нь Бурханы эрх мэдэл ба хүч чадал юм. Бурхан энэхүү эрх мэдлийг Сүмийн арван хоёроос дээш насны, зохистой эрэгтэй гишүүдэд өгдөг ба тэд бусдыг Түүний нэрээр адисалдаг. Баптисм, гишүүний баталгаа, ариун ёслол гэх мэт сайн мэдээний ёслолууд санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг (С ба Г 13; 20:73–79; 84:19–22- ыг үзнэ үү). Сүмийн бүх гишүүд санваарын ач тусыг хүртдэг.

БЭЛТГЭЛ

Энэхүү гарын авлагын 26 болон 114-р хуудсуудыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Сургаалын заавар Санваар бол Бурханы хүч чадал; Бурхан санваарыг залуу эрэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд өгдөг бөгөөд тэгснээр тэд өөрсдийн гэр бүлийг болон бусдыг адисалдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдээр "санваар" гэж хэлүүл. (*Тайлбар:* Энэхүү хичээлийн туршид аавгүй эсвэл аав нь санваар хүртээгүй хүүхдүүд балчир хүүхдийн ангид байгаа тохиолдолд тэдгээрийн сэтгэл санааны байдалд мэдрэмжтэй ханд).

Зургууд 118-р хуудсан дээрх зургийг үзүүлээд хүүхдүүдийг нялх хүүхэд тэвэрч байгаа дүр үзүүлэхийг хүс. Санваар атгагч ах нар, нялх хүүхдүүдийг адисалж, нэр өгч болдог хэмээн тайлбарла. Хүүхдүүдийг "санваар" гэж хэлэхийг хүс.

Өвчтэй хүнийг адисалж байгаа 119-р хуудасны зургийг үзүүл. Санваар атгагч ах нар, өвчтэй хүмүүсийг эдгээхийн тулд адисалж болдог хэмээн хүүхдүүдэд хэлж өг. 26-р хуудасны зургийг харуул. Есүсийн зураг руу заан энэ зураг дээр Есүс, сохор хүнийг адисалж байгаа гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс "санваар" гэж хэлэхийг хүс.

114-р хуудасны зургийг үзүүл. Бид ариун ёслолоос ням гараг бүр хүртдэг гэдгийг хүүхдүүдэд сануул. Энэ нь санваарыг атгагч хүмүүсээр бэлтгэгдэж, адислагдаж мөн түүгээгддэг хэмээн тайлбарла. Хүүхдүүдээс "санваар" гэж хэлэхийг хүс.

Дуу "Хайр энд байна" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл доорх үгсийг давтан хэлэх үедээ гар гараасаа хөтлөөд тойрон алхахыг хүүхдүүдээс хүс:

Манай гэр санваарын хүч чадлаар цаг мөч тутамд адислагддаг.

Дүгнэлт Тэнгэрлэг Эцэг биднийг санваараар дамжуулан адисалдаг хэмээх гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Сургаалын заавар: Энэхүү хэсэг нь хүүхдүүдэд сайн мэдээний анхан шатны ойлголтыг олж авахад туслах зорилготой юм. Тэдний зарим нь хэлж ярьж байгаа бүхнийг тань ойлгохгүй байж магад ч сайн мэдээний үг хэллэгтэй танил болж, энэ нь хожим сурах зүйлсийнх нь үндэс суурь болно.

Жаахан хүүхдүүдийн хэл ярианы чадвар харилцан адилгүй байдаг (*Teaching, No Greater Call,* 110–111-ийг үзнэ үү). Жаахан хүүхдүүдийг хичээл дээр гарч байгаа үгсийг давтан хэлэхэд туслахын тулд намуун дуугаар "*Чи санваар гэж хэлж чадах уу?" гэж асууж болно.* Надтай хамт *санваар* хэмээн хэл" гэж хэлээд хариулахыг нь хүлээ. Хэрвээ үг хүүхэд хариулахгүй байвал дахин эелдгээр хүс. Энэ тохиолдолд хүүхэд хариулахыг хүсэхгүй байсан ч хүүхдийн хүссэнээр, зөнгөөр нь байлгаарай. Хүүхдүүд зөвхөн сонсож байсан ч хичээлээс сурч байдаг.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Зочинтой үйл ажиллагаанд:* Нялх хүүхдээ адислаад удаагүй байгаа нэг аавыг балчир хүүхдийн ангид ирж сэтгэгдлээсээ хуваалцахыг хүс.

Эвхдэг номонд: 119-р хуудасны зургийг хувилуул. Хүсвэл будаж болно. Шулуун зураасын дагуу хайчилж тасархай зураасын дагуу нугал.

Шүлэгт үйл ажиллагаа Дараах үйл ажиллагааны нэг хэсгийг эсвэл бүхэлд нь давтан хэлээд хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс. Бадаг бүрийн дараа бидний амьдралыг санваар адисалдаг болохыг хүүхдүүдэд сануул.

Нялх хүүхдийн адислал (118-р хуудасны зургийг үзүүл):

Аав нь нялх хүүхдээ *(гартаа нялх хүүхэд тэвэрч байгаа дүр үзүүл)*
зөөлнөөр тэвэрч
Санваарын хүчээр адисалж мөн нэрлэдэг.
Тэр гэр бүлдээ хайртай! *(өөрийгөө тэвэр)*

Өвчтөнийг адислах нь (119-р хуудасны зураг руу заа):

Би өвчтэй үедээ *(өөр рүүгээ заа)*
Шударга санваартан ахаас адислал авч чадна
Би амар амгаланг мэдэрнэ, *(гараа зүрхэн дээрээ тавь)*
Би эдгэрнэ гэдэгтээ итгэнэ.

Арцун ёслол (114-р хуудасны зургийг үзүүл):

Би талхыг чимээгүй иднэ *(талх идэж байгаа дүр үзүүл)*
Мөн усыг ч ууна. *(ус ууж байгаа дүр үзүүл)*
Би гараа урдаа аван Есүсийн талаар боддог— *(гараа цээжиндээ тэвэр)*
Би тийн үйлдэх ёстой. *(толгойгоо дээш доош дохино)*

[М.В.Вербика, "The Sacrament," *Friend,* 1995 оны 2 сар, 17]

Зочин Хүүхдүүдэд зочноо танилцуул. Тэр санваартай бөгөөд санваараа ашиглан нялх хүүхдээ адисалсан хэмээн тэдэнд тайлбарла. Уг ааваас "Та санваартай юу?" "Нялх хүүхдийг тань хэн гэдэг вэ?" "Нялх хүүхдээ адислахдаа та юу гэж хэлсэн бэ?" "Нялх хүүхэд тань өсч том болохоор түүнийг адислахдаа санваараа хэрхэн ашиглах вэ?" гэх мэт асуултуудыг асуу.

Эвхдэг ном Хүүхдүүдэд өөрийн бэлтгэсэн эвхдэг номоо үзүүл. Эхний хуудсыг өргөж бичсэн зүйлийг уншаад хүүхдүүдийг өөртэйгөө хамт хэлэхийг хүс. Хуудас бүр дээр ийн давтан хий.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Давтлага: Хүүхдүүд урьд өмнө нь сонсож, харж байсан үйл ажиллагаа, түүх, дуу, зургуудад дуртай байдаг. Энэхүү хичээл болон өмнөх хичээлүүд дээр сурсан дууг дуулах эсвэл үйл ажиллагааг балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед давтан хий. Ийн давтах нь та нарын заасан сайн мэдээний зарчмуудыг санахад нь тэдэнд тусална.



Нялх хүүхдийн
адислал

Өвчтэй хүнийг
адислах



Ариун ёслол

Тэнгэрлэг Эцэг санваараар дамжуулан намайг адисалдаг

29 ЕСҮС ХРИСТ АМИЛСАН (ХРИСТИЙН АМИЛАЛТЫН БАЯР)

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Адам, Ева хоёрын Уналтаас болж хүн бүр бие махбодын үхлийг туулах болно. Биднийг үхэх үед сүнс болон махбод маань тусгаарлагддаг. Есүс Христ амилсны дараа Түүний бие махбод болон сүнс ахиж хэзээ ч салахгүйгээр дахин нэгдсэн. Есүс Христийн Цагаатгалын улмаас хүн бүр амилуулагдах болно (1 Коринт 15:22; Алма 11:42–45-ыг үзнэ үү). Амилуулалтын талаар ойлгож мөн гэрчлэлтэй байх нь бидэнд баяр хөөр, найдварыг өгдөг (Исаиа 25:8; Алма 22:14-ийг үзнэ үү).

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Түүх 122-р хуудасны зургийг үзүүл. Есүс Христийн амилалтын түүхийг маш энгийнээр хэлж өгөх үедээ зураг дээрх зүйлүүд рүү заа (Иохан 19:41–42; 20:1, 11–16-г үзнэ үү). Доорх жишээг үзнэ үү:

Есүсийг нас барахад найзууд нь ихэд гуниглаж байсан *(гунигтай царай гаргахыг хүүхдүүдээс хүс)* Тэд Есүсийн биеийг хадан булшинд тавин *(зурган дээрх хадан булш руу заа)* үүдэнд нь бул чулуу өнхрүүлэн хаасан *(хүүхдүүдээр том, хүнд чулууг өнхрүүлж байгаа дүр үзүүл)* Гурван өдрийн дараа *(хүүхдүүдийг гурван хуруугаа гозойлгохыг хүс)* хоёр тэнгэр элч уг чулууг холдуулсан. Есүс амилсан байсан! *(Зураг дээр Есүсийг заа.)* Тэр амилсан *(хүүхдүүдийг "амилсан" гэж хэлэхэд тусал.)* Есүсийн найзууд маш их баяртай байсан! Тэр амьд мөн Тэр ахиж хэзээ ч үхэхгүй!
Есүсийн найзуудын нэг нь Мариа байсан *(зураг дээр Мариаг заа.)* Түүнийг нас барахад Мариа их гунигтай байсан. Есүсийг амилахад Түүнийг эхэлж харсан хүн нь Мариа байсан. Есүс амилсан учраас тэр баяр хөөртэй байсан *(хүүхдүүдийг баяртай царай гаргахыг хүс).*

Есүсийн тусламжтайгаар хүн бүр амилуулагдаж мөнхөд амьдрах болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдээс баяр хөөртэй царай гаргахыг хүс.

Дуу "Есүс үнэхээр амилсан уу" дууны эхний бадгийг дуул эсвэл унш. "Есүс үнэхээр амилсан уу" (*Хүүхдийн дууны ном*) дууны эхний бадгийг дуулж эсвэл үгсийг нь давтан доорх үйл хөдлөлийг хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Есүс үнэхээр амилсан уу?
Тийм, гурав дахь өдөр ирэхэд *(гурван хуруугаа гозойлго)*
Тэр босоод, булшийг орхин явж,
Тэр Мариаг дуудсан юм. *(гараа цээжиндээ тэвэр)*

Дүгнэлт Хүүхдүүдээс нэг хоёр үгээр "Есүс Христ амилсан" гэж хэлэхийг хүс. Есүс Христ амилсан гэсэн гэрчлэлээ хүүхдүүдтэй товчхон хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Есүс Христ: Зарим улсад Христийн амилалтын баярааар хүүхдүүдэд зориулсан зугаатай уламжлалууд байдаг ч тэдгээр нь Христийн амилуулалттай тэр бүр холбоотой байдаггүй. Христийн амилсан баярын энэхүү хичээлийг Аврагч дээр төвлөрүүлж, хүүхдүүдийн Түүнийг хайрлах хайрыг өсгөхөд нь тусал. Амилуулалт болон Түүний сургаал, төгс үлгэр жишээ гэх мэт Түүний бидэнд өгсөн гайхамшигт бэлгүүдэд баярлаж талархахыг тэдэнд заа.

Дуунууд: Зарим хүүхдүүд нь та нартай хамт дуулахгүй байж магад. Тэд зөвхөн үйл хөдлөл хийж эсвэл та нарыг ердөө харж, сонсоод сууж байсан ч тэд дуунуудыг дуртай сонсож, тэдгээрээс сурдаг.

Гэрчлэл: Гэрчлэлээ энгийнээр, товч тодорхой хуваалц; жишээлбэл: "Есүс Христ амилсан гэдгийг би мэднэ."

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Түүх:* 123-р хуудасны зургуудыг хувилуул. Хүсвэл тэдгээрийг будаад зузаан цаасан дээр наа. Дүрс бүрийг хайчлан авч мөн хадан булшны үүдний зургийг тасархай зураасын дагуу хайчилж гарга.

Будах үйл ажиллагаанд: 123-р хуудсыг хүүхэд бүрт зориулан хувилуул. Дүрс бүрийг хайчилж мөн хадан булшны үүдний зургийг хайчилж гарга.

Дуу Хүүхдүүдийг тойруулан зогсоож гар гараасаа хөтлөхийг хүс. "Есүс амилсан" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан доорх үйл хөдлөлийг хий:

Есүс амилсан, *(тойрч алх)*
Тэр бидний найз.
Тэр амилсанд
Бид баярлана. (*зогсоод зүрхэн дээрээ гараа тавина*)

Хүүхдүүдийн хүссэнээр хэд хэдэн удаа давтан хийж болно.

Түүх Есүс Христийн амилалтын түүхийг дахин хэлж өгөхдөө хайчилсан зургуудаа ашигла. Доорх жишээг үзнэ үү:

(Есүсийн зураг бүхий дүрсийг босоо байдалд байлган хадан булшны үүдээс чулууг холдуулсан байгаагаар эхэл.) Есүсийг нас барахад түүний биеийг хадан булшинд тавьсан *(Есүсийн зураг бүхий дүрсийг хадан агуйд [цаана нь] байрлуул.)* Нэгэн бул чулууг хаалганы өмнө тавьсан *(хадан булшны үүдэнд чулууг өнхрүүлж тавь.)* Гурав дахь өдөр нь хоёр тэнгэр элч ирж чулууг холдуулсан *(үүднээс чулууг өнхрүүлэн холдуул)* Есүс амилсан *(Есүсийн зураг бүхий дүрсийг босоо байлгана).* Түүний сүнс болон бие махбод дахин нэгдсэн! [Сюзан Пэйсон, "Easter Story," *Friend,* 1995 оны 4 сар, 32–33.]

Будах Хүүхдүүдэд хайчилсан зургаа өг. Тэдгээр зургуудыг ашиглан Есүсийн амилалтын түүхийг хэрхэн давтаж болохыг тэдэнд үзүүл. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохиромжтой.



ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Нэмэлт үйл ажиллагаанууд нь хүсвэл хичээлдээ нэмэлт болгон ашиглахаар өгөгдсөн болно. Шаардлагатай зүйлс нь олдохгүй тохиолдолд ижил төстэй зүйлсээр орлуулж болно.

Түүхүүд: "Жаахан хүүхдүүд түүхийг дахин дахин сонсох дуртай байдаг. Ямар нэгэн түүхийг давтан ярих тохиолдолд эхлэл хэсгийг хэлж өгөн "Дараа нь юу болдог вэ?" гэж асуу (*Teaching, No Greater Call,* 181–182). Балчир хүүхдийн ангийнхаа том хүүхдүүдийн нэгээс 122-р хуудасны зургийг эсвэл дүрсүүдийг ашиглан амилуулалтын түүхийг жаахан хүүхдүүдэд ярьж өгөхийг хүс. Шаардлагатай бол тусалж болно.

Үйл ажиллагааны хайрцаг: Балчир хүүхдийн ангид хадгалах үйл ажиллагааны хайрцаг хийх талаар бодож үзээрэй. Үүнд энэхүү будах үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаануудад зориулан хийж ашигласан зүйлсийг хийж болно. Тэгээд өмнөх хичээлүүдийг давтахын тулд тэдгээр үйл ажиллагаануудыг балчир хүүхдийн ангийн дараагийн хичээлүүдэд ашиглаж болно. Балчир хүүхдийн ангийн хичээлийн аль ч үед энэ давтлагыг хийж болно.



30 ЕСҮС ХРИСТ БОЛ ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГИЙН ХҮҮ (ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯР)

БАГШИД ЗОРИУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээлийг заахад өөрийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд дараах зүйлсийг уншиж мөн тунгаан бод:

Есүс Христ зуурдын ээж болох Мариагаас болон үхэшгүй эцэг болох Тэнгэрлэг Эцэгээс төрсөн юм. Тэр бол Бурханы Хүү. Тэнгэрлэг Эцэг биднийг агуу ихээр хайрладаг учраас Тэрээр Есүс Христийг, бидний Аврагч, Жишээ Үзүүлэгч байхаар дэлхий рүү илгээсэн. "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм" (Иохан 3:16).

БЭЛТГЭЛ

Энэхүү гарын авлагын 106-р хуудсыг олоход хялбар болгож тэмдэглэ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цугларах үйл ажиллагаагаар эхэл. Санаа авахын тулд 3-р хуудсыг үзнэ үү.

Залбирал Нээлтийн залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

Зураг 126-р хуудасны зургийг үзүүл. Зураг дээрээс нялх хүүхдийг олохыг хүүхдүүдээс хүс. Түүний нэр бол Есүс гэдгийг хэлээд тэднээс "Есүс" гэж хэлэхийг хүс. Хүүхдүүдээс гартаа нялх хүүхэд тэвэрч байгаа дүр үзүүлэхийг хүс.

Зураг дээр Мариа рүү заан хүүхдүүдэд, "Энэ бол Есүсийн ээж. Түүний нэрийг Мариа гэдэг" хэмээн хэлж өг.

Есүс бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдээс "Есүс бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү юм" гэсэн өгүүлбэрийг хэд хэдэн үгээр нь тасалж хэлэхийг хүс. Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай учраас Өөрийн Хүү Есүс Христийг дэлхий рүү илгээсэн гэдгийг тэдэнд хэл.

Дуу Зураг дээрх нялх Есүс рүү дахин заа. Хүүхдүүдэд та нар дуу дуулах гэж байгаагаа хэл. Таныг нялх Есүсийн зураг руу заах үед тэднээс "Тэр Хүүгээ илгээсэн" гэж хэлэхийг хүс. Тэд хэд хэдэн удаа давтуулаад "Тэр Хүүгээ илгээсэн" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл доорх үгсийг давтан хэл:

Эцэг өөрийн хайр, энэрлийг дэлхийнхэнд хэрхэн илэрхийлэх вэ?
Тэр Хүүгээ, *(нялх Есүсийн зураг руу заа)* ариун амгалан нялх үрээ илгээсэн.

106-р хуудсан дээрх Есүс Христийн зургийг үзүүл. Нялх Есүс өсч том болоод бидний Аврагч, Есүс Христ болсон хэмээн хүүхдүүдэд хэлж өг. Аврагчийн зураг руу заах үедээ хүүхдүүдээс "Тэр Хүүгээ илгээсэн" гэж хэлэхийг хүс. "Тэр Хүүгээ илгээсэн" хэмээх дууг дуулж эсвэл доорх үгсийг давтан хэл:

Эцэг дэлхийнхэнд бидний явах ёстой замыг хэрхэн үзүүлэх вэ?
Тэр Хүүгээ *(Аврагчийн зураг руу заа)* бид мэдэж болохын тулд дэлхий дээр хүмүүнтэй хамт алхуулахаар илгээсэн.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Есүс Христ: "Бидний заадаг бүх зүйл нь гэр бүлийн болон ангийн гишүүдийг Христ рүү чиглүүлэх ёстой. . . . Хичээлдээ бэлдэж мөн зааж байхдаа үүнийг санаарай" (*Teaching, No Greater Call,* 80).

Жаахан хүүхдүүд: Хүүхдүүд анхаарлаа төвлөрүүлж чадаж байгаа эсэхийг ажигла. Тэднийг анхааралтай байлгах зорилгоор заахдаа дуу хоолойныхоо өнгийг өөрчлөх, нүднийхээ харцаар илэрхийлэх зэргээр төрөл бүрийн заах аргуудыг ашигла. *Teaching, No Greater Call,* 71–72-ыг үзнэ үү.

Дүгнэлт Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг илгээсэнд талархаж байдгаа илэрхийл. Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэсэн гэрчлэлээ хуваалц.

Залбирал Хаалтын залбирал хэлэхийг нэг хүүхдээс хүс.

НЭМЭЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

БЭЛТГЭЛ *Сааванд тогтоосон цаасан хүүхэлдэй:* 127-р хуудасны зургийг хүүхэд бүрт зориулан хувилуулж мөн хайчил. Хүүхдүүдэд сааванд тогтоосон цаасан хүүхэлдэй хийж өгөхийн тулд зураг бүрийн ар талд саваагаа цавуудаж эсвэл наадаг цаасаар тогтоо.

Судрын үйл ажиллагаанд: Мормоны Номоо авчир. 3 Нифай 9:15-ыг олоход хялбар болгож тэмдэглэ.

Саваан дээрх цаасан хүүхэлдэй Хүүхдүүдэд саваан дээр тогтоосон цаасан хүүхэлдэйнүүдээ өг. Есүс Христийн мэндэлсэн түүхийг өөрийн үгээр товчхон дахин ярьж өг (Лук 2:4–16-г үзнэ үү). Уг түүхийг ярих үед үйл явдалтай холбоотой зургаа өргөж харуулахыг хүүхдүүдээс хүс. Энэхүү үйл ажиллагаа нь том хүүхдүүдэд илүү тохиромжтой.

Дуу "Малын хашаанд" (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл доорх үгсийг давтан үгсийн утгын дагуу үйл хөдлөл хий. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс.

Малын тэвшнээс өөр унтах газаргүй
Бяцхан Эзэн Есүс нүдээ аньж хэвтэнэ;
Тэнгэр дэх одод түүний дээрээс гийгүүлж,
Бяцхан Эзэн Есүс өвсөн дээр нойрсоно.

Шүлэгт үйл ажиллагаа Доорх шүлэгт үйл ажиллагааг давтан хийж хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Тэвшин дэх хүү, *(хүүхэд бүгвэйлж буй мэт гараа хөдөлгө)*
Хайрт ээж нь дэргэд нь,
Тэнгэрт одод гялалзана, *(тэнгэр рүү заа)*
Бурханы Хүү ирлээ! *(гараа тэвэр)*

Судар Есүс судруудад, Тэр бол Бурхан, Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэж өөрийгөө хэлсэн байдаг хэмээн хүүхдүүдэд хэл. Мормоны Номоос 3 Нифай 9:15-ыг нээн "Болгоогтун, би бол Бурханы Хүү Есүс Христ бөлгөө" хэмээн унш. Хүүхдүүдийг өөртэйгөө хамт "Бурханы Хүү" гэж хэлэхийг хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Сургалтын материал: Балчир хүүхдийн ангид зөвхөн Сүмээс хэвлэн гаргасан материалуудыг ашиглана. Хүүхдүүдээр хийлгэх нэмэлт үйл ажиллагаа шаардлагатай тохиолдолд энэхүү гарын авлагаас өмнөх хичээлүүддээ ашиглаж байсан түүх, тоглоом, хүүхэлдэй, бусад үйл ажиллагааг сонгож болно. Сүмийн сэтгүүлүүдээс тоглоом, түүх ашиглаж бас болно.

Давтан хийх: Христийн мэндэлсний баярын үеэр энэхүү хичээлийг бүхэлд нь эсвэл хэсгийг нь хэд хэдэн удаа давтан заа. Христийн мэндэлсэн түүхийг хүүхдүүд дахин дахин сонсох дуртай байдаг.

Есүс Христ бол Тэнгэрлэг
Эцэгийн Хүү



Есүс Христ бол Тэнгэрлэг
Эцэгийн Хүү

БОГИНО ХИЧЭЭЛ: БАЛЧИР ХҮҮХДИЙН АНГИД ТАВТАЙ МОРИЛНО УУ

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тавтай морилно уу Балчир хүүхдийн ангид хүүхэд анх удаа ирэх үед хүүхдүүдийн цуглараах мөчийг сонгон (хичээл, зууш эсвэл дууны цаг гэх мэт) шинээр ирсэн хүүхдийн нэрийг хэлж танилцуул. Шинээр ирсэн хүүхдэд балчир хүүхдийн ангид ирсэнд нь их баяртай байгаагаа хэл.

Дуу Нэгэн онцгой дууг дуулахыг хүсч буйгаа хүүхдүүдэд хэл. “Сайн уу” (*Хүүхдийн дуу,*) дууг дуулж эсвэл үгсийг нь давтан өөрийгөө тэдэн рүү заах үед тэднээс “сайн уу” гэж хэлэхийг хүс. Дуулахынхаа өмнө хэд хэдэн удаа давтан хийхийг хүсч болох юм.

Сайн уу! *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)* Сайн уу! *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)*
Чи тавтай морилно уу. *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)*
Сайн уу! *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)* Сайн уу! *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)*
Чи ирсэнд баярлалаа
Бидэнтэй хамт байхаар ирсэн үү
Бас бидний сайн найз болохоор ирсэн үү.
Сайн уу! *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)* Сайн уу! *(хүүхдүүд рүү заа: “Сайн уу!”)*
Чи тавтай морилно уу.

Дүгнэлт Шинээр ирсэн хүүхдэд хандан, “[Хүүхдийн нэр], чамайг өнөөдөр манай балчир хүүхдийн ангид ирсэнд бид маш их баяртай байна!” гэж хэл.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүүхэд анх удаа балчир хүүхдийн ангид ирэхдээ дуртай эсвэл айж магад. Тэвчээртэй хандаж, хайрласнаар уг хүүхдийг балчир хүүхдийн ангид анх удаа ирээд, сэтгэл хангалуун байхад нь та тусалж чадна. Хүүхдүүд юу болохыг урьдчилан мэдэж байхдаа илүү дуртай байдаг. Балчир хүүхдийн ангийн хичээлийг аль болох тогтмол хуваариар явуул. Шинээр ирсэн хүүхдүүдэд та нарыг, бусад хүүхдүүдийг мөн орчин нөхцлийг таньж мэдэх хугацаа өгөөрэй.

Хэрвээ хүүхэд ангиас гарч аав ээжтэйгээ байхыг хүсч байвал эцэг эхэд энэ нь хэвийн асуудал гэдгийг ойлгуул. Хүүхдийн аав ээжээс нь тухайн долоо хоногийн туршид балчир хүүхдийн ангийн талаар эерэг зүйлс хүүхдүүддээ хэлж өгөхийг хүс.

БОГИНО ХИЧЭЭЛ: ТӨРСӨН ӨДРИЙН МЭНД

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа Хүүхдийн төрсөн өдөр нь дөхсөн ням гарагт хүүхдүүдийг хичээл, зууш эсвэл дууны цагаар цугларах үед хүүхдүүдэд “[хүүхдийн нэр] –ийн төрсөн өдөр нь болсон [эсвэл болох гэж байгаа]!” гэж хэлнэ. Хүүхдүүдээс “Төрсөн өдрийн мэнд хүргэе” гэж хэлэхийг хүс.

Уг хүүхэд төрсөн өдрөөрөө хэдэн нас хүрч байгааг хүүхдүүдэд хэлж өг. Насны тоо хүртэл нь хуруугаараа тоолохыг хүүхдүүдээс хүс. Хэд хэдэн удаа давтан хий.

Дуу “Төрсөн өдрийн мэнд хүргэе” (*Хүүхдийн дууны ном*) дууг дуулж эсвэл үгсийг давтан хэлээд хүүхдүүдийг өөртэйгөө хамт хийхийг хүс:

Төрсөн өдрийн мэнд хүргэе найз [хүүхдийн нэр] минь.
Өдөр бүр жаргалтай байгаарай.
Төрсөн өдрийн баярын мэнд хүргэе!
Аз жаргал баяр хөөрийг бид хүсэж байна.

Хүүхдүүдийг “Төрсөн өдрийн мэнд хүргэе” гэж хэлээд алгаа ташихыг хүс.

ЗААХАД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүүхдүүд өөрсдийн нэрийг сонсох дуртай байдаг. Хүүхдүүдэд та нарын өгөх хамгийн агуу бэлэг бол тэднийг хайрлаж, таньж мөн чухалчлах явдал юм. Балчир хүүхдийн ангид тэдний төрсөн өдөрт зориулж ямар нэгэн бэлэг бүү өгөөрэй. Хүүхдийн төрсөн өдрийг тэмдэглэхдээ бэлэг өгөхдөө биш харин хүүхдэд онцгой анхаарал тавих нь чухал юм.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИНДЕКС

Бугуйвч 69, 74
Гинж 53, 55
Дуунууд
- "Аз жаргалтай гэр бүл" 36, 48
- "Баптисм" 108
- "Би Аврагчийн хайрыг мэдэрдэг" 20-21
- "Би Ариун сүм харах дуртай" 56
- "Би Бурханы хүүхэд" 8, 12-13, 40
- "Би даруу байхыг хичээнэ" 84
- "Би дуулгавартай дагана" 60
- "Би Есүс шиг байхыг хичээнэ" 24, 68, 72
- "Бишрэлтэй, даруухнаар" 36, 112
- "Бошиглогчийг дага" 101
- "Гэр бүлийн залбирал" 52
- "Гэр бүлүүд үүрд хамт байх болно" 56
- "Есүс Христийн Сүм" 104
- "Есүс амилсан" 121
- "Есүс бүгдийг хайрла гэсэн" 25, 76
- "Есүс үнэхээр амилсан уу" 120
- "Инээмсэглээрэй" 80
- "Малын хашаанд" 125
- "Сайн уу" 128
- "Сайхан дэлхий" 33
- "Толгой, мөр, өвдөг, хөл" 41
- "Төрсөн өдрийн мэнд хүргэе" 129
- "Тэр хүүгээ илгээсэн" 124
- "Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг" 32
- "Тэнгэрлэг Эцэгтээ талархья" 64-65
- "Хайр энд байна" 116
- "Хаврын нэгэн сайхан өдөр" 88
- "Хөгжилтэй" 36, 49, 73
- "Хэрвээ сайхан амьдарч байвал" 81
- "Цасан хүн" 44
- "Эрэлхийлж, эргэцүүлэн бодож, залбир" 92, 96-97
- "Эцэг минь амьдыг би мэднэ" 28

Дүрс 48, 51, 101, 103
Дүрд тоглох 28, 44, 48, 61, 76, 100, 113
Зочин 113, 117
Номууд 33, 35, 37, 39, 93, 95, 113, 115 (*түүнчлэн эвхдэг номыг* үзнэ үү)
Өлгөдөг тоглоом 13,15
Судрууд 25, 29, 37, 52, 77, 104, 109, 112, 125
Таах тоглоом 45, 57, 59, 69, 71, 101, 103, 109, 111
Толь 21
Түүхүүд
- Ариун Сүнсээр тайвширсан хүү 28
- Гэр бүл өвдсөн хүүхдийнхээ төлөө залбирсан нь 53
- Есүс амилсан нь 120, 121
- Есүс арван уяман өвчтэй хүнийг эдгээсэн нь 64
- Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь 24
- Есүс хүмүүсийг тэжээсэн нь 24
- Есүс хүүхдүүдийг адисалсан нь 20, 24, 96
- Есүс ээжийнхээ хамт 49
- Инос залбирсан нь 17
- Иосеф Смитийн анхны үзэгдэл 40, 88
- Нифай хөлөг онгоц барьсан нь 68, 96
- Охин инээмсэглэсэн нь 80
- Сайн Самари хүн 76
- Хүүхдүүд "Намайг уучлаарай" гэж хэлэх 69

Бошиглогчийг дага 100
Ууттай тоглоом 13, 37, 53, 93
Үр 33
Хослуулах тоглоом 65, 67, 105, 107
Хуулах 41
Хүзүүний зүүлт 21, 23, 57, 59, 69, 71
Хүүхэлдэй 61, 63, 97, 99, 125, 127 (түүнчлэн *цаасан хүүхэлдэйг* үзнэ үү)
Цаасан самбар 9, 49
Цаасан хүүхэлдэй 41, 53, 57, 59, 89, 91
Шоо 29, 31, 73,75
Шүлгүүд (шүлэгт үйл ажиллагааг үзнэ үү)
Шүлэгт үйл ажиллагаа (эхний мөрүүд)
- "Аав нь нялх хүүхдээ тэвэрч буй нь" 117
- "Ариун Сүнс намуухнаар ярьдаг" 29
- "Би Есүсийг дагахыг хүсдэг" 73
- "Би онцгой биетэй" 40
- "Би өвчтэй үедээ" 117
- "Би талхыг чимээгүй иднэ" 112, 117
- "Инээмсэглэлийг хараад инээмсэглэх нь амархан" 81
- "Иосеф ойд өвдөглөн суусан" 89
- "Мормоны Номыг унш" 93
- "Надад судруудыг заагааач" 97
- "Нүдэндээ хүр, хамраа дар" 65
- "Тэвшин дэх хүү" 125
- "Тэнгэрлэг Эцэг намайг мэддэг" 20
- "Тэдгээрийг нээ, хаа" 85
- "Хайрт Тэнгэрлэг Эцэг минь" гэж хэлснээр би эхэлдэг 16
- "Хэрвээ чи зөндөө, зөндөө өндөр бол" 9
- "Энэ бол миний ээж, тэр надад тоглоход тусалдаг" 52
- "Энэ бол ээж" 56
- "Энэ жаахан хүүхэд орондоо орох гэж байна" 45

Эвлүүлдэг зураг 25
Эвхдэг ном 17, 19, 85, 87, 117, 119

ҮЗҮҮЛЭНГИЙН ИНДЕКС

Адам ба Ева 99
Амьтад 35
Анхны үзэгдэл 42, 90, 91
Ариун ёслол 114, 115, 119
Ариун сүм 58, 59
Баптисм 110, 111
Баталгаа 111
Бие махбод 43, 47
Будгийн харандаа 75
Бүтээлүүд 34, 35
Гэр бүлүүд 14, 15, 18, 31, 38, 39, 46, 50, 51, 54, 55, 59, 62, 67
Гэр орон 55, 67
Даниел арслангийн үүрэнд 103
Дэлхийн өмнөх амьдрал 15
Есүс Христ 19, 39, 106, 107, 115 (түүнчлэн *Анхны үзэгдлийг* үзнэ үү)
- амилалт 122, 123
- баптисм 110
- таван мянгыг тэжээсэн нь 27
- төрөлт 95, 126, 127
- хүүхэд байхдаа 18
- хүүхдүүдтэй хамт 15, 22, 95, 98
- эдгээх 26, 66, 94, 95

Залбирал 18, 30, 54, 87
Иохан Баптист 103, 110
Иосеф Смит 102, 103, 107 (түүнчлэн *Анхны үзэгдлийг* үзнэ үү)
Инээсэн – гуньсан царай 83
Лемен үндэстэн Самуел 103
Мосе 99
Нифай 70
Ноа 99
Номууд 75
Нялх хүүхдийн адислал 118,119
Сайн Самари хүн 78
Санваар 118, 119
Судрууд 31, 39, 95, 107
Сүмийн байр 31, 39
Тоглоомууд 74, 75
Хуваалцах 74
Хоньчид 127
Хоол хүнс 19, 47, 55, 67, 75
Хувцас 55, 67
Хүндэтгэл бишрэл 86 (түүнчлэн *залбирлыг* үзнэ үү)
Өвчтөнийг адислах 119 (түүнчлэн Есүс Христ, эдгээлтийг үзнэ үү)

ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮЗҮҮЛЭНГҮҮД

Intellectual Reserve, Inc. нь энэхүү гарын авлагын зураг, фото зургууд болон өөр дүрслэлүүдийн эрх хамгаалагдсан ба үүнд дараах зургууд хамаарагдахгүй:

Нүүр хавтас болон хуудас 22: *Christ and the Book of Mormon Children,* by Del Parson. © 1995 Del Parson.

Хуудас 5: Зураг © 2000 Steve Bunderson.

Хуудас 8: Зураг © Rubberball Productions.

Хуудас 18: *In Favor with God,* by Simon Dewey. © 2001 Simon Dewey. Хувилж олшруулахыг хориглоно

Хуудас 24 ба 98: *Storytime in Galilee,* by Del Parson. © 1990 Del Parson.

Хуудас 28: Зураг © 1998 Robert Casey.

Хуудас 32: Зураг © Corbis Images.

Хуудас 42: *The First Vision,* by Gary Kapp. © 1998 Gary Kapp. Хувилж олшруулахыг хориглоно.

Хуудас 48: Зураг © 2000 Steve Bunderson.

Хуудас 54: Зураг © 2006 Hyun-Gyu Lee.

Хуудас 56: Зураг © 2006 Frank Helmrich.

Хуудас 66: *The Leper Who Said "Thank You,"* by John Steel. © ProvidenceCollection.com. Бүх эрх хамгаалагдсан.

Хуудас 88: *Joseph Smith's First Vision,* by Greg K. Olsen. © 1988 Greg K. Olsen.

Хуудас 90: *The Desires of My Heart,* by Walter Rane. © 2004 Walter Rane, Сүмийн Түүх, Урлагийн Музейн зөвшөөрлөөр.

Хуудас 94: *And He Healed Them Every One,* by Gary Kapp. © 1993 Gary Kapp.

Хуудас 102: *Brother Joseph,* by David Lindsley. © 1998 David Lindsley.

Хуудас 106: Detail from *Christ and the Rich Young Ruler,* by Heinrich Hofmann. C. Harrison Conroy Co., Inc-ийн зөвшөөрлөөр нийтлэв.

Хуудас 110: *John the Baptist Baptizing Jesus,* by Greg K. Olsen. © 1988 Greg K. Olsen.

Хуудас 120: *He Is Risen,* by Del Parson © 1996 Del Parson

Хуудас 124: *For unto Us a Child Is Born,* by Lynne Millman Weidinger. © 2002 Lynne Millman Weidinger, Сүмийн Түүх, Урлагийн Музейн зөвшөөрлөөр.

Хуудас 126: *Mary and the Christ Child,* by Robert T. Barrett. © 1993 Robert T. Barrett. Хувилж олшруулахыг хориглоно

Хуудас 128: Зураг © 1999 Bryant Livingston

“Бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно” (3 Нифай 22:13).

“Мөн [Есүс] олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв. “Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг үзэв, мөн тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; мөн тэд доош ирж, багачуудыг эргэн тойрон хүрээлж, мөн тэд галаар эргэн тойрондоо хүрээлэгдсэн байв; мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулав” (3 Нифай 17:21–24).

Ахлагч М.Рассел Баллард “Эрхэм үнэт хүүхдүүдтэй ажиллах бидэнд ариун, уужим сэтгэлтэй үйлчлэгч байх үүрэг хариуцлага оногдуулсан нь ойлгомжтой. Бурхан өнөөгийн хүүхдүүдийг хайраар, итгэлийн гал дөлөөр, тэд хэн бэ гэдгээ мэдэх ойлголтоор дүүрэн байлгахын тулд биднийг томилсон юм” (“Great Shall Be the Peace of Thy Children,” Ensign, 1994 оны 4-р сар, 60) гэж заажээ.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN
4 02371 08363 5
37108 363